



ОРГАНИК ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬ

Хэрэгжилтийн үр
дагаварт хийсэн
үнэлгээний тайлан

2022 он

ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГА



НҮБ-ЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГА

ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.БАРИАШИРСҮРЭН – хуульч, судлаач

2022 он

АГУУЛГА

УДИРТГАЛ	3
НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	6
1.1. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үндэслэл, шаардлага.....	6
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	6
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгох, шалгуур үзүүлэлтийг томъёолох	7
1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлт.....	7
1.3.2. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.....	7
1.4. Үнэлгээний арга зүй	7
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	8
2.1. ЗОРИЛГОД ХҮРЭХ ТҮВШИН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ.....	10
ХУУЛИЙН ЗОРИЛГО	10
2.1.1. Хуулийн 1 дүгээр зүйлийг “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	11
БАТАЛГААЖУУЛАЛТ - БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ - ЭРХ, ҮҮРЭГ	24
2.1.2. Хуулийн 10 дугаар зүйлийг “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	37
ОРГАНИК ҮЙЛДВЭРЛЭЛ, ОРГАНИК ХҮНСЭНД ТАВИХ ХЯНАЛТ, ШОШГЫН ХЭРЭГЛЭЭ.....	51
2.1.3. Хуулийн 12 дугаар зүйлийг “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	51
ОРГАНИК ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭ, ШОШГО	61
2.1.4. Хуулийн 11 дүгээр зүйлийг “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	61
ХАРИУЦЛАГА.....	70
2.1.5. Хуулийн 13 дугаар зүйлийг “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	70
ГУРАВ. ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА	74
ЕВРОПЫН ХОЛБОО.....	74
БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС.....	81
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС	87
АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС.....	92
ЯПОН УЛС	94
ТАВ. ДҮГНЭЛТ.....	97
ЗУРГАА. САНАЛ, ЗӨВЛӨМЖ	110
ДОЛОО. ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	114

УДИРТГАЛ

Аливаа улсын хувьд хүн амаа эрүүл, аюулгүй, баталгаат хүнсээр хангах асуудал үндэсний аюулгүй байдлын чухал хэсгийн нэг бөгөөд төрөөс баримталж буй хүнсний салбарын бодлого, арга хэмжээнээс эхлээд түүний хэрэгжилтийг үр дүнтэй байлгахад чиглэсэн хүнсний сүлжээний бүх үе шатанд тавигдах шаардлага, хяналт шалгалтын үр дүн хүнсний аюулгүй байдлын баталгаа болохын сацуу эцсийн үр дүн нь хэрэглэгч төдийгүй, нийгмийн эрүүл мэнд, эдийн засагт нөлөөлөх өргөн хүрээний асуудал юм. Сүүлийн жилүүдэд олон улсын түвшинд хүнс үйлдвэрлэлийн чиг хандлагад өөрчлөлт орж байгаль орчин, хүний эрүүл мэндэд ээлтэй ХАА-н органик үйлдвэрлэл, органик бүтээгдэхүүнийг дэмжиж байна.

Манай улсын хувьд хүн амыг эрүүл, аюулгүй, баталгаат хүнсээр хангах асуудал Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 1 дүгээр заалтад “хүн амьд явах эрхтэй...” гэсэн суурь зарчимд хамаарах ба хүнсний аюулгүй байдлын бодлого, эрх зүйн орчин нь Үндсэн хуулиар баталгаажсан дээрх суурь зарчмаас гадна Монгол Улсын нэгдэн орсон Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа, салбарын харилцааг зохицуулж буй бодлого, хөтөлбөрөөс бүрдэж байна.

Эрүүл, аюулгүй, баталгаат хүнсний бүтээгдэхүүний нэг хэсэг болох ХАА-н органик үйлдвэрлэл, органик хүнс үйлдвэрлэх асуудалд бид сүүлийн 10 гаруй жил анхаарал хандуулж байгаа ба гол төлөв олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй хүнс, ХАА-н төсөл, хөтөлбөрийн хүрээнд органик үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр ажиллаж иржээ. Үүний үр дүнд 2016 онд бие даасан Органик хүнсний тухай хуулийг баталж эрх зүйн орчныг бий болгосон боловч органик үйлдвэрлэл эрхлэгч болон органик хүнсний бүтээгдэхүүний тоо, хэмжээ төдийлөн өсөхгүй байгаа нь төрөөс хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөр, тэдгээрийн санхүүжилт, органик үйлдвэрлэл эрхлэгчдэд ирэх үр шим тодорхойгүй, зах зээл бага, органик бүтээгдэхүүнийг сурталчлах, хуурамч бүтээгдэхүүнээс хамгаалах асуудалд орхигдсон зэрэг асуудалтай холбоотой байна.

ХАА-н органик хүнс үйлдвэрлэлийг дэмжих талаарх эрх зүйн орчныг бүрдүүлж буй хууль тогтоомжуудад Органик хүнсний тухай хуулиас гадна Хүнсний тухай¹, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай², Тариалангийн тухай³ хуулиудад органик хүнс, тэжээл, бордоотой холбоотой зохицуулалтыг шууд тусгажээ. Бодлогын баримт бичгийн тухайд 2010 онд батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”⁴-д хүнс, ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих,

¹ Хүнсний тухай хууль, 2012 он. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=8912>

² Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, 2012 он. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=8911>

³ Тариалангийн тухай, 2016. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11641>

⁴ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010 он. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/6163>

ялангуяа хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог сайжруулах замаар хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, олон улсын жишигт нийцүүлэх, улмаар иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, цаашлаад хөрсний доройтлыг бууруулах зэрэг асуудлыг тусгасан боловч ХАА-н органик бүтээгдэхүүний талаар тодорхой зохицуулалт агуулаагүй байна.⁵ Харин 2021 онд хүчингүй болсон “Төрөөс хүнс, ХАА-н талаар баримтлах бодлого”⁶, “Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн”⁷ зэрэг үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрт тусгагдсан ХАА-н органик хүнс үйлдвэрлэл, органик бордоо ашиглалтыг дэмжсэн агуулгууд УИХ-ын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт эрүүл, аюулгүй хүнсний хэрэглээг дэмжихэд буюу хүнсний үйлдвэрлэл, түүн дотор органик брэнд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, түүний хэрэглээг дэмжих, хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл, ул мөрийг мөшгөх, баталгаажуулах, хянах тогтолцоог боловсронгуй болгохын зэрэгцээ бүтээгдэхүүн тээвэрлэлтийн сүлжээг сайжруулах зэрэг органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжихээр өргөн хүрээтэй тусгагдсан нь бодлогын түвшинд ахиц гарсныг харуулж байна.⁸ Гэхдээ уг бодлогын баримт бичигт органик хүнс

⁵ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын

3.2.1.2-т “Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой ... хүнс, хөдөө аж ахуй, ... санхүүгийн салбарыг олон улс, Европын Холбооны стандартад нийцүүлэн хөгжүүлнэ.”,

3.4.2.2.Монгол хүний амьдралын зайлшгүй хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний 70-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэлээр тогтвортой хангах техник, эдийн засгийн арга хэмжээ авна.

3.4.2.5.Хүнсний түүхий эд бэлтгэл, үйлдвэрлэл, худалдаа-үйлчилгээ, хадгалалтын бүх үе шатуудад чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоог бий болгоно.

3.4.2.6.Мал эмнэлгийн тогтолцоог шинэчилж, малын халдварт өвчинтэй тэмцэх чадавхийг дээшлүүлж, халдвар, хамгаалал, биоаюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгоно. Монгол малын удмын сан, үр тарианы нутагшмал сортыг хамгаална. Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хүнсний сав, баглаа боодол, бордоо, ургамал хамгааллын бодис ашиглах хяналтыг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ.

3.4.2.7.Хүнсний чанар, аюулгүй байдлын техникийн шаардлагыг олон улсын стандарттай нийцүүлэн шинэчилж, хяналтын тогтолцоог бэхжүүлэн, олон улсын итгэмжлэлд хамруулах арга хэмжээ авна.

3.4.2.8.Хүнсний бүтээгдэхүүнийг зөвхөн аж ахуйн нэгж, байгууллагаар дамжуулан импортлох тогтолцоог бүрдүүлж, импортын хүнсний бүтээгдэхүүнд чанарын урьдчилсан хяналт, бүртгэлжүүлэлт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоо бий болгох, импортлох үеийн чанарын баталгаат байдалд эрсдэлийн үнэлгээ хийх замаар чанар, аюулгүй байдлын баталгааг хангана.

3.5.2.5-д “Бэлчээрийн мал аж ахуй, малчдын ахуй амьдралд шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, уламжлалт сэтгэлгээ, арга хэвшлийг сэргээж, хурдацтай явагдаж байгаа экосистемийн өөрчлөлтийг мэдэрч түүнд тохирсон, дасан зохицсон амьдралын хэв маяг,аж ахуй эрхлэх менежментийн арга барилыг боловсруулж заан сургах, туршин нэвтрүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон нийтэд хүргэх сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ.”

⁶ УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоол. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/11485>

⁷ ЗГ-ыг 2019 оны 52 дугаар тогтоол. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/14388>

⁸ Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичгийн “Хүнд ээлтэй амьдрах орчин” хэсэгт 2.5-д “Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж баталгаат хүнсээр хангана.” Гэх зорилтыг дэвшүүлсэн бөгөөд энэ хүрээнд 2021-2030 онд “Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж, харин 2031-2050 онд “...Органик...эрүүл хүнсний хэрэглээтэй болно.” гэж тус тус заасан. Мөн “Тогтвортой хөдөө аж ахуй”-г хөгжүүлэх асуудлын хүрээнд “Нүүдлийн уламжлалт өв соёлыг хадгалсан, экологид ээлтэй, органик мал аж ахуйг тогтвортой эрхлэх, хөдөө аж ахуйн эрчимжсэн үйлдвэрлэлийг төрөлжүүлж, кластер, логистик, санхүүгийн түрээсийн үйлчилгээг хөгжүүлж, төлөвшүүлнэ.” “...нүүдлийн мал аж ахуйн өв соёлыг дэлхий нийтэд таниулсан органик мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.” “...Оюуны багтаамж өндөртэй, органик, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр экспортыг нэмэгдүүлж, эдийн засагт орлогын шинэ

үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих талаар тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа төлөвлөлтгүй, Органик хүнсний тухай хуулийг хэрэгжүүлэх тогтолцоо тодорхойгүй байна. Тухайлбал, УИХ-ын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”⁹ -ийн 3.3.8-д “ ... ХАА-н бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ” гэх заалтаас өөр органик хүнсний үйлдвэрлэлтэй холбогдох тодорхой үйл ажиллагаа тусгаагүй, түүнчлэн ЗГ-ын 2009 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрт¹⁰ тусгагдсан органик хүнс үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн зорилго, зорилтууд ямар түвшинд хэрэгжсэн талаар мэдээлэл хангалтгүй байна.

Харин Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар УИХ-ын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай”¹¹ 36 дугаар тогтоолыг баталсан нь хүнсний, түүн дотроо органик хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэхээр байгаа бөгөөд энэхүү тогтоолд тусгагдсан ажлуудыг тодорхой төлөвлөгөөний дагуу хариуцах эзэнтэйгээр хэрэгжүүлэх нь өмнөх алдаа дутагдлаа давтахгүй байх үндэс болох юм.

Дээрхээс харахад Органик хүнсний тухай хууль болон төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, хөрөнгө санхүүжилт дутмаг зэргээс шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байгаатай холбоотойгоор органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих, урамшуулах, гадаад, дотоодын зах зээлд өрсөлдөхүйц Монгол брэндийн органик хүнсийг бий болгох, судалгаа, сургалт, сурталчилгаа хийх ажиллагаа удаашралтай байна.

Иймээс хүнс үйлдвэрлэлийн дэлхийн чиг хандлагад нийцүүлэн монгол орны газар нутаг, хөрс, цаг уурын онцлог нөхцөл байдалд нийцсэн газарзүйн заалт бүхий ХАА-н органик хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжихэд Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтэд үнэлэлт өгөх замаар хуулийг шинэчлэн сайжруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, мөн гадаад орны туршлагаас судалж, хэрэгжүүлэх боломжтой зохицуулалтыг нутагшуулах талаар санал, зөвлөмж боловсруулах нь хуулийг боловсронгуй болгох ажилд тодорхой хувь нэмэр оруулах юм.

эх үүсвэрийг бүрдүүлнэ.”⁸ гэжээ. Түүнчлэн “Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болгох” 9 дүгээр зорилтын хүрээнд “...Хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө орон нутгаас нийлүүлдэг органик хүнсний сүлжээ бий болгоно.”⁸ гэж тус тус заажээ.

⁹ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15586&sword=2020-2024%20оны%20үйл%20ажиллагааны%20хөтөлбөр>

¹⁰ Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөр. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=202477&showType=1>

¹¹ Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2022 оны 36 тогтоол. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530824651591>

НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үндэслэл, шаардлага

“Хууль тогтоомжийн тухай” хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “... хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх ...” гэж заасныг үндэслэн ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан Органик хүнсний тухай хуульд үнэлгээ хийлээ.

Органик хүнсний тухай хууль нь ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх, органик хүнс, тэжээл, бордоо үйлдвэрлэх, тэдгээрийг баталгаажуулах, худалдах, импортлох, органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэх, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой бөгөөд энэхүү зорилгодоо хүрэхэд бодитой хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх, тус хуулийг практикт хэрэглэхэд тулгамдаж буй үндсэн болон бусад ямар асуудал байгаа эсэхийг тодруулахад энэхүү хэрэгжилтийн үнэлгээний зорилго оршино.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Засгийн газрын “Аргачлал батлах тухай” 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д¹² хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлохдоо хэрэгжилтийг нь шалгаж үнэлгээ хийх гэж буй хууль тогтоомжийн бүтэц, агуулга, зохицуулалтын шинж чанар, онцлогоос хамааран аль тохиромжтой буюу түүгээр хэрэгжилтийн үр нөлөө, үр дагавар нь гарч ирэх шалгуур үзүүлэлтийг сонгох¹³ боломжтой байдлаар тусгасан.

Иймээс Улсын Их хурлаас 2016 онд баталсан Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо уг хуулийг боловсруулах хэрэгцээ шаардлагыг “Хуулийн төслийн үзэл баримтлал”¹⁴-д тусгасан “... хүн амыг мал аж ахуй, газар тариалангийн гаралтай органик бүтээгдэхүүнээр хангах, органик хүнсний үйлдвэрлэлийг органик түүхий эдээр хангах тогтолцоог бүрдүүлснээр ... малчид, тариаланчдын орлого нэмэгдэж, амьжаргаа дээшлэхэд чухал нөлөө үзүүлнэ. ... Байгалийн хувьд харьцангуй цэвэр, унаган төрхөө хадгалсан манай улсын хувьд давуу талаа ашиглан органик хүнсийг бий болгон гадаад, дотоодын зах зээлд гарах нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах, тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх, ногоон эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.” гэх үндсэн зорилгуудын хэрэгжилт хангагдсан эсэхийг тогтооход агуулгын хувьд чухал ач

¹²Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал. Эх сурвалж: <http://legalinfo.mn/annex/details/7338?lawid=11993>

¹³ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.6.2 дахь заалт. <http://legalinfo.mn/annex/details/7338?lawid=11993>

¹⁴ Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Хууль зүйн сайд Б.Дорлигжав нарын 2016 онд баталсан “Органик хүнсний тухай хуулийн төслийн үзэл баримтлал”-аас эшлэв.

холбогдолтой гэж үзсэн ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэгч, органик бүтээгдэхүүний бүртгэл, баталгаажуулалт, гэрчилгээ олгох үйл ажиллагаа, органик бүтээгдэхүүний тэмдэг, тэмдэглэгээний хэрэглээ болон экспортод холбогдох зарим асуудал болон хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага зэрэг уг хуулийн хэрэгжилтэд голлон нөлөөлж буй зүйл, заалтуудыг сонгосон.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгох, шалгуур үзүүлэлтийг томъёолох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.1.3-т заасан шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох ажлын хүрээнд Органик хүнсний тухай хуулийн сонгосон зүйл заалтыг дээрх аргачлалын 3.4.1-д заасан “Зорилгод хүрсэн түвшин”, 3.4.5-д заасан “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтээр хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх боломжтой гэж үзлээ.

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлт

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д заасан “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тодорхой таамаглал дэвшүүлэх, асуулт тавих замаар тогтоохыг зорьдог¹⁵. Иймээс сонгосон зохицуулалт тус бүрийг зорилгод хүрэх түвшин шалгуураар үнэллээ.

1.3.2. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг аргачлалын 3.7.3.1-т заасан бэлэн байгаа мэдээлэл цуглуулах арга буюу холбогдох ном, товхимол, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Үндэсний стандартчлалын төв, холбогдох бусад төрийн байгууллагууд болон хөндлөнгийн болон хамтын баталгаажуулалтын байгууллагуудаас гаргасан мэдээ мэдээлэл, мөн аргачлалын 3.7.3.2-т заасан холбогдох субьектээс судалгаа авах аргын дагуу холбогдох албан тушаалтан, органик аж ахуй эрхлэгчдээс зарим мэдээллийг нарийвчлан тодруулах зорилгоор хийсэн уулзалт, ярилцлагын судалгааны үр дүн зэргээр бүрдүүлсэн болно.

1.4. Үнэлгээний арга зүй

Энэхүү үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан хийж, гүйцэтгэв. Түүнчлэн Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг судлахдаа харьцуулах, түүхчлэх, задлан шинжлэх (анализ), баримт бичигт дүн шинжилгээ хийх гэсэн хууль зүйн судалгааны үндсэн арга зүйг ашигласан болно.

¹⁵ ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.4.1 дэх заалт. Эх сурвалж: <http://legalinfo.mn/annex/details/7338?lawid=11993>

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хэрэгжүүлэх үе шатанд төлөвлөлтийн үе шатанд тодорхойлсон үнэлгээ хийх хүрээнд багтсан зүйл заалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл буюу хууль тогтоомж, илтгэл, нийтлэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, ном, эмхэтгэл зэрэг олон нийтийн хүртээл болгосон бүтээлүүд болон холбогдох байгууллагуудаас гаргасан мэдээлэлд үндэслэн “Органик хүнсний тухай хуулийн сонгогдсон заалтууд тухайн асуудлыг хангалттай зохицуулж чадаж байгаа эсэх, хэрэв хангалтгүй бол ямар шалтгаан байгааг тодорхойлохыг зорьсон бөгөөд дор дурдсан заалтуудыг “Зорилгод хүрэх түвшин” болон “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэв.

№	Зүйл, заалтын агуулга	Шалгуур үзүүлэлтийн томьёолол
1	“Энэ хуулийн зорилт нь ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх, органик хүнс, тэжээл, бордоо үйлдвэрлэх, тэдгээрийг баталгаажуулах, худалдах, импортлох, органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэх, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино”	ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх эрх зүйн орчин бүрдсэн байна органик хүнс, тэжээл, бордоо үйлдвэрлэх нөхцөл бүрдсэн байна. органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэх, сурталчлахтай холбогдсон эрх зүйн зохицуулалт бий болсон, түүний хэрэгжилт хангалттай байна.
	8 дугаар зүйл. Органик үйлдвэрлэл эрхлэгчид тавих шаардлага 8.1.Органик үйлдвэрлэл эрхлэгч Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаас гадна дараахь шаардлагыг хангасан байна: 8.1.1.органик үйлдвэрлэлийн үйл явц болон органик хүнсийг хоёр жил тутамд баталгаажуулалтад хамруулах; 8.1.2.баталгаажуулалтын зардлыг хариуцах;	Органик үйлдвэрлэл эрхлэгчид тавигдах шаардлага органик үйлдвэрлэл эрхэлснээр эдийн засгийн хувьд хүрэх үр дүнд нийцсэн байна.
4	10 дугаар зүйл. Баталгаажуулалтын байгууллага, органик үйлдвэрлэл болон хүнсний баталгаажуулалт, бүртгэл 10.1.Органик үйлдвэрлэлийн болон органик хүнс, тэжээл, бордооны баталгаажуулалтыг доор дурдсан байгууллага гүйцэтгэнэ: 10.1.1.Монгол Улсын эрх бүхий байгууллагаар итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага; 10.1.2.Монгол Улсад бүртгэлтэй, гадаад улсын итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага. 10.2.Энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэсэн хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан үйлдвэрлэгч, хэрэглэгч болон бусад тал хамтран баталгаажуулах бол хүнс, ХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.	Органик хүнсийг баталгаажуулах байгууллагыг итгэмжлэх үйл ажиллагаа тодорхой байна. Баталгаажуулалтын байгууллагыг үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах болон харуцлага хүлээлгэх эрх зүйн орчин тодорхой байна.
5	10.4.Баталгаажуулалтын байгууллага эрх бүхий үндэсний болон олон улсын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартын хүрээнд баталгаажуулалт хийж, гэрчилгээ олгох, мөн түүнийг түдгэлзүүлэх, хүчингүй болгож болох бөгөөд энэ тухай хүнс, ХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллагад бичгээр мэдэгдэнэ.	
6	10.5.Хүнс, ХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаажсан органик үйлдвэрлэл, хүнсний мэдээллийн санг бүрдүүлж, тухай бүр шинэчлэн мэргэжлийн хяналтын байгууллагад бичгээр мэдэгдэнэ.	Мэдээллийн сан нийтэд хүртээмжтэй, ойлгомжтой байна.

	10.6.Үндэсний итгэмжлэлийн болон хүнс, ХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 10.1, 10.2-т заасан баталгаажуулалт хийсэн этгээдийн талаархи мэдээллийн санг бүрдүүлж, тухай бүр шинэчлэнэ.	
7	10.7.Энэ хуулийн 10.1, 10.2-т заасан баталгаажуулалт хийсэн этгээд дараахь үүрэгтэй: 10.7.1.органик үйлдвэрлэл эрхлэгчтэй энэ хуулийн 6.2-т заасан гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангуулж ажиллах; 10.7.2.органик үйлдвэрлэл эрхлэгч энэ хуулийн 8.2-т заасныг зөрчиж үйлдвэрлэл явуулсан бол баталгаажуулалтыг хүчингүй болгож, энэ тухай мэдээллийг мэргэжлийн хяналтын байгууллага болон хүнс, ХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 10 өдөрт багтаан албан бичгээр мэдэгдэх; 10.7.3.эрх бүхий байгууллагыг баталгаажуулсан үйлдвэрлэл эрхлэгчийн тухай мэдээллээр хангах; 10.7.4.энэ хуулийн 10.1, 10.2-т заасан баталгаажуулалт хийсэн этгээд үндэсний итгэмжлэлийн байгууллагад бүртгүүлэхгүйгээр үйл ажиллагаа явуулахыг хориглоно.	Гэрээний хэрэгжилтийг хянах тогтолцоо хөндлөнгийн, ашиг сонирхлын зөрчилгүй байна. Эрх бүхий байгууллагаас шаардах мэдээлэл тодорхой, давхардалгүй байна.
8	11 дүгээр зүйл. Органик хүнсний тэмдэг, тэмдэглэгээ, шошго 11.1.Энэ хуулийн 10.1-д зааснаар баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдэг, 10.2-т зааснаар баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдэглэгээг тус тус шошгод тавина. 11.7.Хүнсний шошгод монгол болон гадаад хэлээр бичигдсэн "органик", "байгалийн цэвэр", "байгалийн гаралтай цэвэр" гэсэн үгийг хэрэглэх бол энэ хуулийг дагаж мөрдөнө.	Органик хүнс, бордоо, тэжээл болохыг тодорхойлсон шошго хэрэглэх нь үйлдвэрлэгчид дарамт үүсгэхгүй. Органик шошгыг органик бус бүтээгдээгдэхүүн хэрэглэхгүй
9	12 дугаар зүйл. Органик үйлдвэрлэл, органик хүнсэнд тавих хяналт 12.1.Органик үйлдвэрлэлийн сүлжээнд болон органик хүнсний хадгалалт, тээвэрлэлт, экспорт, импорт, худалдаа, үйлчилгээнд тавих хяналтыг Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиар тус тус зохицуулна. 12.2.Энэ хуулийн 10.1, 10.2-т заасан баталгаажуулалт хийсэн этгээд органик хүнсний үйлдвэрлэлийн үйл явцад байнгын хяналт тавина.	Органик үйлдвэрлэл, органик хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналтын мөрөөр хуурамч органик хүнсний бүтээгдэхүүний илрүүлэлт нэмэгдэнэ.
	13 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага 13.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 13.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Органик үйлдвэрлэл, органик хүнсний бүтээгдэхүүнд холбогдох хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэсэн байна.

2.1. ЗОРИЛГОД ХҮРЭХ ТҮВШИН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ

ХУУЛИЙН ЗОРИЛГО

Дэлхий дахинаа 1960-аад оноос эхлэн хүн амын өсөлт, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлд ашигласан химийн бодисын хэмжээ, генийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүнүүд хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэх эргэлзээ үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн дунд газар авч эхэлснээр органик хөдөө аж ахуй, органик бүтээгдэхүүний эрэлт эрс нэмэгдэж, уламжлалт аргаар боловсруулсан, хүнсний хангамж, тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн, байгаль орчинд ээлтэй, байгалийн нөөцийг зохистой, хөнөөл багатай ашиглах замаар боловсруулж буй органик хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн эзлэх байр суурь улам бүр нэмэгдэж, ХАА-н гаралтай органик хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ өсөж байгаа нь энэ салбар дэлхийн хамгийн хурдацтай өсөж дэвшиж буй салбарын нэг болоход нөлөөлж байна.

Манай улс олон улсын ХАА-н органик үйлдвэрлэлийн зарчим, чиг хандлагад нийцүүлэн дотоодын органик хүнсний үйлдвэрлэл, органик хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, импортын бүтээгдэхүүний хяналтыг сайжруулж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох замаар органик үйлдвэрлэлийг дэмжих, органик хүнсний хэрэглээ, хэрэглэгчийн итгэлийг бий болгох, дэлхийн зах зээлд эзлэх хувь жил ирэх тутам өссөөр байгаа органик бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.

Монгол Улс 2030 он гэхэд хүнс, ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 5 хувийг органик аргаар үйлдвэрлэх зорилго тавин ажиллаж байна. ХАА-н хүнс үйлдвэрлэлийн салбарт органик, тогтвортой үйлдвэрлэлийн зарчмыг хүнсний сүлжээний бүх үе шатанд хэвшүүлэх зорилгын хүрээнд хөдөө, аж ахуйн органик үйлдвэрлэлийг дэмжих, сурталчлах зорилготой "Органик хүнс, хөдөө аж ахуй" үндэсний чуулганыг 2016 оноос эхлэн зохион байгуулж байгаа бөгөөд 2018 онд зохион байгуулагдсан 3 дугаар чуулганаас эхлэн “Алсыг харъя, Органикийг сонгоё” уриан дор хэрэгжүүлж эхэлжээ.

Органик үйлдвэрлэлийг дэмжихэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Адра Монгол ОУБ, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, НҮБ-ын Хүнс, ХАА-н байгууллага, Монгол ногоо төсөл, Азийн бүтээмжийн байгууллага, Нийслэлийн Хүнс, ХАА-н газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг төрийн болон олон улсын байгууллага, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүдийн идэвх, оролцоо их юм. Тухайлбал, НҮБ-ын ХХААБ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн “Органик ХАА-г дэмжих” TCP/MON/3503 төслийг энд дурдаж болох юм.

2.1.1. Хуулийн 1 дүгээр зүйлийг “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

№	Зүйл, заалтын агуулга	Шалгуур үзүүлэлтийн томьёолол
1	“Энэ хуулийн зорилт нь ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх, органик хүнс, тэжээл, бордоо үйлдвэрлэх, тэдгээрийг баталгаажуулах, худалдах, импортлох, органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэх, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино”	ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх эрх зүйн орчин бүрдсэн байна
		Хэрэглэгч органик хүнсний бүтээгдэхүүний тэмдэг, тэмдэглэгээ болон органик бус бүтээгдэхүүнээс ялгах мэдлэгтэй болсон байна.

Томьёолол

Органик хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлд хуулийн зорилтыг тодорхойлсон байх ба энэхүү хэсгийг “ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.”, “Хэрэглэгч органик хүнсний бүтээгдэхүүний тэмдэг, тэмдэглэгээ болон органик бус бүтээгдэхүүнээс ялгах мэдлэгтэй болсон байна.” гэх томьёоллоор “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэллээ.

Судалсан байдал

Органик хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан хуулийн зорилтуудыг авч үзвэл “ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх”, “органик хүнс, тэжээл, бордоо үйлдвэрлэх”, “тэдгээрийг баталгаажуулах”, “худалдах”, “импортлох”, “органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэх”, “сурталчлах” гэсэн 7 харилцааг зохицуулахаар зорьжээ.

Хуулийн энэ заалт зорилгодоо хүрч буй эсэхийг тогтоох зорилгоор хуулийн заалтын хэрэгжилтийг “ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.”, мөн “Хэрэглэгч органик хүнсний бүтээгдэхүүний тэмдэг, тэмдэглэгээ болон органик бус бүтээгдэхүүнээс ялгах мэдлэгтэй болсон байна.” гэх хоёр томьёоллын хүрээнд үнэлнэ.

А. Эрх зүйн орчин

Органик хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлийг “ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.” томьёоллоор шалгахад уг зохицуулалт **ЗОРИЛГОДОО ХҮРСЭН** байна. Тодруулбал,

Органик хүнсний тухай хууль батлах үндсэн зорилго болох ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар ХАА-н анхан шатны үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнсний бүтээгдэхүүн, бордоо, тэжээл, үр, суулгац үйлдвэрлэх, тэдгээрийг баталгаажуулах, худалдах, импортлох, органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэх, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулахад шаардлагатай, хуульд тусгасан дүрэм, журам, аргачлал, жагсаалтууд бүгд батлагдсан байна.

Хууль батлагдсан орчин нөхцөлийг авч үзвэл органик үйлдвэрлэлийн талаар мэдлэг олгож, эрх зүйн чадамжийг нэмэгдүүлж, тогтвортой хөгжлийн чадавхыг сайжруулах зорилгоор 2017-2017 онд НҮБ-ын ХХААБ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн “Органик ХАА-г дэмжих” TCP MON/3503 төслийн үр дүнд хуулийн төсөл болон

холбогдох журам, аргачлалуудын төслүүдийг боловсруулсан бөгөөд хуулийн Үзэл баримтлалыг 2015 оны 1 сард батлуулж¹⁶, 2016 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн УИХ-аас Органик хүнсний тухай хуулийг баталсан¹⁷.

Органик хүнсний тухай хуулийг 2016 онд баталсан боловч хуульд заасан журам, дүрэм, аргачлал батлах ажиллагаа удаашралтай явагджээ. Тухайлбал, анхны багц журмыг хууль батлагдсанаас хойш 2 жилийн дараа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд /цаашид ХХААХҮСайд гэх/-ын 2018 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн “Журам, аргачлал батлах тухай” А-09 дүгээр тушаалаар хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т заасан “ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах журам, хэрэглэх бодисын жагсаалт”, 8.4-т заасан “Органик хүнсний орцын найрлага тооцох аргачлал”, 10 дугаар зүйлийн 10.3-т заасан “Харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах байгууллагад тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журам”, 11 дүгээр зүйлийн 11.6-д заасан “Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам”-ыг тус тус баталж байсан бол хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1-д заасан “Органик хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам”¹⁸-ыг ХХААХҮСайд-ын 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А-180 дугаар тушаалаар, “Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам”¹⁹-ыг ХХААХҮСайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А-515 дугаар тушаалаар тус тус баталсан байна.

Харин хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан “Гадаад орны итгэмжлэлийн байгууллагаас итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагыг бүртгэх журам”²⁰ болон холбогдох бусад баримт бичгийг Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн А10 дугаар тушаалаар баталж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2020 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн 4884 дүгээрт бүртгүүлснээр Органик хүнсний тухай хуульд заасан эрх зүйн актууд бүрэн батлагдаж хуулийн зорилтыг агуулсан 1 дүгээр зүйлийн хэрэгжилт эрх зүйн орчин бүрдүүлэх тухайд зорилгодоо хүрсэн байна.

¹⁶ Засгийн газрын 2014 оны 11-р сарын 21-ний өдрийн хуралдааны 59 дүгээр тэмдэглэлээр “Органик хүнсний тухай” хуулийн үзэл баримтлалын төслийг хэлэлцэн дэмжээд, Хууль зүйн сайдын 2015 оны 01-р сарын 20-ны өдрийн 1/230 дугаар албан бичгээр “Органик хүнсний тухай” хуулийн үзэл баримтлалыг батлуулсан.

¹⁷ ХЗЯ-ны 2015 оны 06-р сарын 04-ний өдрийн 1/2142 тоот албан бичгээр Органик хүнсний тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхийг зөвшөөрсөний дагуу 2015 оны 06-р сарын 10-ны өдөр УИХ-д өргөн барьж, 2016 оны 02-р сарын 04-ний өдрийн УИХ-ын чуулганаар хэлэлцүүлсэн.

¹⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=13739&sword=органик%20хүнс>

¹⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=210440&showType=1>

²⁰ Гадаад орны итгэмжлэлийн байгууллагаас итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагыг бүртгэх журам <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15739&sword=органик%20хүнс>

Үнэлсэн байдал

Хэдийгээр ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх эрх зүйн орчин бүрдсэн боловч Органик хүнсний тухай хуульд дотоод зөрчил, хийдэл болон бусад эрх зүйн актууд хооронд зөрчил үүсгэж буй хэд хэдэн зохицуулалт байгааг анхаарах шаардлагатай. Үүнд:

1. Хуулийн зорилт хэсэгт тусгагдаагүй органик хүнсний экспортод хамаарах зохицуулалтыг хуулийн 9 дүгээр зүйлд тусгасан, мөн энэ заалтын хүрээнд зөвхөн органик хүнсний экспорт, импорт хамаарахаар байгаа нь хуулийн хамрах хүрээнд орсон органик бордоо, тэжээл, түүхий эдийг орхигдуулсан,
2. Органик бордоо, тэжээлийн тухайд импортлох болон баталгаажуулагдсан байх шаардлагаас цааш тодорхой зохицуулалтгүй,
3. Органик хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т *“6.2.Баталгаажуулалтын байгууллага органик үйлдвэрлэлд шилжих шилжилтийн үеийг эхлүүлэх болон органик хүнсийг баталгаажуулах тухай гэрээг үйлдвэрлэл эрхлэгчтэй байгуулснаас хойш энэ тухай ажлын 10 өдөрт багтаан хүнс, ХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр мэдэгдэнэ.”* гэж, харин Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журмын 2.5-д *“ХББ нь хамтран ажиллах гэрээ байгуулсан тухай мэдээллийг Органик хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу ажлын 10 өдөрт багтаан хүнс, ХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.”* гэж тусгасан нь хуулийн 6.2 дахь заалтын хүрээнд 2 өөр төрлийн гэрээ байгуулахаар, эсхүл шилжилтийн үеийг эхлүүлэх болон органик хүнсийг баталгаажуулах тухай гэрээ нь ХББ-ын хамтран ажиллах гэрээтэй нэгэн адил мэтээр ойлгогдох эрсдэлтэй,
4. Хуулийн 6.2, 6.4, 7.1.4, 10.4, 10.5, 10.7.2 дахь зүйл, заалтад баталгаажуулалтын байгууллагууд болон органик үйлдвэрлэл эрхлэгчид, төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллага “бичгээр” мэдэгдэл, мэдээлэл хүргүүлэх тухай зохицуулалт агуулсан нь төр засгаас төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх замаар хүндрэл чирэгдэлгүй, шуурхай болгох зорилт тавьж буй өнөөгийн нөхцөл байдалд нийцэхгүй байна.

Органик хүнсний тухай хууль, түүнтэй уялдуулан ХХААХҮСайд, Үндэсний итгэмжлэлийн даргын тушаалаар гаргасан журам, аргачлал зэрэг эрх зүйн актаас гадна Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын даргын 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/181 тушаалаар баталсан “Органик бүтээгдэхүүн/Certified organic эко шошго хэрэглэх эрх олгох журам”²¹ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нь хууль зөрчиж байна. Уг журмаар органик мал аж ахуй, органик газар тариалан, органик зөгийн аж ахуйд тавигдах шаардлагуудыг тодорхойлон органик хүнсний бүтээгдэхүүн болохыг тодорхойлон органик шошго хэрэглэх эрх олгох боломжтой. Харин сүүлийн жилүүдэд хүнсний бүтээгдэхүүнд бус ноос, ноолууран болон гоо сайхны бараа бүтээгдэхүүн, био бэлдмэлүүдэд органик гэрчилгээ олгожээ. 2022 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн УИХ-

²¹ Органик бүтээгдэхүүн/Certified organic шошго. Эх сурвалж: <https://www.mongolchamber.mn/p/24>

03/7501 тоот албан бичгийн хариугаар 2015-2021 онд нийт 66 бүтээгдэхүүнд эко шошго олгосон бүтээгдэхүүний жагсаалт ирүүлснээс харахад 42 хувь нь ноос, ноолууран бүтээгдэхүүнд, 44 хувь нь гоо сайхны бараа бүтээгдэхүүнд, үлдсэн 14 хувь нь эм, био бэлдмэл, хүнс, бордоо зэрэг бусад бүтээгдэхүүн байна.²² МҮХАҮТ-аас олгосон эко шошгын эрэлт хэрэгцээнээс харахад манай улсад органик хүнснээс гадна органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах шаардлага өндөр байна.

Санал, зөвлөмж:

Хуулийн зорилт хэсгийг ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.” томьёоллоор шалгаж, тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Органик хүнсний тухай хуулийн зорилт хэсэгт “экспорт”-ыг нэмж тусгах,
2. Органик бордоо, тэжээл, түүхий эд үйлдвэрлэх, боловсруулах асуудлыг тодорхой болгох,
3. Органик хүнсний тухай хуулийн 9 дүгээр зүйлд манай улсын хувьд экспортлох боломж өндөртэй органик гол нэрийн бүтээгдэхүүн болох органик бордоо, тэжээл, түүхий эдийг тусгах,
4. Органик хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 болон Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журмын 2.5-д заасан гэрээний шаардлагыг нэг мөр ойлгогдохоор томъёолох,
5. Хуулийн эх бичвэрээс “бичгээр” тайлан, мэдээлэл хүргүүлэх шаардлагыг хасах,
6. МҮХАҮТ-ын даргын 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/181 тушаалаар баталсан “Органик бүтээгдэхүүн/Certified organic эко шошго хэрэглэх эрх олгох журам”-ыг хүчингүй болгох.

Б. Сурталчилгаа.

Органик хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлийг “Хэрэглэгч органик хүнсний бүтээгдэхүүний тэмдэг, тэмдэглэгээ болон органик бус бүтээгдэхүүнээс ялгах мэдлэгтэй болсон байна.” томьёоллоор шалгахад уг зохицуулалт **ЗОРИЛГОДОО ХҮРЭЭГҮЙ** байна.

Судалсан байдал

Органик хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлд органик хүнсийг сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилт тавьсан боловч уг хууль болон холбогдох журмуудад органик үйлдвэрлэл эрхлэх, органик хүнсийг сурталчлах ажлыг хариуцах этгээдийг тодорхойлоогүй нь хуулийн хийдэл үүсгэжээ.

Органик үйлдвэрлэл, бүтээгдэхүүнийг сурталчлах ажлын хэрэгжилтийг реклам, зар сурталчилгаа, сургалт, судалгаа болон мэдээллийн ил тод байдал гэсэн 4 чиглэлээр

²² 2022 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн УИХ-03/7501 тоот албан бичигт цахимаар ирүүлсэн хариунаас

сурталчлах боломжтой гэж үзэн өнгөрсөн 5 жилийн хугацаанд дээрх үйл ажиллагаа хэрхэн хэрэгжсэн, ямар үр дүнд хүрсэн тухайд судалж үзлээ.

Органик бүтээгдэхүүний реклам, зар сурталчилгаа хангалтгүй байна. ХАА-н /цаашид ХАА гэх/ органик хүнс үйлдвэрлэгчид органик үйлдвэрлэл, бүтээгдэхүүний талаар олон нийтийн хэвлэл мэдээллийг хэрэгслээр реклам, зар сурталчилгаа цацах боломж хомс байна.

Манайх үйл ажиллагаа, бүтээгдэхүүнээ сурталчлахаар хамгийн хямд буюу үзэгч багатай телевизээр 2 удаа нэвтрүүлэхэд 2 сая орчим төгрөг болсон. Бид төсөл болохоор энэ зардлыг гаргасан, тариаланчид маань энэ зардлыг дийлэхгүй.

АДРА ОУБ-ын “Органик ХАА-н түншлэл” төслийн менежер

Учир нь ХАА-н анхан шатны органик үйлдвэрлэгчид, ялангуяа улирлын шинжтэй буюу тогтмол бус үйл ажиллагаа явуулдаг хүнсний ногоо, зөгийн аж ахуй эрхлэгчдийн дийлэнх хоршоо, нөхөрлөл хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд эдийн засаг, санхүүгийн хувьд бэхжээгүй, хэрэглэгчдийн хандлага, органик бүтээгдэхүүний талаар мэдээлэлгүй, хэрэглээндээ нэвтрүүлээгүй зэрэг зан үйлийн шинжтэй асуудлуудаас гадна олон нийтийн мэдээллийн хэрэгслээр, ялангуяа мэдээллийн үндсэн эх сурвалж болох телевизүүдийн тариф өндөр байдагтай холбоотой байна. Телевизүүдийн зар сурталчилгааны үнэ болох дунджаар 7,000-9,000 төгрөг/секундийн тарифаар ойролцоогоор 1 минутын сурталчилгааг нэг удаа цацахад дунджаар 500,000 төгрөг, 30 хүртэлх секундийн реклам, шторк бэлтгэх зардал 250.000-400.000 төгрөг байна. Энэ нь эдийн засгийн хувьд бэхжээгүй, нэгдсэн холбоо, төлөөлөгчийн газаргүй үйлдвэрлэгчид үйл ажиллагаа, бүтээгдэхүүнээ сурталчлахад хүндрэлтэй байгаа нь хэрэглэгчдэд мэдээлэл хүрэхгүй байхад нөлөөлж байна.

Зураг 1. Зар сурталчилгааны тариф



Нэр	Цагийн бүс	Үнэ/1 сек, төгрөг/
Өглөөний оргил цаг	06:00-12:00	12,000 ₮
Өдрийн гол цаг	12:00-18:00	7,000 ₮
Оройны оргил цаг	18:00-00:00	9,000 ₮
Тусгай үнэ*		22,000 ₮

23

ШТОРК				
1	Шторк цацах	МҮОНТ	1 секунд	7,000
		МҮОНР-1	1 минут хүртэл	25,000
2	Ивээн тэтгэгчээр эфирт түгээх	РЗ	1 удаа	3,000
3	Шторкны эх бэлтгэх	МҮОНТ	1 сек	50,000-100,000
		МҮОНР	1 минут хүртэл	50,000-150,000

24


Дээрх нөхцөл байдлын улмаас ихэвчлэн социал медиа сувгуудаар органик үйлдвэрлэл, бүтээгдэхүүний зар сурталчилгаа явуулдаг нь төдийлөн үр дүнгүй байна. Тодруулбал, олон нийтийн хэрэглээ болсон Фэйсбүүк /Facebook/, Инстаграм /Instagram/ зэрэг цахим хуудсаар дамжуулсан зар сурталчилгаа олон нийтэд гэхээс илүүтэй органик хүнс,

²³ Блүүмберг ТВ тариф. Эх сурвалж: <https://bloombergtv.mn/tv-offer/> Сүүлд үзсэн: 2022.08.10


²⁴ МҮОНРТ-ийн тариф. Эх сурвалж: <http://about.mnb.mn/c/55> Сүүлд үзсэн: 2022.08.10

бүтээгдэхүүн сонирхогчдын түвшинд мэдээлэл хүргэдэг, мөн баталгаажсан болон хуурамч органик бүтээгдэхүүний зар сурталчилгааг ялгах боломжгүй байдаг. Тухайлбал, Facebook хуудсанд “органик”, “байгалийн цэвэр”, “байгалийн гаралтай цэвэр” гэх мэдэгдэл агуулсан баталгаажаагүй органик хүнсний бүтээгдэхүүн сурталчлах, худалдаалах нь түгээмэл байгаа нь хэрэглэгчдийг төөрөгдүүлсээр байна.

Зураг2. Баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулсан органик хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгаа



Зураг 3. Органик болон байгалийн цэвэр, байгалийн гаралтай цэвэр мэдэгдэл ашиглаж буй баталгаажаагүй хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгаа



Органик ХАА-н үйлдвэрлэл, органик хүнсний бүтээгдэхүүний тухай сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил, мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна.

ХАА-н органик үйлдвэрлэл, органик хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, органик тэжээл, бордоо, үр, суулгац үйлдвэрлэхэд эрдэм шинжилгээ судалгааны

байгууллагуудын оролцоо их. Өнөөдөр манай улсад ХАА-н буюу газар тариалан, мал аж ахуй, ургамал хамгааллын чиглэлээр ХААИС-ийн ХАА-н эдийн засаг, инновацын хөгжлийн төв²⁵, Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн²⁶ Дархан-Уул аймаг дахь Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа Ургамал, газар тариалангийн хүрээлэн²⁷, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн²⁸, Мал эмнэлгийн хүрээлэн²⁹ зэрэг ХАА-н хүнсний үйлдвэрлэлтэй холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгүүд мал аж ахуй, газар тариалан, ургамал, үр тариа, жимс жимсгэнэ, хүнсний ногоо судлалын нэгжүүдээрээ дамжуулан эх орны хөрс, цаг уурын нөхцөлд нийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ургамал, амьтан хамгааллын бодис, эм, бэлдмэлүүдийг гаргаж авах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг бөгөөд судалгаа шинжилгээний ажлуудыг дунд органик хүнс, тэжээл, бордоо, ургамал хамгааллын бодис үйлдвэрлэл болон хүнсний бүтээгдэхүүн боловсруулахтай шууд холбогдох төсөл, судалгааны ажлууд болон үүнд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь цөөн байна. Органик хөдөө аж ахуйтай холбоотой хэрэгжүүлсэн ажлуудаас дурдвал, Мал эмнэлгийн хүрээлэн “Органик мал аж ахуйд хэрэглэх байгалийн гаралтай шинэ эм, бэлдмэлийн технологи” зэрэг эрдэм шинжилгээ, судалгааны төсөл хэрэгжүүлсэн бол Ургамал, газар тариалангийн хүрээлэн эрдэмтдийнхээ судалгаа шинжилгээний үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор био бордоо, ургамал хамгааллын бодис үйлдвэрлэгч “БиоУндарга” ХХК-ийг байгуулжээ.

Хэдийгээр улсын хэмжээнд цөөнгүй эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа боловч тэдгээрийн хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, тайлан ХАА-н салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд ил тод, нээлттэй бус, хэн нэгний шүүгэнд хадгалаатай байдаг нь тэдгээрийг ашиглах, хэрэглээндээ нэвтрүүлэх боломжийг хааж байгааг анхаарах нь зүйтэй.

Түүнчлэн ХХААХҮЯ-ны дэргэд 2020 онд салбарын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа туршилт, инкубаци, шинжлэх ухааны ололт, дэвшилтэт техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, дамжуулах, сурталчлах, мэдээ мэдээллээр хангах чиг үүрэг бүхий зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан сургалт, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төв”³⁰ улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулсан³¹ боловч үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг нийтэд ил тод байрлуулаагүй, албан ёсны цахим хуудас нь ажилладаггүй байна. Үүнээс гадна ХХААХҮЯ-ны хариуцаж буй “Органик

²⁵ Хөдөө аж ахуйн эдийн засаг, инновацын хөгжлийн төв Эх сурвалж: https://muls.edu.mn/view.php?page_value_sub=ZW5jb2RldXNlcmlkMzU=

²⁶ Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн. Эх сурвалж: https://muls.edu.mn/view.php?page_value_sub=ZW5jb2RldXNlcmlkMzc=

²⁷ Ургамал, газар тариалангийн хүрээлэн <http://ipas.edu.mn/academics/dgs/>

²⁸ Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн <http://www.plantprotection.mn/>


²⁹ Мал эмнэлгийн хүрээлэн Эх сурвалж: <http://www.ivm.mn/>

³⁰ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төв <http://rdc.gov.mn/>

³¹ ЗГ-ын 2020 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн “Төрийн өмчит үйлдвэрийн газрын талаар авах зарим арга хэмжээний тухай” 93 дугаар тогтоол. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/15626>

бүтээгдэхүүний бүртгэл мэдээллийн сан” organic.gov.mn³² цахим хуудас зөвхөн бүртгэл, баталгаажуулалтын хэсгийн мэдээллийг шинэчилсэн бол бусад мэдээлэл, зөвлөгөө өгөх хэсгүүд 2018 оноос хойш шинэчлэгдээгүй байна.

Зураг 4. Органик хүнсний бүртгэл, мэдээллийн сан дахь мэдээлэл



ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх, органик хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой эрдэм шинжилгээ, судалгааны ажил болон мэдээлэл, арга зүй, зөвлөгөөгөөр хангах ажил хангалтгүй, хүртээмжгүй, цаг үеэсээ хоцорч байгаа нь эдгээр асуудлыг хариуцах нэгж тодорхойгүй, салбарын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын үйл ажиллагаа уялдаагүйгээс гадна энэ төрлийн судалгааг төлөвлөж төсөвт тусгадаггүйтэй холбоотой юм.

Сургалт, нөлөөллийн ажил хангалтгүй хэрэгжиж байна. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын нэгэн адил органик аж ахуй эрхлэгчид, органик хүнс үйлдвэрлэгчид болон хэрэглэгчдэд зориулсан сургалт, нөлөөллийн ажиллагаа зохион байгуулах тал дээр төрийн зүгээс анхаарах шаардлага байна. Органик хүнсний тухай хуульд сургалт, нөлөөллийн ажиллагаатай холбоотой зохицуулалт байхгүй, зорилт хэсэгт энэ талаар тусгаагүй. Харин Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журмын 4.3-т “Хамтын баталгаажуулалтын байгууллага гишүүдээ Органик хүнсний болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, тогтоомж, стандарт, байгууллагын стандарт, дүрмийг судлах, эдгээрт нийцүүлэн хяналт шалгалтын удирдамж аргачлал, хяналтын хуудсыг боловсруулах, үнэлгээ өгөх, хяналт шалгалтыг гүйцэтгэх, тайлагнах чиглэлийн сургалтад хамруулах”, 5.8-д “Хамтын баталгаажуулалтын байгууллагын гишүүд хоорондоо харилцан туршилага, мэдлэгээ хуваалцах, дамжуулах, түгээх, дадлагажих, газар дээр нь очиж зөвлөгөө өгөх чиглэлээр сургалт хэлэлцүүлгийг төлөвлөж, хэрэгжүүлэх, энэ талаар тайлагнах” үүргийг тус тус хүлээлгэснээс харахад ХАА-н органик хүнсний сүлжээний бүхий л шатанд хамаарах хууль тогтоомж, стандарт, байгууллагын стандарт, дүрэм, журам, аргачлалыг судлах, сургалт зохион байгуулах үүрэг зөвхөн баталгаажуулалтын байгууллагад хамааралтай

³² Органик бүтээгдэхүүний бүртгэл мэдээллийн сан. Эх сурвалж: <https://organic.gov.mn> Сүүд үзсэн 2022.08.10

байна. Иймээс төрийн байгууллагын зүгээс хэрэгжүүлж буй сургалт, нөлөөллийн ажил зөвхөн тодорхой аян, арга хэмжээтэй уялдсан байдлаар зохиогдож байна.

Органик хүнсний тухай хууль батлагдсаны дараа энэ талаар сургалт зохион байгуулж байсан. Тухайн үед журмууд нь батлагдаагүй байсан болохоор тодорхой мэдлэг авах боломж байгаагүй. Тэрнээс хойш сургалт аваагүй. Харин сургуулийн хүүхдүүдэд нэг удаа органик шошгын талаас сургалт хийсэн.

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын мэргэжилтэн

Манайх органик бүтээгдэхүүнээ онцолж сурталчилдаггүй. Сурталчиллаа гээд хүсүүсийн мэдлэг, хандлагаас шалтгаалаад үр дүнд хүрэхгүй. Төрийн байгууллагууд органик хүнсний талаар сургалт, мэдээлэл хүргэх ажлаа хийхгүй бол бид бүтээгдэхүүнээ резламдлаа гээд зардал л гарна, өөр ашиг байхгүй.

Хаан жимс ХХК-ийн төлөөлөл

ХХААХҮЯ-ны мэдээллэснээр тус яамнаас 2016-2021 оны хооронд “Органик хүнс, ХАА-н чиглэлээр хэлэлцүүлэг, мэдлэг олгох цахим болон танхимын сургалтыг 75 орчим удаа зохион байгуулж, 4000 орчим хэвлэлийн материалыг олон нийтэд түгээсэн”³³

Улсын хэмжээнд Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг хариуцаж буй бие даасан төрийн байгууллагын нэгж байхгүй. Харин хүнсний асуудал хариуцсан 2 нэгжид Органик хүнсний асуудал хариуцсан тус бүр нэг албан хаагч буюу ХХААХҮЯ-ны Хүнсний үйлдвэрийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Органик хүнс, хүнсний сав баглаа боодлын аюулгүй байдлын асуудал хариуцсан ахлах шинжээч-1, НЗДТГ-ын харьяа Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний үйлдвэрлэлийн хэлтсийн органик хүнсний үйлдвэрлэл хариуцсан нэг мэргэжилтэн ажилладаг³⁴

Мөн Үндэсний аудитын газраас 2021 онд гүйцэтгэсэн “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн” аудитын тайланд³⁵ “Хоол, хүнсний талаарх хүн амын мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажлын үр дүнг тооцдоггүй, үнэлж дүгнэдэггүй, хэрэгжилт хангалтгүй байна Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.1.3-т “Хүн амын дунд хоол тэжээлийн зохистой хэрэглээг төлөвшүүлж, зонхилох халдварт бус өвчнөөс сэргийлэн бичил тэжээлийн дутлыг бууруулна” гэж заасан байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, Эрүүл мэнд, Боловсрол, шинжлэх ухааны яамд харилцан уялдаа холбоогүй ажилласнаас хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсрол олгох ажил үр дүнгүй, хяналтгүй хэрэгжиж, иргэдийн хоол тэжээлийн гаралтай өвчлөл буурахгүй байна. ХХААХҮЯ, ЭМЯ, МХЕГ, НЭМҮТ зэрэг газруудаас жил бүр олон нийтийг соён гэгээрүүлэх, хүнсний мэдлэг боловсрол олгох

³³ ХХААХҮЯ-ны мэдээлэл. Эх сурвалж: <https://mofa.gov.mn/exp/blog/10/84>, Сүүлд нэвтэрсэн: 2022.08.08

³⁴ УИХ-ын гишүүн Ч.Ундармын УИХ-03/7498 тоот албан бичигт ХХААХҮЯ-наас илүүлсэн хариунд

³⁵ Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн” тайлан. Эх сурвалж: <https://audit.mn/?p=15813>

сургалт сурталчилгааны ажлыг хийдэг боловч үр дүнг тооцдоггүй, иргэдийн хоол тэжээлийн талаар мэдлэг боловсрол дээшилсэн эсэхийг үнэлж дүгнэдэггүй нийтлэг зөрчил илэрч байна.” гэж дүгнэсэн нь органик хүнс үйлдвэрлэлт, хэрэглэгчдэд мэдээлэл түгээх асуудалд ч хамааралтай байна.

Дээрхээс харахад органик хүнс үйлдвэрлэлийн сүлжээг бодлого, арга зүйгээр хангах, хянах, бүртгэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын сургалт, мэдлэг, мэдээлэл олгох ажил хангалтгүй байна. Тухайлбал, өнгөрсөн 5 жилийн хугацаанд мэргэжлийн хяналтын, үндэсний итгэмжлэлийн зэрэг байгууллагууд энэ салбарт ажиллах мэргэжилтнүүд, улсын байцаагчид, органик үйлдвэрлэгчдийн түвшинд жилд дунджаар нэг удаа сургалт зохион байгуулснаас дийлэнх нь Органик хүнсний тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой зохион байгуулагджээ. Түүнчлэн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийн байгууллагаас органикаар баталгаажсан бүтээгдэхүүнийг хуурамч бараа бүтээгдэхүүнээс ялгах, хэрэглэгчдийг органик хүнсний бүтээгдэхүүний тэмдэг, тэмдэглэгээ болон органик бус бүтээгдэхүүнээс ялгах мэдлэгтэй болгох асуудлаар 2019 онд бусад байгууллагуудтай хамтарсан хяналтад оролцсоноос өөр тодорхой ажил хийгээгүй байна.

Органик үйлдвэрлэл эрхлэгчид, хяналт шалгалт, үнэлгээ хийх эрх бүхий байгууллага, албан тушаалтан зэрэг органик аж ахуй эрхлэхтэй холбоотой сургалтад хамрагдах шаардлагатай хүмүүст мэдлэг олгох сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах асуудал хариуцсан байгууллага, сургалтын хөтөлбөр өнөөг хүртэл байхгүй байгаа нь дээрх дурдсан хуулийн зохицуулалтын хийдлээс үүдэлтэй гэж үзэж болох юм.

Органик хүнстэй холбоотой мэдээллийг ил тод, ойлгомжтой байдлаар нийтлээгүй байна. ХАА-н салбарт органик үйлдвэрлэл эрхлэгчдийн дийлэнх нь локал буюу өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэлийн хэмжээнд үйл ажиллагаа эрхлэгчид байх ба хүнсний сүлжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомжууд, олон зуун стандарт, журам, дүрмүүдийн талаар мэдээлэлгүй байдаг. Гэвч төрийн бодлого, үйл ажиллагааны түвшинд онцгой анхаарал хандуулж буй органик аж ахуй эрхлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, органик бүтээгдэхүүний баталгаажуулах, экспортлох зэрэг үйл ажиллагаанд тавигдах шаардлага, статистик мэдээллүүдийг цогц байдлаар нийтийн хүртээл болгосон төрийн болон хувийн хэвшлийн байгууллага байхгүй байна. Хууль тогтоомжийг нэг дор байршуулах хамгийн боломжтой Органик хүнсний бүртгэл, мэдээллийн сан, organic.gov.mn-д энэ чиглэлийн хууль, эрх зүйн актуудыг байршуулаагүй, ХХААХҮЯ, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газар зэрэг ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэгч, түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, борлуулагч, хэрэглэгчдэд хамгийн ойр үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын цахим хуудсанд ч мөн адил энэ төрлийн мэдээлэл байхгүй байна. Тухайлбал, Органик хүнсний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т органик үйлдвэрлэл эрхлэгчид “*ойн дагалт баялаг болон байгалийн ургамал ашигласан тохиолдолд сүүлийн гурван жилийн туршид энэ хуулийн 8.3-т зааснаас өөр бодисоор ариутгал, халдваргүйжүүлэлт хийгээгүй талаар байгаль орчин болон хүнс, хөдөө ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлсон талбайгаас*

түүх;”, ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах журмын 2.9-д “Ойн дагалдах баялаг болон байгалийн ургамлыг түүж ашиглахдаа органик бус фермерийн аж ахуй, авто зам болон бохирдлын эх үүсвэрээс нэг км-ээс багагүй зайд байрлах хил зааг нь тодорхойлогдсон, нөөцийн үнэлгээ нь хийгдэж, байгаль орчны улсын нэгдсэн мэдээллийн санд бүртгэгдсэн талбайгаас түүнэ.” гэх шаардлага тавьсан боловч эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, legalinfo.mn, ХХААХҮЯ-ны mofa.gov.mn, Байгаль орчны мэдээллийн сан, www.eic.mn-д “байгаль орчин болон хүнс, хөдөө ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлсон талбай”-н талаар мэдээлэл байхгүй байгаа нь ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэгчдэд хүндрэл үүсгэхээр байна. Үүнийг Үндэсний аудитын газраас 2021 онд гүйцэтгэсэн “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн” аудитын тайланд³⁶ “хүн амыг чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр жигд тогтвортой хангахад хүнсний хангамж, хүртээмж, шим тэжээл, хүнсний аюулгүй байдлын статистик мэдээг олон улсын түвшинд нийцсэн аргачлалаар, үнэн зөв, бодитой тооцох нь чухал байна” гэж дүгнэснээс харж болох юм.

Түүнчлэн ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах журмын 2.4.10-т заасны дагуу Хамтын баталгаажуулалтын байгууллагууд бүтэц, зохион байгуулалт, хяналт шалгалт, баталгаажуулалтын үйл ажиллагаа, органик үйлдвэрлэлийн талаар олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаа нь дийлэнх баталгаажуулалтын байгууллага цахим хуудас зэрэг мэдээлэл түгээх суваггүй байгаагаас харагдаж байна.

Ерөнхийдөө органик хүнсний холбоотой бүхий л мэдээлэл ХХААХҮЯманд нэгтгэгддэг боловч органик хүнс үйлдвэрлэл, органик хүнсний бүтээгдэхүүн борлуулалтын талаарх төрлөөр ангилсан статистик мэдээлэл тодорхойгүй, нийтэд ил тод бус байна. Үндэсний статистикийн хороо, мэргэжлийн хяналт зэрэг байгууллагуудын статистик мэдээлэлд органик үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүнд холбогдох судалгаа, мэдээллийг тусад нь ангилдаггүй тул Органик хүнсний тухай хууль хэрэгжиж буй 5 жилийн хугацаанд энэ салбарт ямар ахиц дэвшил гарсан талаар үнэлгээ өгөхөд хүндрэлтэй. Тухайлбал, Органик хүнсний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5³⁷-т заасны дагуу ХХААХҮЯ 2021 он хүртэл мэргэжлийн хяналтын байгууллагаас, 2021 оноос Гаалийн ерөнхий газраас органик хүнсийг экспортлох болон импортлох үеийн хяналт, шалгалтын мэдээг улирал тутам авч байгаа боловч органик бүтээгдэхүүн экспортолсон, импортолсон тоо, хэмжээний талаар мэдээлэл байхгүй байна. Үүнээс харахад органик хүнсэнд хамаарах статистик мэдээг тодорхой гаргах боломжгүй байгаа нь холбогдох байгууллагууд органик хүнс үйлдвэрлэл, борлуулалттай холбоотой судалгааг тусад нь гаргадаггүйтэй холбоотой байна. Тухайлбал, экспорт, импортын бүтээгдэхүүний бүртгэл, хяналтын явцад органик гэдэг ангиллаар тусад нь шалгадаггүй, бүртгэдэггүй, харин тухайн

³⁶ Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн” тайлан. Эх сурвалж: <https://audit.mn/?p=15813>

³⁷ Мэргэжлийн хяналтын байгууллага органик хүнсийг экспортлох болон импортлох үеийн хяналт, шалгалтын мэдээг гаргаж, улирал тутам хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

бүтээгдэхүүний БТКУС кодоор нь ангилан бусад бүтээгдэхүүнтэй нэгтгэн бүртгэдэг байна. Жишээлбэл, үндэсний брэнд органик бүтээгдэхүүний нэг болох чацарганы шүүс, охьны тухайд “жимсний шүүс” гэх ангилалд бүртгэх ба органик болон органик бус гэсэн ангилал байдаггүй.

Манай байгууллагын экспорт, импортын бүртгэлд чацарганы шүүсийг органик гэж ангилдаггүй, “жимсний шүүс”-т хамаарах БТКУС кодоор нь ангилсан ерөнхий мэдээ гаргадаг.

Гаалийн байгууллагын ажилтантай хийсэн ярилцлагаас

Үнэлсэн байдал

Органик хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан органик хүнсийг сурталчлах зорилтын хэрэгжилт хангалтгүй байгаа нь тухайн харилцааг уг хууль болон холбогдох журмуудаар зохицуулаагүй, хариуцах этгээд тодорхойгүй зэрэг хуулийн хийдэлтэй холбоотой байна. Органик хүнсний тухай хуулийн зорилт хэсгийг “Хэрэглэгч органик хүнсний бүтээгдэхүүний тэмдэг, тэмдэглэгээ болон органик бус бүтээгдэхүүнээс ялгах мэдлэгтэй болсон байна.” томъёоллоор “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтийн дагуу реклам, зар сурталчилгаа, сургалт, судалгаа болон мэдээллийн ил тод байдал гэсэн 4 чиглэлээр үнэлж үзэхэд **“ЗОРИЛГОДОО ХҮРЭЭГҮЙ”** гэж үнэллээ.

1. ХАА-н органик хүнс үйлдвэрлэл, органик бүтээгдэхүүний талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй реклам, зар сурталчилгаа, мэдлэг, мэдээлэл олгох контент хангалтгүй байна. Энэ нь ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэгчдийн дийлэнх нь эдийн засаг, санхүүгийн хувьд бэхжээгүй тул өндөр өртгөөр зар сурталчилгаа, контент бэлтгэх, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх чадамжгүй байгаатай холбоотой байна. Үүнээс шалтгаалан органик үйлдвэрлэгчид социал медиаг өргөнөөр ашиглаж байгаа нь зөвхөн органик хүнс, бүтээгдэхүүн сонирхогчдын түвшинд мэдээлэл хүргэдэг бөгөөд баталгаажсан болон хуурамч органик бүтээгдэхүүнийг ялгах хэмжээнд хэрэглэгчдэд зөв, бүрэн мэдээлэл хүргэх хэмжээнд хүрээгүй байна.
2. Органик ХАА-н үйлдвэрлэл, органик хүнсний бүтээгдэхүүний чиглэлээр хийгдэж буй судалгаа, эрдэм шинжилгээний ажил хангалтгүй, салбарын судалгааны байгууллагуудын үйл ажиллагаа харилцан уялдаагүй, судалгааны ажлын үр дүнг олны хүртээл болгохгүй байна. Хүнс, ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгүүдийн судалгааны ажлуудыг дунд органик хүнс, тэжээл, бордоо, ургамал хамгааллын бодис үйлдвэрлэл болон хүнсний бүтээгдэхүүн боловсруулахтай шууд холбогдох төсөл, судалгааны ажлууд болон үүнд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь цөөн, үйл ажиллагааны төлөвлөгөөндөө энэ чиглэлийн ажил тусгаагүй байна. Эрдэм шинжилгээний байгууллагуудаас гадна хүнс, ХАА-н асуудал хариуцсан төрийн байгууллагууд ч мөн адил энэ тал дээр хангалтгүй ажиллаж байна. Тухайлбал, салбарын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа туршилт, инкубаци, шинжлэх ухааны ололт,

дэвшилтэт техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, дамжуулах, сурталчлах, мэдээ мэдээллээр хангах чиг үүрэг бүхий Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төв энэ чиглэлд ямар үйл ажиллагаа хэрэгжүүлсэн нь тодорхойгүй, органик бүтээгдэхүүний бүртгэл мэдээллийн сан” organic.gov.mn³⁸-д цахим хуудасны мэдээлэл, зөвлөгөө өгөх хэсгүүд 2018 оноос хойш шинэчлэгдээгүй байна.

3. Органик аж ахуй эрхлэгчид, органик хүнс үйлдвэрлэгчид, хяналт шалгалт хийх эрх бүхий этгээдүүд болон хэрэглэгчдэд зориулсан сургалт, нөлөөллийн ажиллагаа хангалтгүй хэрэгжиж байна. Органик хүнсний тухай хуульд сургалт, нөлөөллийн ажиллагаатай холбоотой зохицуулалт байхгүй бол Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журмын 4.3, 5.8-д баталгаажуулалтын байгууллагуудад гишүүдээ сургалтад хамруулах үүрэг хүлээлгэжээ. Гэвч сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах асуудал хариуцах байгууллага тодорхойгүй байгаа нь төрийн байгууллагын зүгээс хэрэгжүүлж буй сургалт, нөлөөллийн ажил зөвхөн тодорхой аян, арга хэмжээтэй уялдсан байдлаар зохиогдоход нөлөөлж байна. Түүнчлэн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах газраас хэрэглэгчдэд зориулсан сургалт, нөлөөллийн ажил огт хийдэггүй нь анхаарах асуудлын нэг юм.
4. Органик хүнстэй холбоотой статистик мэдээ болон органик хүнс үйлдвэрлэгч болон хэрэглэгчдэд шаардлагатай мэдээллийг ил тод, ойлгомжтой байдлаар нийтлэхгүй байна. ХАА-н салбарт органик үйлдвэрлэл эрхлэгчдийн дийлэнх нь өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэлийн хэмжээнд үйл ажиллагаа эрхлэгчид байх тул үйл ажиллагаанд нь холбогдох хууль тогтоомж, стандарт, журам, дүрмүүдийн талаар мэдээлэлгүй байдаг. Гэвч органик аж ахуй эрхлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, органик бүтээгдэхүүний баталгаажуулах, экспортлох зэрэг үйл ажиллагаанд тавигдах шаардлага, статистик мэдээллүүдийг цогц байдлаар нийтийн хүртээл болгосон төрийн болон хувийн хэвшлийн байгууллага байхгүй байна. Түүнчлэн ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах журмын 2.4.10-т заасны дагуу Хамтын баталгаажуулалтын байгууллагууд бүтэц, зохион байгуулалт, хяналт шалгалт, баталгаажуулалтын үйл ажиллагаа, органик үйлдвэрлэлийн талаар олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.
5. Хяналт шалгалт, бүртгэл хийх, мэдээлэл шаардах эрх бүхий төрийн байгууллагууд органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, бордоо, тэжээл, үр, суулгац үйлдвэрлэл, борлуулалтын талаарх статистик мэдээг тусад нь гаргадаггүй, бүртгэдэггүй, тухайн бүтээгдэхүүний нэр, төрөлд нэгтгэн тооцож байгаа нь органик хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой тодорхой судалгаа мэдээлэлгүй байхад нөлөөлж байна.

³⁸ Органик бүтээгдэхүүний бүртгэл мэдээллийн сан. Эх сурвалж: <https://organic.gov.mn> Сүүд үзсэн 2022.08.10

Санал, зөвлөмж

Төрийн зүгээс хүнсний аюулгүй байдал, байгаль орчинд ээлтэй органик аж ахуйн эрхлэлтийг дэмжих бодлого баримталж буй өнөө үед органик хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн болон органик бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэхэд энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах, зөвлөгөө, мэдээлэл, арга зүйгээр хангах асуудал чухал үүрэгтэй. Иймээс уг асуудалтай холбогдуулан дараах саналыг хүргүүлж байна.

1. ХАА-н органик хүнс үйлдвэрлэл, органик бүтээгдэхүүн, шошгын талаар реклам, зар сурталчилгаа, мэдлэг, мэдээлэл олгох контент бүтээх, хандалт өндөртэй хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээхэд дэмжлэг үзүүлэх замаар үйлдвэрлэгч, хэрэглэгчийн мэдлэгийг дээшлүүлэх,
2. ХАА-н салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, Монгол орны байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон ХАА-н органик хүнсний үйлдвэрлэлийн арга, дэвшилтэт технологи боловсруулах, органик үр, суулгац, тэжээл, бордоо, ургамал хамгааллын бодис зэрэг чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх, үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд болон инкубатор, загвар аж ахуй, агро парк байгуулахад дэмжлэг үзүүлэх,
3. Органик аж ахуй эрхлэгчид, органик хүнс үйлдвэрлэгчид, хяналт шалгалт хийх эрх бүхий этгээдүүд болон хэрэглэгчдэд зориулсан сургалт, нөлөөллийн ажиллагаа зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх бүтэц/байгууллагатай болох,
4. Органик хүнстэй холбоотой хууль тогтоомж, эрх зүйн акт, статистик мэдээ болон органик хүнс үйлдвэрлэгч болон хэрэглэгчдэд шаардлагатай мэдээллийг ил тод, ойлгомжтой байдлаар нийтлэх,
5. Органик хүнстэй холбогдох статистик судалгааг тодорхой болгох,

БАТАЛГААЖУУЛАЛТ - БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ - ЭРХ, ҮҮРЭГ

Органик хүнсний үйлдвэрлэл нь ХАА-н тогтвортой хөгжлийг бий болгох, хөрс, ус, агаарын бохирдлыг бууруулах экосистемийн тэнцвэрт байдлыг хангах, зах зээлийг аюулгүй, чанартай хүнсний бүтээгдэхүүн болон түүхий эдээр хангах, хүний эрүүл мэнд, амь нас, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хамгаалах, цаашлаад нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгаар олж буй орлогыг нөхөх нөхцөлийг бүрдүүлэх замаар улс орны эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой. ХАА-н органик үйлдвэрлэлийн үндсэн зорилго нь органик бордоо, тэжээл ашиглах, уламжлалт болон дэвшилтэт технологи ашиглан аливаа химийн бодис, пестицид ашиглалгүйгээр эрүүл хөрснөөс эрүүл хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж хэрэглэгчдэд хүргэхэд чиглэдэг үндсэндээ “хаалттай” тогтолцоо байх юм.

Төрөөс 2030 он гэхэд органик хүнсний үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж хүнс, ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 5 хувьд хүргэж органик баталгаажуулалтад хамруулах зорилт дэвшүүлээд буй энэ үед органик хүнсийг үнэн зөв баталгаажуулах,

баталгаажуулалтын байгууллагуудын ур чадвар, мэдлэг чадавхыг дээшлүүлэх, аливаа ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, тэдний үйл ажиллагаанд тавих төрийн хяналтыг үр дүнтэй байлгах, баталгаажуулалтын байгууллагад тавьж буй шаардлага, хүлээлгэж буй эрх, үүрэг нь цаг үе, үйл ажиллагаатай нь бодитой уялдсан байх зэрэг асуудалд илүү анхаарах шаардлага тулгарна.

Иймээс үнэлгээний энэ хэсэгт бид 2030 он гэхэд хэр хэмжээний ХАА-н хүнсний бүтээгдэхүүнийг органикаар баталгаажуулахыг зорьж байна? Баталгаажуулалтын байгууллагууд түүнд бэлэн үү? Органик хөдөө аж ахуйг хөгжүүлэх төрийн байгууллага үйлдвэрлэгчид, хэрэглэгчдэдээ тэгш, хүртээмжтэй хүрч ажиллах боломжтой юу? зэрэг асуудлаар хуулийн 10 зүйлийн хэрэгжилтийг үнэлэхийг зорьлоо.

А. 2030 он хүртэл ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 5 хувийг органик баталгаажуулалтад хамруулахын тулд төрөөс малчид, тариаланчдад органик үйлдвэрлэлийн талаар мэдээлэл түгээх ажлын эрчимжүүлэхээс гадна газар зохион байгуулалтад анхаарч органик бүс байгуулах асуудлыг судлах, органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх бүтэц, орон тоог нэмэгдүүлэх, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх зэрэг олон асуудлаар дорвитой алхам хийх шаардлагатай.

Үнэлгээний хүрээнд Монгол Улс 2030 он гэхэд ХАА-н бүтээгдэхүүний 5 хувь буюу хэр хэмжээний бүтээгдэхүүнийг органик баталгаажуулалтад хамруулах зорилго тавьж буйг тогтоохыг зорьсон бөгөөд салбарын статистик мэдээллийг “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслөөс 2021 онд гүйцэтгэсэн “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн зарлагын шинжилгээ”³⁹-ний үр дүн болон Статистикийн мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээллийг эх үүсвэр болгон ашиглав.


2020 оны байдлаар ХХААХҮСайдын эрхлэх асуудлын хүрээнд багтах 1/ хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 2/боловсруулах үйлдвэрлэл, 3/бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ, 4/зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний үйлдвэрлэл Дотоодын нийт бүтээгдэхүүний /цаашид ДНБ гэх/- ий 32.5 хувийг эзэлжээ.⁴⁰ Үүнээс органик хүнстэй холбогдуулан ХАА-н /цаашид ХАА гэх/ буюу мал аж ахуй /цаашид МАА гэх/, газар тариалангийн салбарыг онцолж үзвэл эдгээр салбарын бүтээгдэхүүн 1995 онд Монгол улсын ДНБ-ий 32.5 хувийг эзэлж байснаа аажмаар буурч сүүлийн 5 жилийн дунджаар ДНБ-ий 11,12 хувийг буюу 8.7-11.4 хувийг МАА, 1.5-2.0 хувийг газар тариалангийн дэд салбар бүрдүүлэх болсон нь уул уурхайн салбарын хөгжил эрчимжиж ХАА-н салбарт ач холбогдол өгөх явдал буурсантай холбоотой байна.

Зураг 5. ДНБ-д МАА, газар тариалангийн эзлэх хувь

³⁹ ХХААХҮЯ, Европын холбоо, UNDP, FAOMN, ILO. 2021. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн зарлагын шинжилгээ. Эх сурвалж: <https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/94d63bb37bcc9594bc73591d1bd0cb479af2b3e67d78d1773b41c3817aa74866.pdf>

⁴⁰ Монгол улсын Үндэсний тооцооны системийн Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар

Зураг 3. ДНБ-д МАА, газар тариалангийн дэд салбарын эзлэх хувь



Эх үүсвэр: УСХ Тайлбар: *-Урьдчилсан гүйцэтгэл


ХАА гаралтай хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн эзлэх хувь бага байгаа нь импортоос хараат байдалд нөлөөлөх хүчин зүйл болдог. Тухайлбал, манай улсын хүнсний хангамжид загас 100 хувь, шувууны мах 96.6 хувь, сүүн бүтээгдэхүүн 30.7 хувь, гурилан бүтээгдэхүүн 34.1 хувь, төрөл бүрийн будаа 100 хувь, хүнсний ногоо 44 хувь, жимс жимсгэнэ 96.7 хувь, өндөг 47.4 хувь, ургамлын тос 98 хувь, цөцгийн тос 53 хувь, сахар чихрийн зүйл 36.3 хувийн импортын хамааралтай байдаг бол мах, гурил, төмсний хэрэгцээг 97-100 хувь, сүүн бүтээгдэхүүний 69.3 хувь, гурилан бүтээгдэхүүний 65.9 хувь, хүнсний ногооны 56 хувь, жимс жимсгэний 3.3 хувь, өндөгний 52.6 хувь, ургамлын тосны 2 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна.

Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Төрөөс мал аж ахуйн /цаашид МАА гэх/ салбарыг дэмжих зорилгоор 1/Бэлчээрийн мал аж ахуйг зонхилон эрхэлж, хүн ам олноор суурьшсан хот, суурин газрын орчмын болон тариалангийн бүс нутагт ашиг шимийн чиглэлээр төрөлжсөн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх 2/Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах 3/МАА-н гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин, экспортыг нэмэгдүүлэх, гол нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах 4/Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, тээвэр, ложистик, чанарын хяналт, баталгаажуулалтын тогтолцоог сайжруулах, боловсруулалтын түвшинг дээшлүүлэх гэсэн 4 үндсэн зорилтыг Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, салбарын үндэсний хөтөлбөрүүдэд тусгаж, төрөөс бүтээгдэхүүний нийлүүлэлтэд урамшуулал олгох, бэлтгэн нийлүүлэлтэд хөнгөлөлттэй зээл, хүүгийн татаас олгох, хадлан тэжээл бэлтгэх техник, тоног төхөөрөмж нийлүүлэхэд татвар, үнийн хөнгөлөлт үзүүлэх зэрэг дэмжлэг үзүүлж ирсэн нь тус салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ тогтмол өсөхөд нөлөөлжээ. Ялангуяа малын тоо толгой буурсан хэдий ч МАА-н гаралтай бүтээгдэхүүн өсөж байгаагаас эрчимжсэн МАА хөгжих хандлага ажиглагдаж байна. Иймээс МАА-н органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бүрэн боломжтой юм.


Зураг 6: МАА салбарын бодит өсөлт ба малын тооны өсөлт, бууралт⁴¹

Зураг 4. МАА-н салбарын бодит өсөлт болон малын тооны өсөлт, бууралт



Уламжлалт бэлчээрийн мал аж ахуй голлосон МАА-н салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2019 оны гүйцэтгэлээр ДНБ-ний 9.2 хувь, ХАА-н үйлдвэрлэлийн 85.0 хувийг бүрдүүлжээ. МАА-н салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох мах, сүү, ноос, ноолуур, арьс шир, өндөг, зөгийн бал зэргээс сүүлийн 5 жилийн үзүүлэлтээр бүх төрлийн мах, сүү, ноос, ноолуур, арьс ширний үйлдвэрлэл харьцангуй тогтвортой, бага зэрэг өсөх хандлагатай байгаа бол өндөгний үйлдвэрлэл 77.6 хувиар, зөгийн балын 2019 онд 221.5 тонн буюу 2015 онтой харьцуулахад 46.6 хувиар нэмэгдсэн байна. Мөн сүүлийн 5 жилийн байдлаар харахад МАА-н салбарын нийт үйлдвэрлэлийн бодит өсөлт дунджаар 5.4 хувьтай байх боловч сүүлийн жилүүдэд тогтмол өсөж байсан малын тоо толгой 2020 онд 5.5 хувиар буурсан дүнтэй байна.⁴²

График 1 МАА-н үйлдвэрлэлийн өсөлт /мянган төгрөг/⁴³



Статистикийн мэдээллийн санд⁴⁴ байршуулсан мэдээллээс харахад МАА-н гаралтай бүтээгдэхүүн борлуулалтын орлого сүүлийн 5 жилд тогтмол өссөн үзүүлэлттэй байх ба 5 жилийн дунджаар орлогын хэмжээ 5,631,821,400 төгрөг, өсөлтийн хэмжээ дунджаар

⁴¹ МАА салбарын бодит өсөлт ба малын тооны өсөлт, бууралт. Эх сурвалж: <https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/94d63bb37bcc9594bc73591d1bd0cb479af2b3e67d78d1773b41c3817aa74866.pdf>

⁴² ХХААХҮЯ, Европын холбоо, UNDP, FAOMN, ILO. 2021. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн зарлагын шинжилгээ. Эх үүсвэр: <https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/94d63bb37bcc9594bc73591d1bd0cb479af2b3e67d78d1773b41c3817aa74866.pdf>


⁴³ МАА-н үйлдвэрлэлийн өсөлт /мянган төгрөг/ Эх сурвалж: <http://www.1212.mn/>

⁴⁴ <http://www.1212.mn/>

13 хувь байна.⁴⁵ Үүнээс харахад МАА салбарын бүтээгдэхүүний 5 хувь болох 281,591,070 төгрөгийн өртөг бүхий бүтээгдэхүүнийг нэмүү өртөг шингэсэн МАА-н гаралтай органик бүтээгдэхүүн болгох боломж байна.

Органик хүнс үйлдвэрлэлд шилжих боломжтой ХАА-н гол нэрийн бүтээгдэхүүн болох мах, сүүний үйлдвэрлэлийн үзүүлэлтийг сүүлийн 5 жилийн дунджаар авч үзвэл манай улс жилд дунджаар 929,309.3 литр сүү, 526,178.9 тонн мах бэлтгэдэг⁴⁶ бөгөөд статистик мэдээллээс харахад сүүний үйлдвэрлэлийн хэмжээ харьцангуй тогтмол байгаа бол мах үйлдвэрлэлийн хэмжээ 5 жилийн дотор ойролцоогоор 2 дахин нэмэгдсэн нь энэ төрлийн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж байгааг илэрхийлж байна.

График 2: Мах, сүүний үйлдвэрлэл⁴⁷



Дээрхээс харахад МАА-н гаралтай органик хүнс, түүн дотроо 46,4 мянган литр сүү, 26,3 мянган тонн мах, махан бүтээгдэхүүнийг органик хүнсний баталгаажуулалтад хамруулах боломжтой буюу энэ хэмжээний МАА-н гаралтай бүтээгдэхүүнийг 2030 он гэхэд баталгаажуулах зорилго дэвшүүлсэн гэж үзэж болох юм.

МАА-н органик үйлдвэрлэлийн үндэс нь хүн ба амьтан, уул усны амьд тэнцвэртэй холбоог эрхэмлэх, малын төрөлхийн /байгалийн/ зан авир, физиологийн шаардлагад нийцүүлэн тавлаг байдлыг хангах үйл ажиллагааг цогцоор нь хэрэгжүүлэхэд оршино.⁴⁸ МАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүний органик үйлдвэрлэлд тавигдах шаардлагыг ХХААХҮСайдын 2018 оны А-09 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах журам”-аар тогтоосон бөгөөд журмын 3 дугаар бүлэг Органик мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд тавигдах шаардлагуудыг агуулжээ.

⁴⁵ МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, улсаар, жилээр. Эх сурвалж: http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1001_001V1&AIMAG_select_all=0&AIMAGSingleSelect=_0&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2021_2020_2019_2018_2017&viewtype=table

⁴⁶ <http://www.1212.mn/>

⁴⁷ ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, төрлөөр, бүс, аймаг, нийслэлээр Эх сурвалж:

http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1001_041V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=_T1_T2&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=_0&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020_2019_2018_2017&viewtype=table

⁴⁸ Органик хүнснийг боловсруулах, үйлдвэрлэх, шошголох, худалдаалахад баримтлах арга зүйн удирдамж MNS CAC GL 32:2017. Эх сурвалж: <https://estandard.gov.mn>

Хэдийгээр бидний дунд харьцангуй цэвэр, байгалийн унаган төрхөө хадгалсан бэлчээрт уламжлалт аргаар малласан МАА-н гаралтай бүтээгдэхүүнээ экологийн цэвэр, органик байна гэх ойлголт түгээмэл байдаг боловч МАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүн олон улсын болон дотоодын хууль тогтоомжид заасан органик мал аж ахуйн үйлдвэрлэлд тавигдах шаардлагыг хангахгүй байгаа нь Органик хүнсний тухай хууль 2017 онд хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд МАА-н гаралтай бүтээгдэхүүн бусад төрлийн органик бүтээгдэхүүнээс бага байхад нөлөөлж байна. Тухайлбал, журмын 10.1-д “Мал амьтныг байгалийн бэлчээрт уламжлалт аргаар маллах, байгалийн болон тарималжуулсан органик бэлчээрт жилд 120 хоногоос дээш хугацаанд бэлчээж, бусад хугацаанд энэ журамд нийцүүлэн байран маллах замаар органик мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхэлнэ”, 11.3-т “Органик мал аж ахуйн үйлдвэрлэлийг органик бус мал аж ахуйн үйлдвэрлэлтэй нэг дор хавсарч, тусгаарласан, эсхүл зэрэгцээ байдлаар эрхлэхгүй.” зэрэг зохицуулалтын хэрэгжилтийг хангахад хүндрэлтэй байдаг. Үүний тод жишээ бол ХХААХҮЯ-наас гаргасан судалгаагаар МАА-н гаралтай бүтээгдэхүүнийг органик болон шилжилтийн үеийн баталгаажуулалт хийлгэх хүсэлт зөвхөн 2021 оноос эхлэн ирсэн бөгөөд сүү, сүүн бүтээгдэхүүний баталгаажуулалт хийлгэсэн хэмжээ 2022 онд 32 төрөл байгаа бол мал, махны 5 төрөл шилжилтийн үед бүртгүүлээд байна. Өнгөрсөн жил гаруй хугацаанд органикаар баталгаажсан сүү, сүүн бүтээгдэхүүний төрөл нэмэгдсэн ч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ тодорхойгүй байна.



Органик сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээрээ анхдагч “Үлэмж органик” ХХК нь өдөрт 3000 литр сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах хүчин чадалтай⁴⁹ бөгөөд сүү, тараг, аарц, эдэм гээд органикаар баталгаажсан 10 төрлийн бүтээгдэхүүнээ⁵⁰ 15 сүлжээ дэлгүүр, 300 гаруй супермаркет болон минимаркетуудаар худалдаалдаг. Уг аж ахуйн нэгжээс гадна Органик хүнсний бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй Silk Road Magic LLC, Монтаримал ХХК, 2 хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1 хоршоо мал аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэгчээр

бүртгүүлэх болзол ханган органик сүү, аарц, ааруул, мах зэрэг бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлж байна. Эдгээр үзүүлэлтээс харахад манай улс жилд ойролцоогоор 2 мянган литр органик сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа нь зорилтот 46,4 мянган литр сүү, сүүн бүтээгдэхүүнийг органикаар баталгаажуулахын тулд органик МАА эрхлэгчдийг төрөөс дэмжих, органик үйлдвэрлэл эрхлэх журам, шаардлага зэргийг сурталчлах, таниулах, органик бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэх боломж, нөхцөлийн

⁴⁹ Монгол үнээний сүүгээр бүтсэн, “Үлэмж органик” брэнд. 2019. Эх сурвалж: <https://bossclub.mn/монгол-үнээний-сүүгээр-бүтсэн-үлэмж-о/>

⁵⁰ <https://organic.gov.mn/?#/company/manufacturers/5f584dc5dd923418e44daafd>

талаар мэдээлэл түгээхээс гадна баталгаажуулалт, бүртгэл хийх эрх бүхий байгууллага, нэгж, албан тушаалтны тоонд ч мөн анхаарах шаардлагатай.

Өмнө дурдсанчлан МАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүн дундаас 26,3 мянган тонн мах, махан бүтээгдэхүүнийг органик хүнсний баталгаажуулалтад хамруулах боломжтой. Гэвч органикаар баталгаажиж, бүртгүүлсэн мал, мах үйлдвэрлэлийн хэмжээ маш бага байна. Тухайлбал, 2021 онд 5 төрлийн үхрийн махыг органик шилжилтийн үеийн бүртгэлд бүртгүүлсэн байх ба зах зээлд нийлүүлж буй органик мах, махан бүтээгдэхүүний хэмжээ тодорхойгүй байгаа нь нэг талаас статистик мэдээг боловсронгуй болгоход анхаарах шаардлагатайг харуулж байна.

Малчид органик МАА-д тавигдах шаардлагын талаар мэддэггүй. Хаалга тогшоод, манай мал эрүүл бэлчээрийн мал, органик гэрчилгээ авъя, хаана хэдэн төгрөг төлөх үү? гээд ороод ирдэг. Би энд ямар хууль, журам байдаг талаар бараг хичээл ороод гаргадаг.

ХХААХҮЯ-ны мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг хариуцаж буй нэгж, албан хаагчдын тоог авч үзвэл Улсын хэмжээнд Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг хариуцаж буй бие даасан төрийн байгууллагын нэгж байхгүй. Харин хүнсний асуудал хариуцсан 2 нэгжид Органик хүнсний асуудал хариуцсан тус бүр нэг албан хаагч буюу ХХААХҮЯ-ны Хүнсний үйлдвэрийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Органик хүнс, хүнсний сав баглаа боодлын аюулгүй байдлын асуудал хариуцсан ахлах шинжээч-1, НЗДТГ-ын харьяа Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний үйлдвэрлэлийн хэлтсийн органик хүнсний үйлдвэрлэл хариуцсан нэг мэргэжилтэн байдаг.

ХХААХҮЯ-наас ирүүлсэн мэдээлэл

МАА-н гаралтай бүтээгдэхүүнийг органик үйлдвэрлэлийн төрөл, хэмжээ бага байхад нөлөөлөх хүчин зүйлсийг судалж үзэхэд юуны өмнө малчид, МАА-н гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн дунд органик үйлдвэрлэлийн талаар мэдлэг муу, өндөр зардал, төвөгтэй ажиллагаа шаарддаг органик баталгаажуулалт хийлгэсэн ч түүний үр өгөөж нь тодорхойгүй, ул мөр мөшгөх тогтолцоо зэрэг бүртгэл, мэдээллийн ажлыг хөтлөх хүн хүч дутмаг зэргээс шалтгаалан хэрэгжүүлэхэд хүндрэлтэй зэрэг асуудлууд нөлөөлөхөөс гадна тэднээс үл хамаарах дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, уул уурхай, газар тариалангийн салбарын тэлэлт, шинээр үүсэж буй хортон шавьж, өвчин эмгэг гээд олон хүчин зүйлээс шалтгаалан бэлчээр, усны хомсдол үүсэж байгаа нь органик МАА-г тогтвортой эрхлэхэд хүндрэл үүсгэж байна. Тухайлбал, бэлчээрийн газрын ангиллаас хот суурин газрын дэд бүтэц, уул уурхайн ашигт малтмал, газар тариалан зэрэг өөр ангилалд шилжих, үерийн усны эвдрэлд орох, элсний нүүдэл зэргээс шалтгаалан бэлчээрийн талбайн хэмжээ багассаар байгаа ба 2019 оны бэлчээрийн талбайн хэмжээг 1964 оныхтой харьцуулан үзэхэд бэлчээрийн талбай 10.1 сая га-гаар багассан⁵¹, Монгол орны тал хээрийн бүс нутгийн 17 аймгийн 38.6 сая га

⁵¹ Бэлчээрийн хүрэлцээ, хангамж. ХХААХҮЯ. 2019. Эх сурвалж: <https://mofa.gov.mn/exp/blog/7/6>


талбайд үлийн цагаан оготны тархалт хувийн байх хэмжээнээс хэтэрсэн бөгөөд энэ нь нийт бэлчээрийн 34.46 хувийг эзэлж бэлчээрийн даацыг доройтуулж байгаа⁵² талаар салбарын яам мэдээлсэн байна.

Иймээс цаашид органик МАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх, МАА-н гаралтай бүтээгдэхүүнийг органик үйлдвэрлэлд шилжүүлэхийн тулд төрөөс органик мал арчилгаа, маллагаа, тээвэрлэлт, нядалгаа зэрэг асуудлаар малчдын мэдлэгийг дээшлүүлэхээс гадна эн тэргүүнд газар зохион байгуулалтын асуудалд онцгой анхаарч, тухайлбал, органик мал аж ахуй эрхлэх бүс бий болгох, тэнд уул уурхай, органик бус газар тариалангийн талбайн зөвшөөрөл олгохгүй байх, хортон шавж, ургамалтай зөвхөн органик аргаар тэмцэх зэрэг арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Газар тариалан, хүнсний ногоо

Газар тариалангийн тухайд тус салбар нь 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын ДНБ-ий 1.8 хувь, ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 15 хувийг бүрдүүлсэн ба сүүлийн 5 жилд дунджаар 5.4 хувиар өссөн байна. Газар тариалангийн гол нэр төрлийн бүтээгдэхүүнд үр тариа, төмс, хүнсний ногоо, таримал тэжээл, техникийн ургамал, эмийн болон бусад ургамал, жимс, жимсгэнэ ордог бөгөөд 2020 оны байдлаар үр тарианы тариалалт нийт тариалсан талбайн 72.5 хувийг эзэлж байна. Гэвч буудайн гагийн ургацын хэмжээ дунджаар 10.4 цн байгаа нь бусад улс орнуудтай харьцуулж үзэхэд 1 га-гаас хураан авсан улаан буудайн ургац дэлхийн дунджаас ойролцоогоор 3 дахин, OECD-ийн орнуудаас 4 дахин доогуур байна.⁵³

Зураг 7: Хураасан төмс, хүнсний ногоо, үр тариа, тэжээлийн ургамлын хэмжээ 1996-2021⁵⁴



⁵² Бэлчээрийн ургамал хамгаалал. ХХААХҮЯ. 2019. Эх сурвалж: <https://mofa.gov.mn/exp/blog/7/241>

⁵³ ХХААХҮЯ, Европын холбоо, UNDP, FAOMN, ILO. 2021. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн зарлагын шинжилгээ. Эх үүсвэр: <https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/94d63bb37bcc9594bc73591d1bd0cb479af2b3e67d78d1773b41c3817aa74866.pdf>

⁵⁴ Хураасан төмс, хүнсний ногоо, үр тариа, тэжээлийн ургамлын хэмжээ. 1996-2021 онд. Эх сурвалж: http://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L10_2&type=description

Дотоодын нийт хэрэглээний 50 орчим хувийг хангаж буй хүнсний ногооны үйлдвэрлэлийн түвшинд органикаар баталгаажсан хүнсийг хамгийн ихээр үйлдвэрлэж байгаа ба төмс, хүнсний ногооны тариалалтын хэмжээ жилээс жилд өсөх хандлагатай байгаа боловч органик үйлдвэрлэлд шилжих сонирхолгүй байна.

Хүснэгт 1: Хураасан төмс,хүнсний ногоо, үр тариа, тэжээлийн ургамал/тонн. 2017-2021

Хураасан ургац	2017	2018	2019	2020	2021	5 жилийн дундаж	Зорилтот 5%
Хүнсний ногоо	82,102	100,731.7	99,546.6	121,235.1	121,743.4	105071.8	5253.588
Төмс	121,808.5	168,882.6	192,239.9	244,261.6	182,638.2	181966.2	9098.308
Үр тариа	238,101.9	453,849.2	433,305.4	430,317.9	614,497.2	434014.3	21700.72
Таримал тэжээл	47,894.9	123,839.9	121,117.2	182,090.5	293,676.3	153723.8	7686.188

Сүүлийн 5 жилд тариалсан төмс,хүнсний ногоо, үр тариа, тэжээлийн ургамлын дундаж хэмжээнд суурилан 2030 он хүртэл газар газар тариалангийн бүтээгдэхүүний 5 хувийг органик баталгаажуулалтад хамруулах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд бид жилд 5253.5 тонн хүнсний ногоо, 9098.3 тонн төмсийг органик баталгаажуулалтад хамруулах шаардлагатай. Харин одоогоор органик үйлдвэрлэлд огт шилжээгүй үр тариа, таримал тэжээлийг органик үйлдвэрлэлд шилжүүлэх тухайд онцгой анхаарал хандуулах шаардлагатай юм. Үр тариаг органик үйлдвэрлэлд шилжүүлснээр нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, нэмүү өртөг шингэсэн органик гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжих суурь болох юм.

Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид маань үнэхээр хэцүү. Органик түүхий эд байхгүйгээс бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүсэл байсан ч боломж байдаггүй. Үр тариаг байнга борддог, хөрс хамгаалах, зэрлэг ургамал устгах бодисын хэрэглээнээс гадна тариалалтын талбайн арчилгаа ч органик шаардлагад нийцэхгүй гээд асуудал их.

ХХААХҮЯ-ны мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

Органик хүнсний үйлдвэрлэлд тариалангийн талбай чухал нөлөөтэй. Статистикийн мэдээллийн нэгдсэн санд байршуулсан газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй талбайн хэмжээний талаарх мэдээллээс харахад хүнсний ногоо, үр тариа, таримал тэжээл тариалах талбайн хэмжээ тогтмол өсөлттэй байгаа бөгөөд 5 жилийн дундаж үзүүлэлтээр нь тооцвол 9057.09 га-д хүнсний ногоо, 15412.17 га-д төмс, 382580.5 га-д үр тариа, 46152.31 га-д таримал тэжээл тарьж байгаагаас таримал тэжээл тариалах талбайн хэмжээ 5 жилийн дотор 2,8 дахин өссөн нь анхаарал татаж байна.


Хүснэгт2: Тариалсан талбайн хэмжээ/га 2016-2020

Хураасан ургац	2016	2017	2018	2019	2020	5 жилийн дундаж	Зорилтот 5%
Хүнсний ногоо	9,052.16	8,356.61	8,865.81	8,438.36	10,572.51	9057.09	452.8545

Төмс	15,024.34	15,147.78	12,924.94	14,941.92	19,021.89	15412.17	770.6087
Үр тариа	377,802.15	390,860.18	366,809.35	369,445.24	407,985.76	382580.5	19129.03
Таримал тэжээл	29,893.35	26,222.59	46,308.93	43,799.09	84,537.59	46152.31	2307.616

Дээрх үзүүлэлтээс харахад манай улс 5 жилийн дундаж үзүүлэлтээр 1 га талбайгаас 11,6 тонн хүнсний ногоо, 11,8 тонн төмс, 1,3 тонн үр тариа, 3,3 тонн таримал тэжээл хураадаг. Иймээс 2030 онд ХАА-н үйлдвэрлэлийн 5 хувийг органик баталгаажуулалтад хамруулах зорилгодоо хүрэхийн тулд 5,253.5 тонн хүнсний ногоо тариалах 452,8 га газар, 9,098.3 тонн төмс тариалах 770 га газар, 21,700 тонн үр тариа тариалах 19,129 га газар, 7,686 тонн таримал тэжээл тариалах 2,307 га газрыг хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн органик бус газар тариалан, мал аж ахуй, уул уурхай, хот суурин газраас тусгаарлах бэлтгэл хангах шаардлага үүсэхээр байна. Ялангуяа газар тариалан эрхэлж буй талбайн хэмжээг бүс нутгаар нь авч үзвэл хүн амын суурьшил өндөртэй, уул уурхай эрчимтэй хөгжиж буй бүс нутгуудад газар тариалангийн талбайн дийлэнх хэсэг нь оршиж байгаа нь цаашид ХАА-н органик хүнсний бүтээгдэхүүнээр олон улсын зах зээлд өрсөлдөх, экспортыг нэмэгдүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд газар зохион байгуулалт, төлөвлөлт чухал үүрэгтэй болох нь харагдаж байна.


График 3. Тариалсан талбайн хэмжээ бүс нутгаар/га 2020⁵⁵



Органик газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд тариалан эрхлэгчдийг шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах, арга зүй, санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай. Манай улсад тариалан эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо тогтмол өсөлттэй байна.

⁵⁵ ТАРИАЛСАН ТАЛБАЙ, ургамлын төрлөөр, улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, жилээр. Эх сурвалж: http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1001_038V2&BAG_select_all=0&BAGSingleSelect=_0_1_3_26534_4_5_2&TURUL_select_all=0&TURULSingleSelect=_1_2_3_112&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2021_2020_2019_2018_2017_2016&viewtype=table

График 4: Тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний тоо⁵⁶



Үүнээс харахад төрийн зүгээс газар тариалан эрхлэгч 20 орчим мянган аж ахуйн нэгж, иргэнд органик хүнс үйлдвэрлэлийн талаар мэдээлэл түгээх, эдгээрээс органик үйлдвэрлэлд шилжих хүсэлтэй, боломжтой тариаланчдыг судалгаа мэдээлэл, арга зүйгээр хангах бүтэцтэй байх шаардлага үүсэх юм. Иймээс төрийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудад органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих, туслалцаа үзүүлэх бүтэц, орон тооны зохицуулалт хийх асуудал тулгамдаж байна.

Хүнсний ногоо тариалдаг, хүлэмжийн аж ахуй эрхэлдэг хүмүүс бүгд л өөр өөрийн хөрөнгө, цаг хугацаа, хүч хөдөлмөрөө барж байж туршилага суудаг. Орон гэрээ зардаг ч юм уу, банкнаас зээл аваад хөдөлдөг. Гэтэл манай орны хөрс, цаг агаарын нөхцөлд, аль газарт, аль хөрсөнд нь ямар ургамал ургуулах нь ашиг шимтэй, хэрхэн тариалбал үр өгөөжтэй байх талаар зөвлөгөө мэдээлэл өгдөг, туршилт судалгааныхаа үр дүнг хуваалцдаг байгууллага гэж байхгүй. Иймээс ихэнх нь дампуурдаг дүр төрх байсаар байна. Энгийн жишээ дурдахад органик үйлдвэрлэлтэй холбоотой асуудал дандаа гадны төслөөр хэрэгждэг. Төсөл эхлэхдээ мөнгөтэй сайхан, харин дуусаад гараад явахаар тэр ажлыг үргэлжлүүлээд аваад явчих газар байдаггүй. Босгосон бүхэн нь хий хоосон зүйл болдог. Ийм байхгүйн тулд бид тогтолцооныхоо, бүтцийнхээ асуудлыг шийдэх хэрэгтэй. Одоо бол яаман дээр ганц хүний зүрх сэтгэл дээр л органикийн асуудал тогтдог. Тэр хүн угаасаа ч ганцаараа улсын хэмжээнд органик үйлдвэрлэлийн хянаад, бүртгээд, зохион байгуулаад явах ямар ч боломжгүй.

Органик хөгжил ТББ төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Манай яаманд органик хүнсний асуудал хариуцсан нэг л мэргэжилтэн бий. Мэдээж ганцхан органик хүнсээ хариуцахгүй, өөр асуудлууд ч хариуцна. Яамны зүгээс энэ асуудал дээр хүн нэмэх боломжгүй, хэмнэлтийн горим гээд. Бараг бүгд

⁵⁶ Тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний тоо
http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1002_001V3&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=_0&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2021_2020_2019_2018_2017&viewtype=table

л давхар асуудал хариуцаад сууж байгаа. Улсын хэмжээнд ХАА-н органик үйлдвэрлэлтэй холбоотой асуудал хариуцсан 2 төрийн албан хаагч бий. 1 нь би, нөгөөх нь Нийслэлийн Хүнс, ХАА-н газрын нэг мэргэжилтэн. Ийм бүтэцтэйгээр энэ ажил явж байна. ХХААХҮЯ-ны мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

ХАА-н яамны Тунгалаг мэргэжилтэн байгаа болохоор одоохондоо бид асуудлаа яриад, шийдүүлээд яваад байна. Өөр хүн байсан бол хэцүү, яаманд органик хүнсний талаар мэдэх хүн бараг байхгүйтэй адил. Ялангуяа органик хүнсний ногоонд хамгийн хамааралтай хүнсний ногоо хариуцсан мэргэжилтэн нь энэ талаар мэдлэггүй, өдөр бүр өөр өөр ааштай байдаг нь хүнд. Гэтэл бид хүнсний ногоо тариалж байгаа юм чинь тэр хүн тодорхой хэмжээний мэдлэгтэй байх шаардлагатай санагддаг. Ийм болохоор төрийн байгууллагуудын албан хаагчдын мэдлэгийг сайжруулмаар санагддаг.

Сэлэнгэ органик төслийн ажилтантай хийсэн ярилцлагаас

Органик ХАА-н үйлдвэрлэл эрхлэх, ялангуяа хүнсний ногоо тариалах үйл ажиллагаа ихэвчлэн олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд тодорхой хэмжээнд амжилттай хэрэгжиж байна. Тухайлбал НҮБ-ын ХХААБ-ын “Органик ХАА-г дэмжих” ТСР MON/3503 төслийн хүрээнд органик хүнсний үйлдвэрлэл эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх ажил хийгдэж байсан бол одоо АДРА Монгол олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй Органик ХАА-н түншлэл төслийн хүрээнд “Сэлэнгэ органик” брэндийг үүсгэж Сэлэнгэ аймгийн тариаланчдад органик газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх, органик бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх талаар мэдээлэл, зөвлөгөө, арга зүйн болон санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлэн ажилласан нь ихээхэн үр дүнд хүрсэн байна.



Анх 2019 онд Сэлэнгэ аймгийн 139 ногоочин нэгдэж, “Сэлэнгэ органик” хамтын баталгаажуулалтын байгууллага байгуулж, ХХААХҮЯ-ны “Органик хүнсний бүртгэл, мэдээллийн сан”-д бүртгүүлэн, органик тэмдэг, тэмдэглэгээ ашиглах эрх авч байсан бол өнөөдөр Органик хүнсний бүртгэл мэдээллийн системд бүртгэлтэй ХББ-ын 60 гаруй хувь буюу 11 нь АДРА Монгол төслийн хүрээнд үүсгэн байгуулагдсан Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй хамтын баталгаажуулалтын байгууллага байна.

Сэлэнгэ органик нь газар тариалан болон зөгийн аж ахуй эрхлэгчдийг хоршооны зохион байгуулалттай үйл ажиллагаа эрхлэх орчин нөхцөлийг бүрдүүлэн ажилладаг бөгөөд

эдгээр хоршоод нь дундын хоршоондоо органик бүтээгдэхүүнээ нийлүүлэн хадгалах, тээвэрлэх, борлуулах замаар органик бүтээгдэхүүнээ жилийн дөрвөн улиралд зах зээлд нийлүүлэх боломж бүрдүүлжээ. Одоогоор Органик ХАА-н түншлэл төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн 30 хоршооны 900 гаруй гишүүд Сэлэнгэ органик брэнд хүнсний ногоо, зөгийн бал зэрэг бүтээгдэхүүнээ нийтийн хэрэгцээнд нийлүүлдэг аж.

Харин улсын хэмжээнд тариалж буй газар тариалангийн бүтээгдэхүүний хэдэн хувь нь органикаар баталгаажсан болохыг салбарын яам одоогоор тооцож гаргадаггүй байна. Учир нь органик хүнсний ногоо тариаланчдаас ирүүлж буй мэдээг хүлээн авах, боловсруулах программ хангамжид мэдээллийг хэрхэн ангилж оруулах, боловсруулах асуудал шийдэл олоогүй. Иймээс үйлдвэрлэгчид гараар бөглөсөн маягтыг pdf форматаар мэдээллийн системд оруулдаг тул тоо хэмжээг гаргахын тулд тариаланч, баталгаажуулалтын байгууллага нэг бүрээр тариалсан ногооны хэмжээг нэмж тооцох шаардлагатай зэрэг хүндрэлээс шалтгаалан өнөөдөр Монгол Улсад органикаар баталгаажсан хүнсний хэмжээг тодорхойлох байгууллага байхгүй байна.

Органик хүнс үйлдвэрлэлийн хэмжээг тогтооход маш их цаг хугацаа орохоор байна. Бүх үйлдвэрлэгчийн ирүүлсэн материал тус бүрлүү орж, төрөл тус бүрээр нь нэмэх шаардлага үүсээд байна л даа. Ингээж байж нийт мэдээлэл гарна. Үүнийг хийх цаг зав гарахгүй байна. Уг нь программаа засаад төрлөөр нь хэмжээгээр нь оруулдаг болох шаардлагатай. Гэхдээ одоо лууван гэхэд л хэдэн янз бий, яг яаж ангилж оруулах талаар тогтоож чадахгүй байна.

ХХААХҮЯ-ны мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

ХХААХҮСайдын 2018 оны А-09 дугаар тушаалаар баталсан “ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах журам”-ын Хоёрдугаар бүлэг Органик газар тариалангийн үйлдвэрлэлд, 4 дүгээр бүлэг Органик зөгийн аж ахуй эрхлэхэд, Тавдугаар бүлэг Органик хүнсийг боловсруулах үйлдвэрт тавигдах шаардлагуудыг тогтоосон байдаг бөгөөд органик газар тариалан, зөгийн аж ахуй эрхлэгчдийн хувьд мөн адил газрын асуудал хүндрэл учруулж байна. Тухайлбал, журмын 8.3-т “Нийслэл хот, бусад төвлөрсөн хот суурин газарт эрлэх органик газар тариалангийн үйлдвэрлэл нь ачаалал ихтэй (жилийн дундаж үзүүлэлтээр тооцоход өдөрт 3,000-аас олон машин, тээврийн хэрэгсэл зорчих) зам, уулзвараас 250м, хүнд, хөнгөн үйлдвэрийн байгууламжаас 1000 м болон түүнээс дээш зайд байрлана”, 15.1-д “Зөгийн суурь /балт ургамлын нөөцтэй бэлчээрт байрлуулсан хэсэг бүл/-ийг түүнээс 3 км-ын радиус бүхий тойрог дотор сүргийн тэжээлд хүрэлцэхүйц хэмжээний балт, тоост ургамал, усны эх үүсвэртэй органик газар тариалангийн болон атаршсан талбай, байгалийн бэлчээрт байршуулна.”, 15.2-т “Энэ журмын 15.1 дэх хэсэгт заасан байршил нь органик бус тариалангийн талбай, эсхүл бохирдлын эрсдэл өндөртэй (хувиргасан амьд организм ашигласан таримлын талбай, суурин газар, үйлдвэрийн болон уул уурхайн бүс, асфальтан автозам, хогийн цэг, гэх мэт) газраас 5 км болон түүнээс дээш зайд алслагдсан байна.”, 8.5-д “Органик газар тариалангийн үйлдвэрлэл нь органик бус аж ахуйгаас зурвас, саадаар тусгаарлагдсан байна” зэрэг орон зайн хязгаарлалт тогтоосон зохицуулалт цөөнгүй бий. Гэтэл органик бус газар тариалан, уул

уурхай, аялал жуулчлал эрхлэх, хүнд хөнгөн үйлдвэр байгуулах, суурин газар байгуулах газар ашиглах, эзэмших эрхийг төрийн болон орон нутгийн хэд хэдэн байгууллага олгодог, газар олголт урт болон дунд хугацааны төлөвлөлтгүй хэрэгждэг, мөн иргэн, аж ахуйн нэгжүүд өөрийн эзэмшил, өмчлөлийн газартаа дурын ажил, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэх боломжтой зэргээс шалтгаалан багагүй хөрөнгө, хүч хөдөлмөрөөр бүтсэн органик газар тариалангаас гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн органик шаардлага хангахгүй болох эрсдэл өндөр байгаа бол органик зөгийн аж ахуй эрхлэгчдэд журмын шаардлага хангасан талбай олоход цаг хугацаа, зардал их шаардагдаж байгаа нь бүтээгдэхүүний үнийн өсөлт болон борлуулалтын хэмжээнд нөлөөлөх эрсдэлтэй байна.

2.1.2. Хуулийн 10 дугаар зүйлийг “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

4	10 дугаар зүйл. Баталгаажуулалтын байгууллага, органик үйлдвэрлэл болон хүнсний баталгаажуулалт, бүртгэл 10.1.Органик үйлдвэрлэлийн болон органик хүнс, тэжээл, бордооны баталгаажуулалтыг доор дурдсан байгууллага гүйцэтгэнэ: 10.1.1.Монгол Улсын эрх бүхий байгууллагаар итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага; 10.1.2.Монгол Улсад бүртгэлтэй, гадаад улсын итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага. 10.2.Энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэсэн хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан үйлдвэрлэгч, хэрэглэгч болон бусад тал хамтран баталгаажуулах бол хүнс, ХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.	Органик хүнсийг баталгаажуулах байгууллагыг итгэмжлэх үйл ажиллагаа тодорхой байна.
7	10.7.Энэ хуулийн 10.1, 10.2-т заасан баталгаажуулалт хийсэн этгээд дараахь үүрэгтэй: 10.7.1.органик үйлдвэрлэл эрхлэгчтэй энэ хуулийн 6.2-т заасан гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангуулж ажиллах;	Гэрээний хэрэгжилтийг хянах тогтолцоо хөндлөнгийн, ашиг сонирхлын зөрчилгүй байна.
2	8 дугаар зүйл. Органик үйлдвэрлэл эрхлэгчид тавих шаардлага 8.1.Органик үйлдвэрлэл эрхлэгч Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаас гадна дараахь шаардлагыг хангасан байна: 8.1.1.органик үйлдвэрлэлийн үйл явц болон органик хүнсийг хоёр жил тутамд баталгаажуулалтад хамруулах; 8.1.2.баталгаажуулалтын зардлыг хариуцах;	Органик үйлдвэрлэл эрхлэгчид тавигдах шаардлага органик үйлдвэрлэл эрхэлснээр эдийн засгийн хувьд хүрэх үр дүнд нийцсэн байна.

Томьёолол

Органик хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн баталгаажуулалтын байгууллагыг итгэмжлэх харилцааг зохицуулсан 10.1, 10.2 дахь хэсгийг “Органик хүнсийг баталгаажуулах байгууллагыг итгэмжлэх үйл ажиллагаа тодорхой байна.” болон баталгаажуулалтын байгууллагаас гэрээний хэрэгжилтийг хангуулахтай холбоотой харилцааг зохицуулсан 10.7 дахь хэсгийг, “Гэрээний хэрэгжилтийг хянах тогтолцоо хөндлөнгийн, ашиг сонирхлын зөрчилгүй байна.” гэх томьёоллоор “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэллээ.

Судалсан байдал

Органик хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлд ХАА-н органик хүнсний бүтээгдэхүүнийг баталгаажуулах эрх бүхий байгууллагуудыг тодорхойлсон. Хуулийн зохицуулалтаас харахад органик хүнсний баталгаажуулалтыг хуулийн этгээдийн буюу хөндлөнгийн баталгаажуулалтын хэлбэр, хамтын оролцоонд суурилсан буюу хамтын баталгаажуулалтын хэлбэрээр хэрэгжиж байна. Тодруулбал, органик хүнсний баталгаажуулалт хийх эрх бүхий байгууллага /цаашид ББ гэх/ буюу хуулийн этгээдийн 2 хэлбэрийг хүлээн зөвшөөрснөөс нэг нь дотоодын эрх бүхий байгууллагаас итгэмжлэгдсэн ББ, нөгөө нь гадаад улсын эрх бүхий байгууллагаас итгэмжлэгдсэн, Монгол Улсад бүртгэгдсэн ББ байна.⁵⁷ Үүнээс гадна үйлдвэрлэгч, хэрэглэгч болон бусад талуудын оролцоог хангасан, харилцан бие биеийхээ үйл ажиллагаанд хяналт тавих байдлаар органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах эрхийг үйлдвэрлэгч, хэрэглэгчид нөхөрлөл хэлбэрээр хэрэгжүүлэх олгосон⁵⁸ нь өнөөдөр хамгийн түгээмэл ашиглах баталгаажуулалтын төрөл болжээ.

Дээр дурдсан баталгаажуулалтын байгууллагууд нь эрх бүхий байгууллагаар итгэмжлүүлсэн байх шаардлагатай ба итгэмжлэхтэй холбоотой харилцааг Органик хүнсний тухай хууль, MNS ISO 17065: 2013 Тохирлын үнэлгээ — Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээг баталгаажуулах байгууллагад тавих шаардлага⁵⁹, ХХААХҮСайдын 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А-09 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журам⁶⁰ Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн А/10 дугаар тушаалаар “Гадаад орны итгэмжлэлийн байгууллагаас итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагыг бүртгэх журам”⁶¹-аар зохицуулж байна.

Органик хүнсний тухай хууль 2016 онд батлагдаж 2017 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжсэн боловч хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-заасны дагуу баталгаажуулалтын байгууллагуудыг итгэмжлэхтэй холбоотой харилцааг зохицуулах журмуудыг 2018, 2020 онд баталсан нь хуулийн хэрэгжилт удаашралтай байхад нөлөөлжээ. Тодруулбал, 2018 онд ХХААХҮСайдын А-09 дүгээр тушаалаар баталсан Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журмаар 2019 онд анхны хамтын баталгаажуулалтын байгууллагыг итгэмжилж байсан бол Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын

⁵⁷ 10.1.Органик үйлдвэрлэлийн болон органик хүнс, тэжээл, бордооны баталгаажуулалтыг доор дурдсан байгууллага гүйцэтгэнэ:

10.1.1.Монгол Улсын эрх бүхий байгууллагаар итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага;

10.1.2.Монгол Улсад бүртгэлтэй, гадаад улсын итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага.

⁵⁸ 10.2.Энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэсэн хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан үйлдвэрлэгч, хэрэглэгч болон бусад тал хамтран баталгаажуулах бол хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.

⁵⁹ <https://estandard.gov.mn/standard/v/5985>

⁶⁰ <https://legalinfo.mn/mn/detail/13149>

⁶¹ Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн а/10 дугаар тушаал. 2020-10-02. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2020 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн 4884 дүгээрт бүртгэснээр хүчин төгөлдөр болсон. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/15739>

үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль болон MNS ISO 17065: 2013 Тохирлын үнэлгээ — Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээг баталгаажуулах байгууллагад тавих шаардлага стандартын дагуу анхны хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагыг мөн л 2019 онд итгэмжилжээ. Тэгвэл Монгол Улсад бүртгэлтэй гадаад улсын баталгаажуулалтын байгууллага өнөөг хүртэл байхгүй байгаад холбогдох журам 2020 оны 10 сард хэрэгжиж эхэлсэн нь нөлөөлж байна.

Түүнчлэн Монгол Улс 2030 он гэхэд ХАА-н бүтээгдэхүүний 5 хувийг органик баталгаажуулалтад хамруулах зорилттой уялдуулан бүтэц, хүний нөөц, үйл ажиллагааны хувьд чанар, стандартын шаардлага хангасан баталгаажуулалтын байгууллагуудыг бий болгох, үйл ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай. Үүнд хүнсний аюулгүй байдлын асуудал хурцаар хөндөгдсөн энэ үед “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолыг баталсан. Тус тогтоолын 2/ Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авах арга хэмжээний г/⁶², д/⁶³ хэсэгт мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэр, хадгалалт, тээвэрлэлт, худалдаа, үйлчилгээнд стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг мөрдүүлэх, түүнийг баталгаажуулах эрх бүхий итгэмжлэгдсэн байгууллагын тоог нэмэгдүүлэх, мөн хөндлөнгийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар тусгасантай холбогдуулан ХАА-н органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийг баталгаажуулах итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагуудыг бий болгох арга хэмжээ авахаар төлөвлөсөн нь тодорхой хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллага

Органик хүнсний тухай хуулийн 10.2-т “Энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэсэн хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан үйлдвэрлэгч, хэрэглэгч болон бусад тал хамтран баталгаажуулах бол хүнс, ХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.”, мөн 10.7.4-т “энэ хуулийн 10.1, 10.2-т заасан баталгаажуулалт хийсэн этгээд үндэсний итгэмжлэлийн байгууллагад бүртгүүлэхгүйгээр үйл ажиллагаа явуулахыг хориглоно.” гэж заасны дагуу баталгаажуулалтын байгууллагууд холбогдох төрийн байгууллагуудын бүртгэлд хамрагдсан байх үүрэгтэй бөгөөд энэ зохицуулалт хангалтгүй хэрэгжиж байна.

Хуулийн 10.1-д заасан баталгаажуулалтын байгууллага /цаашид хөндлөнгийн ББ гэх/-ын бүртгэлтэй холбоотой дараах асуудлууд үүсэж байна. Нэгдүгээрт Органик хүнсний бүртгэлийн мэдээллийн санд хөндлөнгийн ББ-ыг баталгаажуулсан бүтээгдэхүүний хамт бүртгэдэг боловч итгэмжлэлийн хугацаа хэзээ эхэлсэн, хэзээ дуусах талаар мэдээлэл агуулдаггүй.

⁶² г/мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэр, хадгалалт, тээвэрлэлт, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг мөрдүүлэх, хүнсний сүлжээний үе шат бүрд хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, түүнийг баталгаажуулах эрх бүхий итгэмжлэгдсэн байгууллагын тоог нэмэгдүүлэх;

⁶³ д/хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн явцад аюулгүйн үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангасан эсэхэд тавигдах дотоодын хяналтыг нэмэгдүүлэх, хөндлөнгийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх;

Зураг 8: Органик хүнсний бүртгэл мэдээллийн сан дахь мэдээлэл⁶⁴



Ерөнхий мэдээлэл	Бүтээгдэхүүн	
Баталгаажуулалтын байгууллага: Эс Эф Си Эс ХХК	Баталгаажуулалтын байгууллагын төрөл: Хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллага	Байгууллагын регистрийн дугаар: 5830214
Байгуулагдсан огноо: 2014-04-14	МХЕГ -ын бүртгэлийн дугаар: 123456789	Цахим шуудан: sfscertification@gmail.com
Ажлын утас: 70149762	Ажлын утас: 99015078	Факс: -
Аймаг хот: Улаанбаатар	Сум дүүрэг: Баянгол	Хаягын мэдээлэл: 16-р хороо, Колорадо Бизнес төв 207 тоот

Хоёрдугаарт, итгэмжлэлийн хугацаа дууссан хөндлөнгийн ББ-ын хугацааг дахин сунгаагүй, эсхүл итгэмжлэлийг цуцалсан тохиолдолд хуулийн 12.2-т заасан чиг үүргийг хэн, хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна. Тухайлбал, хөндлөнгийн ББ болох Эс Эф Си Эс ХХК⁶⁵ нь Хаан Жимс Эс Би Ти ХХК болон Үлэмж органик ХХК-ийн үйлдвэрлэсэн 65 бүтээгдэхүүнийг органикаар баталгаажуулсан бөгөөд эдгээр бүтээгдэхүүнд Органик хүнсний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т⁶⁶ заасны дагуу 2024 он хүртэл хяналт тавих үүрэг хүлээсэн. Эс Эф Си Эс ХХК-ны итгэмжлэлийн хугацаа 2023 оны 8 сар хүртэл үргэлжлэх бөгөөд эл хугацаа сунгагдаагүй тохиолдолд хяналт тавих асуудал хөндөгдөх юм.

Гуравдугаарт, үндэсний итгэмжлэлийн байгууллагаас баталгаажуулалтын байгууллагыг бүртгэх эрх зүйн орчны зөрчил, хийдлийг нягтлах шаардлагатай байна. Тодруулбал, Стандарт, хэмжилзүйн газрын Бүтээгдэхүүн, тогтолцоо баталгаажуулалтын газар Органик хүнсний тухай хуулийн 10.1-д заасан хөндлөнгийн ББ-аар бүртгүүлэх хүсэлт гаргасан боловч MNS ISO 17065: 2013 Тохирлын үнэлгээ — Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээг баталгаажуулах байгууллагад тавих шаардлагад заасан 2 удаа бүтээгдэхүүн баталгаажуулсан байх шаардлага хангаагүй тул хөндлөнгийн ББ-аар бүртгүүлэх үйл явц удааширсан байна.

Манай байгууллага органик бүтээгдэхүүн баталгаажуулах эрх авахаар Үндэсний итгэмжлэлийн төвд хандсан, гэвч 2 удаа баталгаажуулалт хийсэн байх стандартын шаардлага хангаагүй гээд нэлээн удаан хүлээгдэж байгаа. Гэхдээ болно гэсэн.

Стандарт, хэмжилзүйн газрын мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

Дөрөвдүгээрт, хөндлөнгийн ББ-аар бүртгүүлэх шаардлага хангасан үндэсний баталгаажуулалтын байгууллагуудын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, тэдэнд тавих хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

⁶⁴Баталгаажуулалтын байгууллагууд/Дэлгэрэнгүй Эх сурвалж: <https://organic.gov.mn/#/validator-organization/5d007a0c4413917fa0249210>

⁶⁵ <http://sfcs.mn/attorney>

⁶⁶ 12.2.Энэ хуулийн 10.1, 10.2-т заасан баталгаажуулалт хийсэн этгээд органик хүнсний үйлдвэрлэлийн үйл явцад байнгын хяналт тавина.

Баталгаажуулалтын байгууллагуудын ажилтнуудын чадвар, мэдлэгийг дээшлүүлэх шаардлага байна. Зарим нь зорилгоо мэдэж байгаа боловч яг ямар үйл ажиллагаа хийхээ мэдэхгүй байх тохиолдол гарч байна. Энэ цаашидаа органик үйлдвэрлэлийг зөв голдрилоор нь хөгжүүлэхэд саад болох эрсдэлтэй байна. Дотоод сургалтын хүрээнд органик үйлдвэрлэлийн явц, бүтээгдэхүүний хяналтын талаар бүрэн мэдлэг авах боломж одоогоор бүрдээгүй.

ХХААХҮЯ-ны мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

Хамтын баталгаажуулалтын байгууллага

Органик хүнсний баталгаажуулалт хийх хамгийн хямд, харилцан уялдаатай, итгэлцэлд суурилсан хувилбар нь Хамтын баталгаажуулалтын байгууллага /цаашид ХББ гэх/ -аар баталгаажуулах хэлбэр бөгөөд энэ нь хамгийн бодитой, богино хугацаанд үйл ажиллагаа нь жигдрэх боломжтой, орон нутгийн органик хүнсний зах зээл рүү чиглэсэн баталгаажуулалтын байгууллага болж байна. Иймээс манай улсад ХББ -ын хэлбэр илэрхий хөгжиж байгааг Органик хүнсний бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй 18 ББ-ын 16 нь ХББ байгаагаас⁶⁷ харж болох юм.

ХББ-ын давуу тал нь хяналт, шалгалт болон бусад арга хэмжээ зохион байгуулах зардал бага, тухайн орон нутагтаа борлуулах боломж өндөртэй, нэр хүндтэй байх боломжтой тул олон тооны ХББ үүсгэн байгуулагдаж байна. Харин ББ-ын энэ хэлбэр нь ашиг сонирхлын зөрчил үүсгэх, хяналт шалгалтын үр дүн сул байх, борлуулалтын хэмжээ, зах зээл бага, зах зээлд нийлүүлэх зардал өндөр байх, нэгдсэн маркетинг, удирдлага зохион байгуулалтад орох чадамжгүй зэрэг асуудал үүсгэх боломжтой нь органик хүнсний амин сүнс болох хэрэглэгчийн итгэл, үнэмшилд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байдаг.

Түүнчлэн ХББ-ы баталгаажуулах үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь холбогдох хууль тогтоомжтой зөрчилдөж байна. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4.1.6-д "тохирлын үнэлгээ" гэж бүтээгдэхүүн, ажилтны ур чадвар, менежментийн тогтолцоо нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох үйл ажиллагааг⁶⁸ ойлгоно гэж заасан. Тохирлын үнэлгээний итгэмжлэл гэдэг нь тохирлын үнэлгээний байгууллагын тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх мэргэжлийн чадвартайг нь албан ёсоор нотлон харуулсан хөндлөнгийн этгээдийн баталгаа⁶⁹ бөгөөд энэ нь тохирлын үнэлгээний байгууллагуудын чадавх, бие даасан, хараат бус байдлыг илэрхийлдэг учраас хэрэглэгч өөрийн хэрэгцээнд тохирсон сорилт, хэмжилт, шалгалт тохируулга, баталгаажуулалтын үйлчилгээг сонгох боломжийг олгодог. Тухайлбал, Үндэсний итгэмжлэлийн төв нь Монгол Улс болон дэлхийн олон улс оронд хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу итгэмжлэлийн үйлчилгээг хүргэдэг. Тэгвэл органик хүнсний баталгаажуулалтыг ХХААХҮСайдын тушаалаар баталсан журмаар зохицуулж байгаа нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуультай зөрчилдөж байна.

⁶⁷ <https://organic.gov.mn/#/validator-organization/coopList>

⁶⁸ Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль. 2017. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/13071>

⁶⁹ <https://www.mnas.gov.mn/> итгэмжлэл-гэж-юу-вэ

Иймээс ХХААХҮСайдын 2018 оны А-09 дүгээр тушаалаар баталсан “Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журмыг Монгол Улсын стандарт болгон батлуулах шаардлагатай гэж үзлээ.

Органик хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэсэн хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан үйлдвэрлэгч, хэрэглэгч болон бусад тал хамтран баталгаажуулах бол хүнс, ХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ” гэж зааснаас харахад энэ төрлийн баталгаажуулалт хийх этгээдээс ямарваа нэг хуулийн этгээдийн хэлбэр шаардаагүй боловч ХХААХҮСайдын 2018 оны А-09 дүгээр тушаалаар баталсан “Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журам”-ын 1.1-д “Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан, хамтран баталгаажуулах байгууллагыг Иргэний хуулийн 481 дүгээр зүйлд заасан нөхөрлөл хэлбэрээр байгуулна.” гэж тодотгосон зохицуулалт оруулжээ. Гэвч ХББ-ыг зарим тохиолдолд нөхөрлөл хэлбэрээр зохион байгуулах нь оновчгүй байх тул одоо хэрэгжиж буй практикт хоршоо, төрийн бус байгууллага хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлж байна. Үүний тод жишээг органик хүнсний ногоо, зөгийн бал үйлдвэрлэлийн дийлэнх хувийг үйлдвэрлэж буй Сэлэнгэ аймгийн органик үйлдвэрлэгчид бүгд хоршоо хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг бол нарийн ногоо, бордоо үйлдвэрлэгчдээс бүрдсэн Органик хөгжилт ХББ нь төрийн бус байгууллага хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаагаас харж болох юм.

Манайх нөхөрлөл хэлбэрээр үйл ажиллагаа явуулж үзсэн энэ тэнд очоод зээл авах ч юм уу, худалдан авалт, борлуулалт хийх, баримт олгох гээд данс тооцоотой холбоотой асуудал гарахаар нөхөрлөл байхаар хэцүү байдаг. Тийм болохоор бид давхар төрийн бус байгууллага байгуулаад үйл ажиллагаагаа явуулж байгаа. Гэхдээ яг л хуульд заасны дагуу 6 сараараа сонгуульт үүргээ гүйцэтгээд явна.

Органик хөгжилт ХББ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Органик хүнс үйлдвэрлэлийн хэмжээ үлэмж бага байгаа энэ үед ХББ-уудыг итгэмжлэх, бүртгэх үйл ажиллагааг өнөөгийн тогтолцоогоор хэрэгжүүлэх боломж байгаа боловч төрийн бодлогын хүрээнд ХАА үйлдвэрлэлийн 5 хувийг органикаар баталгаажуулах тохиолдолд тогтолцоог шинэчлэх, өргөжүүлэх шаардлага үүсэхээр байна. Ялангуяа одоо мөрдөгдөж буй “Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журам”-ын зохицуулалт нь нэг нэг хоршоо/нөхөрлөлийн үйл ажиллагаанд буюу цөөн гишүүнтэй, ойролцоо байрлалтай, бие биенийхээ үйл ажиллагааг хянах боломжтой жижиг ХББ-д хамаарч байгаа бол өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлага нь олон гишүүнтэй эсхүл цөөн гишүүнтэй хэд хэдэн хоршоо/нөхөрлөл нэгдэн ХББ байгуулах тохиолдолд тухайн харилцааг зохицуулах боломжгүй байна. Ялангуяа органик үйлдвэрлэл эрхлэгчид нэмүү өртгийн сүлжээнд бүтээгдэхүүнээ хямд өртгөөр нийлүүлэх, нэгдсэн маркетинг хийх, тасралтгүй ханган нийлүүлэлт хийх, нэгдсэн удирдлага зохион

байгуулалтад орох шаардлага үүссэн тохиолдолд энэхүү харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай байна.

ХББ-ын баталгаажуулалт, бүртгэлийг Тунгалаг мэргэжилтэн хянадаг, тэгээд нэг товч дардаг байх л даа. Баримт бичгийн бүрдлийн бол програм нь өөрөө шаардаад явчих байх. Өнөөдөр хэдхэн ХББ байгаа болохоор тэгэс гээд болгож байгаа байх, олон болоод ирвэл нэгбүрчлэн хянана гэдэг боломжгүй.

Органик хөгжил ХББ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Мөн баталгаажуулалт, бүртгэлийн харилцааг зохицуулж буй журамд ХББ-ыг анхлан болон давтан итгэмжлэх хугацааг заагаагүй, мөн ХББ-ын итгэмжлэлийг цуцлах нөхцөл, энэ шийдвэрийг гаргах эрх бүхий этгээд зэрэгт холбогдох тухай зохицуулалт тусгаагүй, мөрдлөг болгох бусад хууль тогтоомжийг эшлээгүй нь органик хүнсний баталгаажуулахад хамгийн түгээмэл сонгож буй ХББ-д холбогдох зохицуулалт тодорхойгүй байхад нөлөөлөхөөр байна. Тухайлбал, Журмын 2.3-т заасан Хамтран ажиллах гэрээнд гишүүн хамтран ажиллах гэрээгээр хүлээсэн үүрэг болон тангаргийг зөрчихөд хүлээлгэх хариуцлагыг тооцох талаар тусгасан боловч эдгээр гишүүддээ хариуцлага тооцдоггүй ХББ-г хэрхэх талаар зохицуулалт байхгүй байна. Харин итгэмжлэлийн хугацааг тогтоохтой холбоотой эрх зүйн зохицуулалтаас харахад Итгэмжлэлийн үндэсний төвийн даргын тушаалаар баталсан “MNAS P701 Итгэмжлэлийн үйл явцын журам”-ын⁷⁰ 8.4-т зааснаас анхны итгэмжлэлийн хугацаа 2 жил байх ба үйл ажиллагааны явцаас шалтгаалан давтан итгэмжлэлийн хугацаа ялгаатай байхаар тусгасан байдаг байна.

ХББ-ын зөвшөөрлийг цуцлах асуудлыг хууль зүйн талаасаа тодорхой ил тод болгох нь чухал байна. Хариуцлага алдаа дутагдал гаргаад байгаа гишүүдтэйгээ хариуцлага тооцож чадахгүй байгаа ХББ-г хэрхэх талаар журамд тодорхой нэмж оруулах шаардлагатай гэж үздэг.

Сэлэнгэ органик төслийн ажилтантай хийсэн ярилцлагаас

Органик хүнс үйлдвэрлэгчид ХББ-ыг сонгоход зардлын асуудал нөлөөлж байна. Хөндлөнгийн ББ-аар бүтээгдэхүүнээ баталгаажуулах зардал 3 сая төгрөгөөс эхэлж байгаа⁷¹ бол зах зээлд бүрэн нэвтэрч чадаагүй, эдийн засаг, хүний нөөцийн хувьд бэхжиж амжаагүй органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хувьд ХББ нь баталгаажуулалт, хяналт шалгалтыг хамгийн бага зардлаар гүйцэтгүүлэх боломж олгодгоороо давуу талтай байна.

Манай ХББ-ын тухайд баталгаажуулалтын зардал харьцангуй бага, нэг жилд дунджаар 300 мянган төгрөг болдог. Аудитын баг маань цалин авдаггүй, зөвхөн томилолтын зардал авдаг болохоор ийм хэмжээтэй байгаа.

Органик хөгжил ХББ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

⁷⁰ MNAS P701 Итгэмжлэлийн үйл явцын журам. Эх сурвалж: <https://www.mnas.gov.mn/> итгэмжлэлийн-хөтөлбөр/10

⁷¹ ОРГАНИК БАТАЛГААЖУУЛАЛТЫН ҮНЭ. Эх сурвалж: <http://sfcs.mn/organic-price>

Харин органик бүтээгдэхүүн, түүхий эд нь дотоодын болон гадаадын зах зээлд танигдсан, гол төлөв нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний борлуулалттай аж ахуйн нэгжүүдийн хувьд хөндлөнгийн ББ-ыг сонгон үйлчлүүлж байгаа нь ихэвчлэн гадаад зах зээлд хүлээн зөвшөөрөгдөх алхам болж байгаа бол нөгөө талдаа бусдын үйл ажиллагааг хянахаас илүү хөндлөнгийн хяналт хэрэгжүүлдэг байх нь цаг хугацааны хувьд хэмнэлттэй гэж үздэгтэй холбоотой байна.

Манайх хөндлөнгийн ББ-г сонгох болсон шалтгаан нь өөрсдөө яваад жишээ нь энэ хүнсний ногоог органикаар тариалж байна уу үгүй юу гээд огт мэдэхгүй зүйлээ шалгаад явж байхын оронд мөнгийг нь төлөөд хөндлөнгийн ББ-аар өөрсдийгөө хянуулаад явах нь дээр гэж үзсэн.

Хаан жимс ХХК-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

ХХААХҮСайдын 2018 оны А-180 дугаар тушаалаар баталсан Органик хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам болон 2018 оны А-09 дүгээр тушаалаар баталсан “Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журмын дагуу ХХААХҮЯ-ны Хүнсний үйлдвэрийн хөгжлийн бодлого зохицуулалтын газрын нэг мэргэжилтэн ХББ-уудаас гадна органикаар баталгаажсан болон импортын органик бүтээгдэхүүний бүртгэлийг хөтөлж байгаа нь органик бүтээгдэхүүн, органик үйлдвэрлэлд тавих хяналт сул байгааг илэрхийлж байна. Ялангуяа 2030 он хүртэл органик үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, экспортын брэнд бүтээгдэхүүнтэй болох зорилт дэвшүүлээд буй манай улсын хувьд шаардлагатай бүтэц, орон тоог бий болгох шаардлага байна.

Мэдээллийн санд ирж байгаа хүсэлтүүдийг ерөнхийд нь хардаг. Гэрээ, тангараг гээд агуулга нь ойлгомжтой баримт бичгийг хянадаггүй. Харин үйлдвэрлэлийн төлөвлөгөө, хяналт, шалгалтын илтгэх хуудас гээд заавал харах шаардлагатай зүйлс бий. Цаг хугацаа ордог. Хуулийн хугацаанд нь багтаахыг хичээдэг. Програм хангамжаа сайжруулах санал гаргах, органик үйлдвэрлэгчид болон худалдан авагчдад зориулсан шинэлэг ажил хийх хэрэгтэй болдог. Гэтэл үндсэндээ бичиг баримтаа хянаад хариу өгөөд явж байтал үндсэн ажил маань хоцордог. Нэг хүн үүнийг хийнэ гэж байхгүй л дээ. Гэхдээ амжуулдаг. Би удахгүй гавьяаны амралтандаа гарна, тэрнээсээ өмнө органикт сэтгэлтэй хандчихаар дараагийн хүнээ бэлдэхэд хүртэл анхаарах хэрэгтэй байна.

ХХААХҮЯ-ны мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

Органик хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7.1-д ББ нь органик үйлдвэрлэл эрхлэгчтэй энэ хуулийн 6.2-т заасан гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангуулж ажиллах үүрэгтэй бөгөөд энэхүү гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаа одоогоор ямарваа нэг сөрөг үр дагаваргүйгээр хэрэгжиж байна. Үүнд ХББ-уудын зүгээс хэрэгжүүлж буй дотоод хяналтаас илүү органик үйлдвэрлэгчдийн хандлага илүү ихээр нөлөөлж байна. Харин органик үйлдвэрлэгчийн тоо өсөхийн хэрээр хөндлөнгийн болон хамтын ББ-ын тоо өсөх тул эдгээр гэрээний хэрэгжилтийг үнэн зөв дүгнэсэн эсэхийг хэрхэн тогтоох, хэн хяналт тавих нь тодорхойгүй байна.

Органик гэдэг бол тухайн үйлдвэрлэгч үйл ажиллагаагаа өөрөө үнэлэх, өөрөө хянах тогтолцоо гэж хардаг. Мэргэжлийн хяналт ирээд органик гэж хэлэх нь утгагүй. Харин би өөрөө ямар ч шалгалт, аудитын өмнө органик гэдгээ баталж чаддаг байх нь илүү чухал юм. Тиймээс энэ гэрээний хяналт дээр одоохондоо асуудал гарахгүй. Одоохондоо бол органикт сонирхолтой, сэтгэлтэй хүмүүс энд ажиллаж байгаа гэж боддог. Харин хэт олон болоод, өрсөлдөөн үүсэх юм бол яаж өөрчлөгдөхийг хэлж мэдэхгүй.

Органик хөгжил ХББ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

“Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журам”-ын 3.4-т ХХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бүртгэгдсэн ХББ-ын үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд Захиргааны гэрээ байгуулж, хяналт тавина гэх зохицуулалтыг тусгасан боловч өнөөг хүртэл энэ төрлийн гэрээ байгуулсан, гэрээний хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгсөн тохиолдол байхгүй байна. Иймээс хууль тогтоомж, холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж ажиллах нь чухал байна.

Дөнгөж хөлөө олох гэж байгаа ХББ-уудыг Захиргааны гэрээгээр дарамтлаад байхаар органик байхаас татгалзах магадлалтай. Хууль хэрэгжээд 5 жил боллоо. Үндсэндээ ХББ-ууд байгуулагдаад 3 жил л болж байгаа. Энэ хугацаанд алдаа оноогоо дэнслээд, засаж сайжруулаад явж байгаа гэж боддог. Гэрээ байгуулах амархан, түүнийг хэн, хэрхэн хянах нь одоохондоо шийдэгдээгүй байна.

ХХААХҮЯ-ны мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

Манайд байгуулагдсан цагаас эхлээд одоо хүртэл яамтай гэрээ байгуулаагүй. Мэргэжлийн хяналт, яам гээд хаанаас ч шалгалт ирж байгаагүй. Тэр хяналтууд ер нь шалгаж байгаа газартаа ашигтай газраа л хийгддэг байх

Органик хөгжил ХББ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Үнэлсэн байдал

Органик хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан баталгаажуулалтын байгууллага, органик үйлдвэрлэл болон хүнсний баталгаажуулалт, бүртгэлтэй холбоотой харилцааг зохицуулж буй хуулийн заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа нь тухайн харилцааг зохицуулах журмуудыг батлах ажиллагаа удаашралтай байсан, баталгаажуулалтын байгууллагыг итгэмжлэх эрх зүйн орчин зөрчилтэй, эдгээр байгууллагуудыг бүртгэх, хянах бүтэц, хүний нөөцийн дутагдал зэрэг хүчин зүйлстэй холбоотой байна.

Органик хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн хэрэгжилтийг үнэлэхдээ эхний хэсэгт Монгол Улс 2030 он гэхэд “Хүнс, ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 5 хувь органик баталгаажуулалтад хамрагдсан байх” зорилт дэвшүүлэн ажиллаж байгаатай холбогдуулан органикаар баталгаажуулахыг зорьж буй ХАА-н хүнсний бүтээгдэхүүний хэмжээг тогтоох, зорилтыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, удаах хэсэгт хуулийн 10 дугаар зүйлийг “Органик хүнсийг баталгаажуулах байгууллагыг

итгэмжлэх үйл ажиллагаа тодорхой байна”, мөн “Гэрээний хэрэгжилтийг хянах тогтолцоо хөндлөнгийн, ашиг сонирхлын зөрчилгүй байна” гэх томъёоллоор “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтийн үнэлэхэд **“ЗОРИЛГОДОО БҮРЭН ХҮРЭЭГҮЙ”** гэж үнэллээ.

А. 2030 он хүртэл ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 5 хувийг органик баталгаажуулалтад хамруулахын тулд төрөөс малчид, тариаланчдад органик үйлдвэрлэлийн талаар мэдээлэл түгээх ажлын эрчимжүүлэхээс гадна газар зохион байгуулалтад анхаарч органик бүс байгуулах асуудлыг судлах, органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх бүтэц, орон тоог нэмэгдүүлэх, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх зэрэг олон асуудлаар дорвитой алхам хийх шаардлагатай. Үнэлгээний энэ хэсэгт төрөөс ХАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүний 5 хувийг органик баталгаажуулалтад хамруулах зорилтын хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг нэгтгэн дүгнэвэл:

1. ХХААХҮСайдын 2018 оны А-09 дүгээр тушаалаар баталсан “ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах журам”-аар органик газар тариалан, МАА-н үйлдвэрлэл, органик зөгийн аж ахуй эрхлэх, органик хүнсийг боловсруулах үйлдвэр эрхлэхэд тавигдах шаардлагуудыг тогтоосноор тухайн харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн.
2. Улсын хэмжээнд МАА-н гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлтээс харахад 929,309.3 литр сүү, 526,178.9 тонн мах бэлтгэсэн бол үүнээс 2 мянга орчим литр, 10 гаруй төрлийн органик сүү, сүүн бүтээгдэхүүн, 5 төрлийн мах, махан бүтээгдэхүүнийг органик шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэжээ. Төрөөс 2030 он хүртэл органик баталгаажуулалтад хамрагдсан ХАА-н бүтээгдэхүүний хэмжээг 5 хувьд хүргэх зорилтын хүрээнд 46,4 мянган литр сүү, 26,3 мянган тонн мах, махан бүтээгдэхүүнийг органик хүнсний баталгаажуулалтад хамруулахаар байна. Энэхүү зорилтод хүрэхийн тулд төрөөс органик МАА эрхлэгчдийг дэмжих, урамшуулах, органик үйлдвэрлэл эрхлэхтэй холбоотой хууль тогтоомжийг сурталчлах, үйлдвэрлэлд тавигдах шаардлагыг таниулах, органик бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэх боломж, нөхцөлийн талаар мэдээлэл түгээхээс гадна баталгаажуулалт, бүртгэл хийх эрх бүхий байгууллага, нэгж, албан тушаалтны тоог нэмэгдүүлэх шаардлагатай.
3. ХАА-н органик бүтээгдэхүүн түүн дотроо МАА-н гаралтай органик бүтээгдэхүүний төрөл, хэмжээ бага байхад малчид, МАА-н гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн дунд органик үйлдвэрлэлийн талаар мэдлэг муу, органик баталгаажуулалт хийлгэсэн ч эдийн засгийн ач холбогдол бага, органик үйлдвэрлэлтэй холбоотой бүртгэл, мэдээллийн ажлыг гүйцэтгэх хүний нөөц, ур чадварын асуудал, уламжлалт аргаар малласан бэлчээрийн малын гаралтай бүтээгдэхүүн угаасаа байгалийн цэвэр, органик бүтээгдэхүүн байдаг гэх хэвшмэл ойлголт зэрэг нөлөөлж, үүнээс шалтгаалан органик МАА-н үйлдвэрлэл эрхлэх сонирхолгүй байна. Иймээс органик МАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх, зорилтот хэмжээний МАА-н гаралтай бүтээгдэхүүнийг органик үйлдвэрлэлд шилжүүлэхийн тулд төрөөс органик мал арчилгаа, маллагаа, тээвэрлэлт, нядалгаа

зэрэг баталгаат органик хүнс бэлтгэх асуудлаар малчдын мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй.

4. Хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэлийн түвшинд органикаар баталгаажсан хүнсийг хамгийн ихээр үйлдвэрлэж байна. Статистик үзүүлэлтээс харахад 2030 он хүртэл газар газар тариалангийн бүтээгдэхүүний 5 хувийг органик баталгаажуулалтад хамруулах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд 5,253.5 тонн хүнсний ногоо тариалах 452,8 га газар, 9,098.3 тонн төмс тариалах 770 га газар, 21,700 тонн үр тариа тариалах 19,129 га газар, 7,686 тонн таримал тэжээл тариалах 2,307 га газрыг органик бус газар тариалан, мал аж ахуй, уул уурхай, хот суурин газраас тусгаарлах бэлтгэл хангах шаардлага үүсэхээр байна.
5. ХАА-н органик хүнс үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхэд газар зохион байгуулалтын асуудалд онцгой ач холбогдол өгөх шаардлагатай байна. Ялангуяа МАА, газар тариалангийн талбайн дийлэнх хэсэг нь хүн амын нягтаршил өндөртэй, уул уурхай, аж үйлдвэр эрчимтэй хөгжиж буй бүс нутгуудад оршихоос гадна дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, үер усны аюул, ган гачиг, цөлжилт, органик бус, газар тариалангийн салбарын тэлэлт, шинэ төрлийн хортон шавж, өвчин эмгэг гээд олон хүчин зүйлээс шалтгаалан бэлчээр, усны хомсдол үүсэж байгаа нь органик МАА, газар тариаланг тогтвортой эрхлэхэд хүндрэл үүсгэх эрсдэлтэй байна. Иймээс ХАА-н органик хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдээр олон улсын зах зээлд өрсөлдөх, экспортыг нэмэгдүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд бүс нутаг, аймаг, сумын хэмжээнд уул уурхай, органик бус газар тариалан, МАА-гаас ангид хортон шавж, ургамалтай зөвхөн органик аргаар тэмцдэг хууль тогтоомжийн шаардлага хангахуйц хязгаарлалт тогтоосон органик МАА, газар тариалангийн бүс бий болгох боломжийг судлах шаардлагатай.
6. ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлээс үр тариа, таримал тэжээлийг органик үйлдвэрлэлд шилжүүлэхэд онцгой анхаарах шаардлагатайг энэ төрлийн бүтээгдэхүүн органик баталгаажуулалтад хамрагдаагүй байгаа нь харуулж байна. Ялангуяа үр тариаг органик үйлдвэрлэлд шилжүүлснээр нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, нэмүү өртөг шингэсэн органик гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжих суурь болох бол таримал тэжээлийг органик болгох нь МАА-н гаралтай органик бүтээгдэхүүний өсөлтөд нөлөөлөх ач холбогдолтой юм.
7. ХАА-н органик үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд малчид, тариаланчдыг шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах, арга зүй, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох, эрдэм шинжилгээ судалгааны үр дүн, шинэ технологи нэвтрүүлэх боломж бүрдүүлсэн органик ХАА-н цогц бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох шаардлагатай. Тухайлбал, манай улсад 2020 оны байдлаар газар тариалан эрхлэгч 20 орчим мянган иргэн, аж ахуйн нэгжид органик хүнс үйлдвэрлэлийн талаар мэдээлэл түгээх, эдгээрээс органик үйлдвэрлэлд шилжих хүсэлтэй, боломжтой тариаланчдыг судалгаа мэдээлэл, арга зүйгээр хангах бүтэц байхгүй, улсын хэмжээнд 2 мэргэжилтэн эл асуудлыг хариуцаж байна.
8. ХАА-н гаралтай органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийн бүртгэл мэдээллийг оновчтой, тодорхой хөтлөх шаардлагатай байна. Тухайлбал, улсын

хэмжээнд хэр хэмжээний МАА, газар тариалангийн гаралтай органик бүтээгдэхүүн, түүхий эд үйлдвэрлэгдсэн, тэдгээрийн хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын талаарх мэдээллийг салбарын яам хүртэл тооцож гаргадаггүй байна.

Б. Органик хүнснийг баталгаажуулах баталгаажуулалтын байгууллагыг бүртгэх эрх зүйн орчин зөрчилтэй, зарим үйл ажиллагаа хэрэгжихгүй байгаа нь хуулийн зохицуулалтын хэрэгжилт зорилгодоо хүрэхгүй байхад нөлөөлж байна. Баталгаажуулалтын байгууллагыг итгэмжлэх, бүртгэх болон бүртгэл хөтлөхтэй холбоотой асуудлыг нэгтгэн дүгнэвэл дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

1. Органик хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар органик хүнсний баталгаажуулалтыг 1/ дотоодын буюу Монгол Улсын эрх бүхий байгууллагаар итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага, 2/ гадаадын буюу Монгол Улсад бүртгэлтэй, гадаад улсын итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага болон 3/ харилцан итгэлцэлд тулгуурласан хамтын баталгаажуулалтын байгууллагууд хэрэгжүүлж байна. Эдгээр баталгаажуулалтын байгууллагууд нь Органик хүнсний тухай хуулийн 10.2, 10.7.4-т заасан шаардлагад нийцүүлэн Үндэсний итгэмжлэлийн төв болон ХХААХҮЯ-нд бүртгүүлэн үйл ажиллагаа явуулдаг.
2. Баталгаажуулалтын байгууллагыг итгэмжлэхтэй холбоотой харилцааг зохицуулж буй эрх зүйн орчныг Органик хүнсний тухай хууль, MNS ISO 17065: 2013 Тохирлын үнэлгээ — Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээг баталгаажуулах байгууллагад тавих шаардлага, ХХААХҮСайдын 2018 оны А-09 дүгээр тушаалаар баталсан “Органик хүнснийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журам” Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн А/10 дугаар тушаалаар “Гадаад орны итгэмжлэлийн байгууллагаас итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагыг бүртгэх журам” бүрдүүлж байна. Гэхдээ эдгээр журмууд нь хууль хэрэгжих эхэлснээс хойш 2-4 жилийн дараа батлагдсан нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлсөн.
3. Хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагыг итгэмжлэх эрх зүйн орчин зөрчилтэй байгаа нь энэ төрлийн баталгаажуулалтын байгууллагыг итгэмжлэх ажлыг удаашралтай, ойлгомжгүй байдалд хүргэж байна. Тухайлбал, MNS ISO 17065: 2013 Тохирлын үнэлгээ — Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээг баталгаажуулах байгууллагад тавих шаардлагад ББ нь тухайн чиглэлээр 2 удаа бүтээгдэхүүн баталгаажуулсан байх шаардлага тавьж байна.
4. Органик хүнсний бүртгэл, мэдээллийн санд ББ-уудыг бүртгэхдээ итгэмжлэгдсэн хугацааг тодорхой тусгаагүй, холбогдох журмуудад ББ-ын итгэмжлэлийн хугацаа сунгагдаагүй тохиолдолд тэдний зүгээс хэрэгжүүлэх хяналт шалгалтыг хэн, хэрхэн хэрэгжүүлэх талаар зохицуулаагүй, мөн итгэмжлэлийг анхлан болон давтан хийлгэх тохиолдолд итгэмжлэлийн хугацаа хэдэн жил байх талаар тодорхой тусгаагүй зэрэг асуудлууд байна. Үүнээс гадна ХХААХҮЯ-ны органик хүнсний бүртгэл, мэдээллийн санд мэдээлэл оруулах, хүсэлт шийдвэрлэх

ажиллагааг нэг мэргэжилтэн хариуцаж байгаа нь хүнсний бүтээгдэхүүний баталгаажуулалтын үр дүнг нягтлах, ББ-аар бүртгүүлэх хүсэлтийг шийдвэрлэх ажил удаашрах, алдаа гарах магадлалыг нэмэгдүүлж байна. Иймээс 2030 он хүртэл органик үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, экспортын брэнд бүтээгдэхүүнтэй болох зорилт дэвшүүлээд буй манай улсын хувьд шаардлагатай бүтэц, орон тоог бий болгох шаардлага байна.

5. Органик хүнсний баталгаажуулалт хийх хамгийн хямд, харилцан итгэлцэлд суурилсан, богино хугацаанд үйл ажиллагаа нь жигдрэх боломжтой, орон нутгийн органик хүнсний зах зээл рүү чиглэсэн баталгаажуулалтын байгууллага болох Хамтын баталгаажуулалтын байгууллагууд ихээр байгуулагдаж байгаа нь санхүү, хүний нөөцийн хувьд бэхжээгүй, зөвхөн тухайн орон нутагтаа үйл ажиллагаагаа эрхэлж буй аж ахуй эрхлэгчид органик үйлдвэрлэлд шилжиж байгаатай холбоотой байна.
6. Мөн Органик хүнсний тухай хуулийн 10.7.4-т “энэ хуулийн 10.1, 10.2-т заасан баталгаажуулалт хийсэн этгээд үндэсний итгэмжлэлийн байгууллагад бүртгүүлэхгүйгээр үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасан боловч Үндэсний итгэмжлэлийн төвийн мэдээллийн санд бүртгэлтэй хамтын баталгаажуулалтын байгууллага байхгүй байна.
7. ХББ-аас органик хүнсийг баталгаажуулах үйл явцыг журмаар зохицуулсан нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулиар тохирлын үнэлгээ нь бүтээгдэхүүн, ажилтны ур чадвар, менежментийн тогтолцоо нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтооход чиглэнэ гэх зохицуулалттай зөрчилдөж байгаа тул органик хүнсийг баталгаажуулах үйл явцыг хууль тогтоомжид нийцүүлэн Монгол Улсын стандарт болгох шаардлагатай.
8. ХББ-ыг нөхөрлөл хэлбэрээр байгуулахаар журамласан боловч практикт хоршоо, төрийн бус байгууллага хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна. Иймээс Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журамд нөхөрлөлөөс бусад хуулийн этгээдийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх практик шаардлага байна.
9. Одоо мөрдөгдөж буй журам цөөн гишүүнтэй, ойролцоо байрлалтай, бие биеийхээ үйл ажиллагааг хянах боломжтой жижиг ХББ-ын хэмжээнд хэрэгжих боломжтой тул ирээдүйд ХАА-н органик хүнсний үйлдвэрлэл тэлэх магадлалыг тооцож олон гишүүнтэй эсхүл цөөн гишүүнтэй хэд хэдэн хоршоо/нөхөрлөл нэгдэн ХББ байгуулах тохиолдолд тухайн харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бий болгох асуудлыг судлах.
10. “Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журам”-ын 3.4-т Хүнс, ХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бүртгэгдсэн ХББ-ын үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд Захиргааны гэрээ байгуулж, хяналт тавина гэх зохицуулалт огт хэрэгжээгүй байна.

Санал, зөвлөмж:

А. Монгол Улс 2030 он хүртэл ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 5 хувийг органик баталгаажуулалтад хамруулах зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд:

1. Төрөөс ХАА-н органик үйлдвэрлэл буюу МАА, газар тариалан эрхлэгчдийг дэмжих, урамшуулах бодлого боловсруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх,
2. ХАА-н органик хүнсний үйлдвэрлэл, органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, тэжээл, бордоо, үр суулгац үйлдвэрлэлт, боловсруулалт, мал арчилгаа, маллагаа, тээвэрлэлт, нядалгаа хадгалалт, тээвэрлэлт, худалдаа, хүнсний сав баглаа боодлын аюулгүй байдал гээд бүхий үйл явцыг удирдлага зохион байгуулалтаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, үйлдвэрлэгч, хэрэглэгчдэд органик бүтээгдэхүүн, органик үйлдвэрлэл эрхлэхтэй холбоотой хууль тогтоомжийг сурталчлах, үйлдвэрлэлд тавигдах шаардлагыг таниулах, органик бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэх боломж, нөхцөлийн талаар сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил явуулах зэрэг цогц бодлого, арга хэмжээг нэгдмэл удирдлага дор харилцан уялдаатай хэрэгжүүлэх бүтэц, тогтолцоог бий болгох, ББ-ын итгэмжлэл, бүтээгдэхүүний баталгаажуулалт, бүртгэл хийх эрх албан тушаалтны тоог нэмэгдүүлэх,
9. Органик мал аж ахуй, газар тариалан, хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор хууль тогтоомжийн шаардлага хангахуйц хязгаарлалт тогтоосон органик МАА, газар тариалангийн бүсийг бий болгох, органик талбайд тариалсан органик хүнсний бүтээгдэхүүнийг органикаар бүртгэх боломжийг бүрдүүлэх,
3. ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлээс үр тариа, таримал тэжээлийг органик үйлдвэрлэлд шилжүүлэх, органик үр, бордоо болон органик бүтээгдэхүүнийг хадгалах зоорьны асуудалд онцгой анхаарч бодлогоор дэмжих,
4. ХАА-н гаралтай органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийн бүртгэл мэдээллийг оновчтой, тодорхой хөтлөх

Б. Органик хүнсийг баталгаажуулах баталгаажуулалтын байгууллагыг итгэмжлэх, бүртгэх асуудлын хүрээнд

5. Хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагыг итгэмжлэх эрх зүйн үндэс болох MNS ISO 17065: 2013 Тохирлын үнэлгээ — Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээг баталгаажуулах байгууллагад тавих шаардлагад шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах,
6. Органик хүнсний бүртгэл, мэдээллийн санд ББ-уудын итгэмжлэгдсэн хугацааг тодорхой тусгах,
7. Холбогдох журмуудад ББ-ын итгэмжлэлийг анхлан болон давтан хийлгэх тохиолдолд итгэмжлэлийн хугацааг тодорхой тогтоох, итгэмжлэлийн хугацаа сунгагдаагүй тохиолдолд ББ-ын зүгээс хэрэгжүүлэх хяналт шалгалтыг хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг тодорхой болгох,
8. Баталгаажуулалтын байгууллагын боловсон хүчний чадавхыг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх,

9. Органик хүнсний тухай хуулийн 10.7.4-т заасны дагуу ХББ-уудыг Үндэсний итгэмжлэлийн төвийн мэдээллийн санд бүртгүүлэх,
10. ХББ-аас органик хүнсийг баталгаажуулах үйл явцыг журмаар зохицуулсан нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуультай зөрчилдөж байх тул уг журмыг стандарт болгох,
11. ХББ-ын гишүүнчлэлийн дээд, доод хязгаарыг тогтоох, мөн олон гишүүнтэй ХББ байгуулах, эсхүл хэд хэдэн нөхөрлөл/хоршоо нийлэн ХББ үүсгэх боломжтой эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай эсэхийг судлах,
12. “Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журам”-ын 3.4 дэх заалтын хэрэгжилтийг хангуулах,

ОРГАНИК ҮЙЛДВЭРЛЭЛ, ОРГАНИК ХҮНСЭНД ТАВИХ ХЯНАЛТ, ШОШГЫН ХЭРЭГЛЭЭ

Хүн амын өсөлт, байгаль цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалан дэлхий дахинаа хүнсний хомсдол үүсэх эрсдэл тулгараад буй өнөө үед баталгаатай, эрүүл, аюулгүй хүнсээр ард иргэдээ хангах нь хүнсний нөөцийн хязгаарлагдмал нөхцөлд улам хүндрэлтэй асуудлын нэг болж байна. Үүнтэй холбоотойгоор дэлхийн улс орнууд НҮБ-аас баталсан Тогтвортой хөгжлийн зорилт-2030 баримт бичигтэй уялдуулан хөгжлийн бодлого төлөвлөлтдөө байгаль орчинд ээлтэй, уламжлалт арга барилд суурилсан, дэвшилтэт технологи ашиглан эрүүл хүнс үйлдвэрлэхэд буюу органик хүнс үйлдвэрлэлд ихээхэн ач холбогдол өгч байгааг Европын Холбоо 2030 он гэхэд ХАА-н үйлдвэрлэлийн 25-аас доошгүй хувийг органик болгох зорилтыг, манай улс ХАА-н бүтээгдэхүүний 5 хувийг органикаар баталгаажуулах зорилго тавин ажиллаж байгаа зэргээс харж болох юм. Манай улс хүнсний аюулгүй байдалд онцгой ач холбогдол өгөх шаардлагатай болсныг МУ-ын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар УИХ-ын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай⁷² тогтоол батлагдах болсон нөхцөл харуулж байна. Иймээс органик хүнсний хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь нэг талдаа хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, нөгөө талдаа органик хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах давхар ач холбогдолтой тул Органик хүнсний тухай хуулийн 12 дугаар зүйлийн сонгож, хэрэгжилтийг үнэллээ.

2.1.3. Хуулийн 12 дугаар зүйлийг “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

№	Зүйл, заалтын агуулга	Шалгуур үзүүлэлтийн томъёолол
9	12 дугаар зүйл. Органик үйлдвэрлэл, органик хүнсэнд тавих хяналт 12.1.Органик үйлдвэрлэлийн сүлжээнд болон органик хүнсний хадгалалт, тээвэрлэлт, экспорт, импорт, худалдаа, үйлчилгээнд тавих хяналтыг Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний	Органик үйлдвэрлэл, органик хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналтын мөрөөр хуурамч органик хүнсний бүтээгдэхүүний илрүүлэлт нэмэгдэнэ.

⁷² Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2022 оны 36 тогтоол. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530824651591>

	аюулгүй байдлыг хангах тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиар тус тус зохицуулна. 12.2.Энэ хуулийн 10.1, 10.2-т заасан баталгаажуулалт хийсэн этгээд органик хүнсний үйлдвэрлэлийн үйл явцад байнгын хяналт тавина.	
--	--	--

Томьёолол

Органик үйлдвэрлэл, органик хүнсэнд тавих хяналт, шошгын хэрэглээ хэсэгт Органик хүнсний тухай хуулийн 12 дугаар зүйлд органик үйлдвэрлэл, органик хүнсэнд тавих хяналтыг хэрэгжүүлэх асуудлыг тусгасан байх ба хуулийн хэрэгжилтийг үнэлэхдээ “Органик үйлдвэрлэл, органик хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналтын мөрөөр хуурамч органик хүнсний бүтээгдэхүүний илрүүлэлт нэмэгдэнэ.” гэх томьёоллоор, харин органик хүнсний тэмдэг, тэмдэглэгээ, шошгын хэрэглээг “Органик хүнс, бордоо, тэжээл болохыг тодорхойлсон шошго хэрэглэх нь үйлдвэрлэгчид дарамт үүсгэхгүй.” болон “Органик шошгыг органик бус бүтээгдэхүүн хэрэглэхгүй” гэх томьёоллоор “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэллээ.

Судалсан байдал

А. Төрийн хяналт

Органик хүнсний тухай хуулийн 12 дугаар зүйлийг “Органик үйлдвэрлэл, органик хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналтын мөрөөр хуурамч органик хүнсний бүтээгдэхүүний илрүүлэлт нэмэгдэнэ” гэх томьёоллоор “Зорилгод хүрэх түвшин” шалгуураар үнэлэхэд хэрэгжилт **“ЗОРИЛГОДОО БҮРЭН ХҮРЭХГҮЙ”** байна.

1. Төрийн хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагууд ХАА-н анхан шатны органик үйлдвэрлэл, органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, бордоо, тэжээл, үр, суулгац үйлдвэрлэлийн онцлогт нийцсэн асуумж бүхий хяналтын хуудасгүй байгаа нь органик үйлдвэрлэл эрхлэгчдийн болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах түвшинд хяналт шалгалт хэрэгжихгүй байхад нөлөөлж байна.

Манай улсын хувьд хүнсний аюулгүй байдлын хяналтын хүрээнд 1/ зах зээл дэх хүнсний чанар, шим тэжээллэг байдалд хийх тандалт судалгаа, 2/ хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналт, 3/ хүнс экспортлох, импортлоход тавих гаалийн болон хорио цээрийн хяналт, 4/ стратегийн хүнс экспортлох, импортлох зөвшөөрөл олгох⁷³ үйл ажиллагааг хэрэгжүүлдэг бөгөөд хүнсний сүлжээний хяналтыг хүнсний хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, бусад эрх бүхий төрийн болон төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодын оролцоотой хэрэгжүүлдэг.

⁷³ Хүнсний тухай хуулийн 13 дугаар зүйл.

Органик хүнсний тухай⁷⁴, Хүнсний тухай⁷⁵, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай⁷⁶, Төрийн хяналт, шалгалтын тухай⁷⁷, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай⁷⁸, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай⁷⁹ хуулиудын хүрээнд ХАА-н органик хүнс үйлдвэрлэлийн сүлжээ, органик бүтээгдэхүүний хяналтыг дотоод хяналт, хөндлөнгийн хяналт болон төрийн хяналт хэлбэрээр хэрэгжүүлнэ.

Төрийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Хилийн хорио цээрийн алба, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар зэрэг төрийн байгууллагын улсын байцаагчид байна. Тухайлбал, МХЕГ-ын хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагчид улсын хэмжээнд мал эмнэлэг, мал, амьтны үржлийн болон ургамал хамгаалал, хорио цээр, таримал ургамлын үр сортын чанарын хяналт, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны чиглэлээр хяналт шалгалт хийхдээ Монгол Улсад мөрдөгдөж буй хүнсний технологийн 606 стандарт, 4 техникийн зохицуулалтын⁸⁰ хэрэгжилтийг хангуулан ажилладгаас⁸¹ харахад ажлын ачаалал ихтэй байгаа нь органик үйлдвэрлэл, органик хүнсний бүтээгдэхүүнд тавих тогтмол хяналтын үр дүнд сөргөөр нөлөөлөх, мөн “органик” мэдэгдлийг ашигласан органик бус бүтээгдэхүүнийг зах зээлээс гаргах замаар хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах ажлын хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлөх эрсдэлтэй байна. Тодруулбал, НМХГ-ын Хүнсний аюулгүй байдал, ХАА-н хэлтсээс МУ-ын УИХ-ын гишүүн Ч.Ундрамын 2022.08.05-ны өдрийн УИХ-03/7503 дугаартай албан бичигт ирүүлсэн хариунд дурдсанаар мэргэжлийн хяналтын байгууллагаас Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг нийслэлийн хэмжээнд 58 улсын байцаагч хариуцаж байгаагаас Хүнсний үйлдвэрлэл, хүнсний худалдаанд хяналт тавьж буй нийт хүнсний чанар, стандартын хяналтын улсын /ахлах/ байцаагч-11, Хүнсний үйлдвэрлэл, хүнсний худалдаанд хяналт тавьж буй нийт эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагч-16, Ургамал хамгаалал хорио цээрийн хяналтын улсын /ахлах/ байцаагч-7, Мал эмнэлгийн хяналтын улсын /ахлах/ байцаагч-24 байдаг. Тэгвэл 2015 оны байдлаар ХАА-н органик хүнсний анхан шатны үйлдвэрлэл явагддаг хөдөө орон нутагт буюу аймгуудын мэргэжлийн хяналтын газрын бүтэц орон тооноос⁸² харахад 21 аймгийн хэмжээнд 361 улсын байцаагч, лабораторийн ажилтан ажиллаж байгаагаас мэргэжлийн хяналтын лабораториудад 114 лабораторийн ажилтан, Хүнс, ХАА-н хэлтэст ургамал хамгаалал, хорио цээрийн улсын байцаагч 20, мал үржлийн

⁷⁴ Органик хүнсний тухай хууль.Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/11884>

⁷⁵ Хүнсний тухай хууль.Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/8912>

⁷⁶ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль.Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=8911>

⁷⁷ Төрийн хяналт, шалгалтын тухай хууль.Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/500>

⁷⁸ Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль.Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/38>

⁷⁹ Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль.Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/551>

⁸⁰ Үүнээс 330 нь шинжилгээний арга, аргачлалтай холбоотой, 172 нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний техникийн ерөнхий шаардлагууд, 104 нь хүнсний үйлдвэрийн нийтлэг асуудал, тоног төхөөрөмж, бусад стандартууд байна

⁸¹ <https://open.audit.mn/reports/open.audit.mn/pages/20220113085448/watermarked.pdf>

⁸² МХЕГ-ын 2015 оны 4 сарын 21-ний өдрийн 208 дугаар тушаал. Эх сурвалж: <https://shilendans.gov.mn/pdfview?file=21d0cd850a0265a73fc9cfcdeda2c21.pdf>

улсын байцаагч 17, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч 24, хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч 48, Хил, хорио цээрийн хяналтын хэлтэст ургамал хамгаалал, хорио цээрийн улсын байцаагч 31, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч 33, стандарт, чанарын хяналтын улсын байцаагч 39, ариутгагч, лабораторийн ажилтан 35 ажиллаж байжээ.

МХЕГ-аас төрийн хяналт шалгалт хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа ашиглаж буй 278 хяналтын хуудаснаас⁸³ Хүнсний чанар, стандарт, Байгаль орчин, Мал эмнэлэг, хорио цээр, Ургамал хамгаалал, хорио цээр, Экспортын хилийн хорио цээр, Импортын хилийн хорио цээрийн хяналтад хамаарах 124 хяналтын хуудсаар ХАА-н анхан шатны органик үйлдвэрлэл, органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, бордоо, тэжээл зэрэг Органик хүнсний тухай хуулийн хамрах хүрээний үйл ажиллагаа, бүтээгдэхүүнд хяналт тавигдана. Эдгээрээс экспорт, импортын хилийн хорио цээрийн хяналт шалгалтын 3 хяналтын хуудсанд буюу Ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүн импортлох үеийн хяналтын хуудас /9.2.3/⁸⁴, Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн импортлох үеийн хяналтын хуудас /9.3.1/⁸⁵, Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн экспортлох үеийн хяналтын хуудас /9.3.7/⁸⁶, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцыг шалгах 1 хяналтын хуудсанд буюу Ургамлын гаралтай жижиглэн савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас /1.22.1/⁸⁷, бордоотой холбоотой Ургамал хамгаалах бодис, бордоо, бэлдмэл үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас /1.36/⁸⁸-ыг ашиглан Органик хүнсний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.2⁸⁹-т заасан органик болохыг баталсан гэрчилгээ, шошго, тэмдэг, тэмдэглэгээтэй эсэхийг шалгаж байгаа нь тухайн байгууллага зөвхөн уг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5⁹⁰-д заасан үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээлэл цуглуулахад зориулагдсан байна. Харин органик аж ахуй эрхлэх, органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тэдгээрийн сав баглаа, боодол, тээвэрлэлт, хадгалалтын явцыг шалгахдаа “органик”-ийн шаардлага хангаж буй эсэхэд анхаарахгүй байна. Тухайлбал, мэргэжлийн хяналтын байгууллага нь органик хүнс үйлдвэрлэлийн үе шат, үйл явцыг шалгахдаа илүүтэй эцсийн бүтээгдэхүүнийг ихэвчлэн хэрэглэгчийн гомдол саналын мөрөөр шалгадаг нь учир дутагдалтай байна. Гэхдээ шинээр хөгжиж буй салбарт

⁸³ МХЕГ. Хяналтын хуудас, хяналтын хуудасны тушаал. Эх сурвалж: <http://home.inspection.gov.mn/news/254/single/703>. Сүүлд нэвтэрсэн 2022.08.20

⁸⁴http://home.inspection.gov.mn/beta/upload/files/2020/1_22_1_УРГАМЛЫН%20ГАРАЛТАЙ%20ЖИЖИГЛЭН%20САВЛАГААТАЙ%20БҮТЭЭГДЭХҮҮНИЙ%20ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ%20ШАЛГАХ%20ХЯНАЛТ%20ХУУДАС-2020.pdf

⁸⁵http://home.inspection.gov.mn/beta/upload/files/2019/2019%20хяналтын%20хуудас/9_3_1%20Hunsni%20tuuhii%20ed%20hyanah%20hh2019_01_18.pdf

⁸⁶http://home.inspection.gov.mn/beta/upload/files/2018/9_3_7_Hunsni%20tuuhii%20ed%20buteegdehuun%20hyanah%20hh%202017.pdf

⁸⁷http://home.inspection.gov.mn/beta/upload/files/2020/1_22_1_УРГАМЛЫН%20ГАРАЛТАЙ%20ЖИЖИГЛЭН%20САВЛАГААТАЙ%20БҮТЭЭГДЭХҮҮНИЙ%20ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ%20ШАЛГАХ%20ХЯНАЛТ%20ХУУДАС-2020.pdf

⁸⁸ http://home.inspection.gov.mn/beta/upload/files/2018/2012-2018/1_36_Urgamal%20hamgaalah%20bodis_bordoo%20shalgah%20hh%202017.pdf

⁸⁹ Органик хүнсний тухай хуулийн 9.3.2. экспортлогч улсын эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаас олгосон органик болохыг тодорхойлсон хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх,

⁹⁰ Органик хүнсний тухай хуулийн 9.5. Мэргэжлийн хяналтын байгууллага органик хүнсийг экспортлох болон импортлох үеийн хяналт, шалгалтын мэдээг гаргаж, улирал тутам хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

мэргэжлийн хяналтын байгууллагын дарамт ирэхгүй байгаа нь үйлдвэрлэгчдэд нэг талдаа хөнгөлөлт болдог байна.

Манайх 2018 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа, мэргэжлийн хяналтаа шалгалт ирж байгаагүй. Гэхдээ ирээд яг юу шалгах вэ гэдэг нь сонин л доо, органикийн тухайд...

Органик хөгжил ХББ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Уг нь төрийн байгууллагууд нь, мэргэжлийн хяналт нь ч юм уу ирээд шалгаад, энэ үнэхээр органик арга технологиор үйлдвэрлэгдсэн, органик бүтээгдэхүүн юм байна гээд хэлээд өгвөл бид хэдэн зуун реклам, зар сурталчилгаа хийснээс илүү үр дүнтэй байхаар байна.

Хаан жимс ХХК-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Ерөнхийдөө органик үйлдвэрлэлийг мэргэжлийн хяналт ирж шалгалаа гэхэд эцсийн бүтээгдэхүүнийг л шалгана. Гэтэл эцсийн бүтээгдэхүүн хүртэл маш олон үе шат, олон орц найрлага байна, хөрс, ус, үр суулгац, түүхий эд гээд... Органик үйлдвэрлэлийн онцлог нь ул мөр мөшигөх ажиллагаанд суурилдаг. Гэтэл энэ бүхнийг шалгахгүй. Иймээс мэргэжлийн хяналтын хяналт гэхээс илүү дотоод хяналтыг илүү хөгжүүлэх хэрэгтэй гэж боддог. Ер тэгээд нэг байцаагч л шалгаад байна гэдэг чинь аливаа асуудлын эхлэл болно. Тэр хүмүүс чинь солигдохгүй шүү дээ, харин дотоод хяналт тавих хүнээ солиод байх боломжтой.

ХХААХҮЯ-ны мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

Иймээс органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, тэжээл, бордооны үйлдвэрлэлийн хяналтын тогтолцоог сайжруулах үүднээс төрөөс органик хүнс үйлдвэрлэлийн хэмжээг 2030 он хүртэл нэмэгдүүлэх чиглэл болон Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.5-ын II үеийн 3 дахь зорилт⁹¹, Зорилт 8.3-ын I үеийн 2 дахь зорилт, Зорилт 9.2-ын I үеийн 7 дахь зорилт, УИХ-ын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын 1-ийн 3/-д⁹², 2-ын д⁹³ заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор төрийн хяналтын байгууллагын хяналт шалгалтыг сайжруулах, органик хүнсний чиглэлээр мэргэшсэн хяналтын бүтэц, тогтолцоог бий болгох шаардлага байна.

Б. Лаборатори

Органик хүнсний хэрэглээ, экспортыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн итгэл үнэмшлийг бий болгох, органик үйлдвэрлэл эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах зэрэг олон асуудалд


⁹¹ Алсын хараа 2050. 2.5 дахь зорилт. II үе. 3.Хүнсний хангамж, нийлүүлэлтийн үйл ажиллагаанд тавих эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт, шаардлагыг боловсронгуй болгож, баталгаат хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой систем бий болгон органик, баяжуулсан, зохицуулах үйлчилгээтэй болон эрүүл хүнсний хэрэглээтэй болно.

⁹² з/хүнсний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох, пестицид, малын эм, хоруу чанар өндөртэй нян, хүнд металлын үлдэгдлийг хянах, хяналтын төлөвлөгөөг батлах;

⁹³ д/хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн явцад аюулгүйн үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангасан эсэхэд тавигдах дотоодын хяналтыг нэмэгдүүлэх, хөндлөнгийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх;

үндэсний лабораториудын чадавх чухал үүрэг гүйцэтгэнэ. Манай улсын тухайд хүнсний бүтээгдэхүүний лабораториуд олон улсын шаардлага хангах хэмжээнд органик түүхий эд, бүтээгдэхүүнийг шинжлэх чадамжгүй байгаа нь төрөөс ХАА-н органик бүтээгдэхүүнийг буюу монгол органик брэндийн экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилгод сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Үүний нэг жишээ бол Монпеллетс компаниас Европын холбооны зарим улсад экспортолж буй хонины ноосон бордоонд хийсэн Монгол Улсын болон Герман Улсын лабораторийн шинжилгээний дүн юм.

Зураг 9. Дотоодын болон гадаадын лабораториудын шинжилгээ



Органик хүнсний үйлдвэрлэлийн бүхий л шатанд дүн шинжилгээ, сорилт хийх, тэдгээрийг баталгаажуулах, баримтжуулах нь органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах чухал хүчин зүйлийн нэг бөгөөд органик хүнсний бүтээгдэхүүнийг баталгаажуулахад лабораториудын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, тоног төхөөрөмжийн төрөл, хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. ХАА-н салбарын эрдэм шинжилгээ, судалгааны төв/хүрээлэнгүүдийн дэргэдэх болон орон нутаг дахь мэргэжлийн хяналтын байгууллагууд органик хүнс болохыг нотлох зарим сорил, шинжилгээг гүйцэтгэх тоног төхөөрөмжийн хүртээмж, хүчин чадлаас гадна төсвийн хүрэлцээгүй байдлаас үүдэн шинжилгээ хийдэггүй. Энэ нь анхан шатны үйлдвэрлэл эрхлэгчид үйл ажиллагаа явуулж буй газартаа бус төв суурин газарт бүтээгдэхүүнээ шинжлүүлэх, органик бүтээгдэхүүнээ экспортод гаргах бол гадаад улсын лабораторид шинжлүүлэх шаардлага үүсгэж байгаа нь органик хүнс үйлдвэрлэгчдэд хүндрэл, нэмэлт зардал үүсгэж байна. Хүнсний лабораториудын нөхцөл байдлыг Үндэсний аудитын газраас 2021 онд гүйцэтгэсэн “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн” аудитын тайланд⁹⁴ “Хүнсний шим тэжээл, чанар аюулгүй байдлыг шинжилж байгаа лабораториуд өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна Монгол Улсад хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд сорил туршилт хийх чиг үүрэг бүхий төрийн болон

⁹⁴ Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн” тайлан. Эх сурвалж: <https://audit.mn/?p=15813>

хувийн хэвшил, их дээд сургуулиудын харьяа лаборатори 2016 онд 66 байсан бол 2019 онд 69, 2020 онд 106 болж өмнөх оноос 37 буюу 34.9 хувиар өссөн байна. Орон нутгийн Мэргэжлийн хяналтын газрын лабораториудын одоо ашиглаж байгаа тоног төхөөрөмжийн 50 орчим хувийг 2000 оноос өмнө үйлдвэрлэсэн, элэгдлээ бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан, засвар, шинэчлэлт хийгээгүй зэргээс шалтгаалан үйл ажиллагаа нь доголдон итгэмжлэлийн хүрээн дэх шинжилгээг бүрэн хийж чаддаггүй байна. БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн 20.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2013 онд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн барилгыг барьж, тоног төхөөрөмжийг бэлтгэн хүчин чадлын хувьд улсын хэмжээнд тэргүүлэх лабораторийг бий болгосон боловч нийлүүлсэн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний зардал өндөр, хэрэглэх эм, урвалжийн хүрэлцээ хангалтгүйгээс 100 хувь хүчин чадлаар нь ашиглахгүй байна.” гэж үнэлснээс харахад лабораториудын үйл ажиллагааг бэхжүүлэх онцгой шаардлага байгааг харуулж байна.

Монгол органик брэнд үүсгэн бүтээгдэхүүнээ экспортолж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори болон бусад байгууллагын лабораториудын шинжилгээ хийх зарчим, шинжилгээний төрөл, үр дүн хангалтгүй байгааг үйлдвэрлэгчид онцолж байна. Ялангуяа Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораториос дээж авч шинжлэх хүнсний бүтээгдэхүүний жагсаалтад⁹⁵ органик хүнсийг оруулснаар олон нийтийн дунд органик хүнсний чанар, аюулгүй байдлын талаар эерэг мэдээлэл түгээхэд нөлөөлөх боломжтой.

Манай лабораториудын үр дүн олон улсад хүлээн зөвшөөрөгдөхөд хэцүү, Лабораториуд маань хангалтгүй байна. Үйлдвэрлэгч өөрөө хүссэн үедээ, хүссэн бүтээгдэхүүнээ шинжлүүлдэг, юу шинжлүүлэхээ өөрөө мөнгөндөө тааруулаад сонгодог. Хяналтын шинжилгээ хийдэггүй. Ийм учраас манай баталгаажуулалтын үр дүнг хүлээн зөвшөөрөхөд хэцүү. Жишээ нь өмхий махны хэрэг байна. Тэр бодисыг манайх шинжилж чадахгүй, ийм л байна. Бид бүтээгдэхүүнээ хүнд метал, пестицидийн үлдэгдэл гээд 30 орчим төрлийн шинжилгээ хийлгэнэ, гэтэл манай органик бүтээгдэхүүнийг худалдан авч буй импортлогч орон 300 гаруй үзүүлэлтээр шалгадаг. Иймээс бид гадаадад хийлгэсэн шинжилгээний дүндээ илүү итгэдэг. Манайх 7 төрлийн бүтээгдэхүүнээ улиралд нэг удаа шинжлүүлдэг, 7-14 хоногийн дотор хариу нь гарна, ойролцоогоор нэг сая гаруй төгрөг болдог.

Хаан жимс ХХК-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Манай төслийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй органик үйлдвэрлэгчид одоогоор дүүргүүдийн мэргэжлийн хяналтын лабораторид шинжилгээ хийлгээж байгаа. Нэг шинжилгээ 70-80 мянган төгрөг болдог. Манайхан 750 гаруй бүтээгдэхүүнтэй. Шинжилгээ хийлгэхдээ нэг удаад хэдхэн бүтээгдэхүүн авч явдаг, сая гаруй төгрөг төлдөг. Пестицидгүй гээд их баярладаг.

АДРА Монгол төслийн менежертэй хийсэн ярилцлагаас


⁹⁵ МХЕГ-ын 2016 оны “Аргачлал батлах тухай” А/167 дугаар тушаал. 3 дугаар хавсралт

Бид бүтээгдэхүүнээ Европын холбооны орнуудад нийлүүлэхийн тулд тухайн улсад органик бордоонд тавигдах шаардлагыг хангасан байх ёстой. Органик бүтээгдэхүүний шинжилгээгээ Германы Ханболдтын их сургуулийн лабораторид хийлгэсэн. Энэ лабораторийн шинжилгээний үр дүнг ЕХ-ны бүхий л улс хүлээн зөвшөөрнө, үүнийгээ бариад бид ЕХ-ны баталгаажуулалтын байгууллагаар органик бордоо бүртгүүлж болно гээд давуу талууд байна.

Монпеллэтс ХХК-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

В. Дотоод хяналт

ХАА-н хүнсний үйлдвэрлэл, түүн дотроо органик хүнсний үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, экспорт, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих чиг үүргийг Хүнсний тухай хуульд зааснаар аж ахуйн нэгж байгууллага хүнсний чиглэлийн үйл ажиллагаандаа дотоод хяналтыг⁹⁶ тогтмол хэрэгжүүлэх, мөн Органик хүнсний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д органик үйлдвэрлэлийн үйл явц болон органик хүнсийг хоёр жил тутамд баталгаажуулалтад хамруулах, 12 дугаар зүйлийн 12.2-т баталгаажуулалтын байгууллага байнгын хяналт тавих үүргийг тус тус тусгажээ. Мөн Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журмын 1.2⁹⁷-т ХББ-ын гишүүд харилцан бие биедээ хяналт тавих зарчмыг, 2.4-т ХББ-ын Хамтран ажиллах гэрээнд хяналт шалгалттай холбоотой зардал хуваарилах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын мэдээллийг ашиглах, нийтэд мэдээлэх тусгах тухай заасан бол 2.4.5-д⁹⁸ дотоод хяналт тавих этгээдийг томилох буюу 2.4.5.ижил төрлийн органик хүнс үйлдвэрлэгч ХББ-ын гишүүд харилцан бие биеийхээ, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч гишүүн нь анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч гишүүний үйл ажиллагааг тус тус хянах тухай, 4.2-т хяналт хийх багийн тухай, 4.7-д⁹⁹ жилд нэг удаа төлөвлөгөөт бус хяналт тавих тухай тус тус заажээ.



⁹⁶ Хүнсний тухай хууль. 12 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт.

⁹⁷ Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журмын 1.2. Хамтын баталгаажуулалтын байгууллага нь гишүүн үйлдвэрлэгчийнх нь бүтээгдэхүүн, үйл ажиллагаа Органик хүнсний тухай хууль тогтоомж болон бусад холбогдох дүрэм, журам, стандартад заасан шаардлагад нийцсэн эсэхийг харилцан бие биедээ хяналт тавих зарчмаар баталгаажуулан, баталгаажсан бүтээгдэхүүнээ орон нутгийн хэрэглэгчдэд санал болгох чиг үүргийг хэрэгжүүлнэ

⁹⁸ Мөн журмын 2.4.5.ижил төрлийн органик хүнс үйлдвэрлэгч ХББ-ын гишүүд харилцан бие биеийхээ, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч гишүүн нь анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч гишүүний үйл ажиллагааг тус тус хянаж, үнэлгээ өгөх, зөрчил, дутагдлыг илрүүлэх, гарсан зөрчлийг арилгахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;

⁹⁹ Мөн журмын 4.7. ХББ нь гишүүний үйл ажиллагаанд жилд нэг удаа төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг явуулна.

ХАА-н органик хүнс үйлдвэрлэлийн анхан шатны болон боловсруулах үйлдвэрлэлийн явцад тавих хяналтын нэг төрөл бол үйлдвэрлэгчийн дотоод хяналт юм. Органик хүнсний тухай хууль болон холбогдох журмуудад зааснаар дотоод хяналтыг тогтмол, төлөвлөгөөт бус хяналтыг жилд нэгээс доошгүй удаа хэрэгжүүлэх бол үйлдвэрлэлийн үйл явц болон органик хүнсийг хоёр жил тутамд баталгаажуулалтад хамруулах байдлаар үйлдвэрлэгчийн болон баталгаажуулалтын байгууллагын зүгээс хэрэгжүүлэх дотоод хяналт органик аж ахуй эрхлэгч, органик хүнс, тэжээл, бордоо үйлдвэрлэгч шалгалтын үр дүнд хангалттай сайн хэрэгждэг гэж үзэж болох юм.

Сэлэнгэ органикийн хамтын баталгаажуулалтын байгууллагууд жилдээ төлөвлөгөөний дагуу хяналтаа хийдэг, газар дээр нь очоод хөрс, ус, үр суулгац, бүтээгдэхүүн гээд бүхий л зүйлээ тойроод шалгана. Одоо энэ шалгалтаа хийж байгаа. Бие биенээ шалгаад явахаар шалгалтын баг бараг 2-3 долоо хоног ажиллаж байна. Сэлэнгэ органик төслийн менежертэй хийсэн ярилцлагаас

Бид хуулиар тогтоосон дотоод хяналт шалгалтаа тогтмол хийнэ. Анхнаасаа хамтын баталгаажуулалтын байгууллагыг сонгоогүй шалтгаан нь тойроод бие биеэ хянаад цаг алдаж байхаар хэдий үнэтэй ч хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагаар хянуулаад явах нь дээр гэж үзсэн. Шалгуулаад явсан нь илүү амар байдаг

Хаан жимс ХХК-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Харин органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, бордоо тэжээлийн хадгалалт, тээвэрлэлт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих асуудал зохицуулалтгүй байгаа нь органик бүтээгдэхүүний үндсэн шинж чанарт нөлөөлөх эрсдэлтэй байгаа нь үйлдвэрлэгчид, хэрэглэгчдийн эрх ашиг, эдийн засагт сөргөөр нөлөөлөх магадлалтай тул энэ төрлийн нарийвчилсан зохицуулалт бий болгох шаардлагатай байна.

Үнэлсэн байдал

Органик үйлдвэрлэл, органик хүнсэнд тавих хяналт, шошгоны хэрэглээ хэсэгт Органик хүнсний тухай хуулийн 12 дугаар зүйлд тусгасан органик үйлдвэрлэл, органик хүнсэнд тавих хяналтын хэрэгжилтийг “Органик үйлдвэрлэл, органик хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналтын мөрөөр хуурамч органик хүнсний бүтээгдэхүүний илрүүлэлт нэмэгдэнэ.” гэх томъёоллоор үнэлэхэд хуулийн хэрэгжилт **“ЗОРИЛГОДОО БҮРЭН ХҮРЭХГҮЙ”** байна

1. Органик хүнсний сүлжээний хяналт дотоод хяналт, хөндлөнгийн хяналт, төрийн хяналт шалгалт хэлбэрээр хэрэгжиж байна. Органик хүнс, хүнсний бүтээгдэхүүний тухайд өнөөгийн байдлаар энэ төрлийн үйл ажиллагаа гарааны шатандаа хөгжиж байгаа бөгөөд цөөн тооны үйлдвэрлэл эрхлэгч ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа нь баталгаажуулалтын байгууллагаас тавьж буй хөндлөнгийн болон гишүүд бие биедээ тавих дотоод хяналт хангалттай сайн хэрэгжихэд нөлөөлж байна. Харин органик буюу шинэ төрлийн ХАА-н үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүн бий болох эрх зүйн орчин бүрдэж энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо өсөж байгаа боловч төрийн хяналт шалгалтын тогтолцоо, үйл ажиллагаа энэ үйл явцтай уялдаагүй байна.

2. Төрийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Хилийн хорио цээрийн алба, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар зэрэг төрийн байгууллагын улсын байцаагчид байна. Мэргэжлийн хяналтын байгууллагаас хяналт шалгалт хэрэгжүүлж буй албан хаагчдын хүрэлцээ, ашиглаж буй тоног төхөөрөмж, хяналтын хуудас органик хүнсний сүлжээг хянах түвшний шаардлага хангахгүй байгаа нь органик аж ахуй эрхлэх, органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тэдгээрийн сав баглаа, боодол, тээвэрлэлт, хадгалалтын явцыг шалгахдаа “органик”-ийн шаардлага хангаж буй эсэхэд чиглэгдэхгүй байна. Түүнчлэн мэргэжлийн хяналтаас бусад байгууллагууд органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалттай холбоотой хяналт шалгалтыг хэрэгжүүлэхгүй байна.
3. Манай улсад үйл ажиллагаа явуулж буй хүнсний бүтээгдэхүүний лабораториуд олон улсын шаардлага хангах хэмжээнд органик түүхий эд, бүтээгдэхүүнийг шинжлэх чадамжгүй байгаа нь дотоодод баталгаажуулсан органик бүтээгдэхүүнийг экспортлоход хүндрэл үүсгэж улмаар төрөөс ХАА-н органик бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилгод сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Түүнчлэн хүнсний лабораториудын төлөвлөгөөт хяналтад органик хүнс, хүнсний бүтээгдэхүүнээс дээж авч шинжлэх зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.
4. ХАА-н органик хүнсний хадгалалт, тээвэрлэлт, экспорт, импорт, худалдаа, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт тавих эрх зүйн орчин дутмаг байна. Иймээс органик хүнсний холбоотой дээрх асуудлуудад хяналт тавих төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай.

Санал, зөвлөмж

1. Органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, тэжээл, бордооны үйлдвэрлэлд тавих төрийн хяналтын тогтолцоог сайжруулах үүднээс төрийн хяналтын байгууллагын хяналт шалгалтад ашиглах асуумж, хяналтын хуудас зэрэг баримт бичгийг шинэчлэх, боловсронгуй болгох, албан хаагчдыг органик хүнсний чиглэлээр мэргэшүүлэх,
5. Хүнсний бүтээгдэхүүний лабораториудын хүний нөөц, тоног төхөөрөмжийг сайжруулах замаар органик хүнс, хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, борлуулагч, хэрэглэгч өөрт хамгийн ойр байрлалд шинжлүүлэх боломжийг бүрдүүлэх,
6. Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лабораторид органик хүнсийг олон улсын шаардлага хангах хэмжээнд шинжлэх нөхцөлийг бүрдүүлэх,
7. Дотоодод үйлдвэрлэсэн болон импортын органик бүтээгдэхүүний тодорхой хувийг шинжилгээнд хамруулах зохицуулалт бий болгох
8. ХАА-н хүнсний үйлдвэрлэл, түүн дотроо органик хүнсний үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох,

ОРГАНИК ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭ, ШОШГО

2.1.4. Хуулийн 11 дүгээр зүйлийг “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

8	11 дүгээр зүйл. Органик хүнсний тэмдэг, тэмдэглэгээ, шошго 11.1.Энэ хуулийн 10.1-д зааснаар баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдэг, 10.2-т зааснаар баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдэглэгээг тус тус шошгод тавина. 11.7.Хүнсний шошгод монгол болон гадаад хэлээр бичигдсэн "органик", "байгалийн цэвэр", "байгалийн гаралтай цэвэр" гэсэн үгийг хэрэглэх бол энэ хуулийг дагаж мөрдөнө.	Органик хүнс, бордоо, тэжээл болохыг тодорхойлсон шошго хэрэглэх нь үйлдвэрлэгчид дарамт үүсгэхгүй. Органик шошгыг органик бус бүтээгдээгдэхүүн хэрэглэхгүй
---	--	--

Судалсан байдал

Монгол Улсад хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа, боодол болон шошгод хамаарах суурь эрх зүйн зохицуулалтуудыг Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, 2013 онд баталсан ХХААХҮСайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/46/115 тушаалаар баталсан “Зайлшгүй сав, баглаа болон боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журам”¹⁰⁰ болон MNS 6648:2016 “Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага” стандарт¹⁰¹-ад тусгажээ. Эдгээр ерөнхий шаардлагуудаас гадна органик хүнсний тухайд органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээг олгох, хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг Органик хүнсний тухай хууль болон ХХААХҮСайдын 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А-09 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар “Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам”¹⁰²-аар зохицуулж байна.

Органик хүнсний тэмдэг, тэмдэглэгээ, шошго хэрэглэх зохицуулалтыг авч үзвэл Органик хүнсний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 10.1-д зааснаар баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдэг, 10.2-т зааснаар баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдэглэгээг тус тус шошгод тавина”, мөн хуулийн 11.7 дахь хэсэгт “Хүнсний шошгод монгол болон гадаад хэлээр бичигдсэн "органик", "байгалийн цэвэр", "байгалийн гаралтай цэвэр" гэсэн үгийг хэрэглэх бол энэ хуулийг дагаж мөрдөнө.” гэж заасан бол болон журмын 3.7-д 100%, 3.8-д 90-99% органик орц найрлагатай хүнсэнд органик шошго хэрэглэх асуудлыг нарийвчлан тусгасан. Харин хуулийн 11.5 дахь хэсэг органик бус хүнс, тэжээл, бордоог

¹⁰⁰ Зайлшгүй сав, баглаа болон боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журам Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/12967>


¹⁰¹ MNS 6648:2016 “Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага. Стандартчиллын үндэсний зөвлөлийн 64-р тогтоолоор баталсан <https://estandard.gov.mn/standard/reader/2067#0-ndqdzshnswxqzacc.jpg>

¹⁰² Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам. ХХААХҮСайдын 2018 оны А-09 дүгээр тушаал. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/13149>

органик тэмдэг, тэмдэглэгээтэйгээр нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, зар сурталчилгаанд ашиглах¹⁰³, органик шилжилтийн үеийн бүтээгдэхүүнд органик тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэхийг хориглосон¹⁰⁴ зохицуулалтыг, журмын 3.9¹⁰⁵, 3.10¹⁰⁶-т органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ, “органик”, “байгалийн цэвэр”, “байгалийн гаралтай цэвэр” гэсэн мэдэгдэл хэрэглэхийг хориглох тохиолдлуудыг тусгажээ.

Органик хүнсний тухай хуулийн 11.6 дахь хэсэгт “Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журмыг хүнс, ХАА-н асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу ХХААХҮСайдын 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А-09 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар “Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам”¹⁰⁷-ыг баталсан бөгөөд уг журмын 3.1-д заасны дагуу Органик болохыг илэрхийлсэн 6 тэмдэг, тэмдэглэгээг ХХААХҮЯ-ны оюуны өмчөөр Оюуны өмчийн газрын гэрчлэх тэмдгийн 40-0019373 дугаарт бүртгүүлжээ.

Зураг 10. Органик тэмдэг, тэмдэглэгээ, ХХААХҮЯ



¹⁰³ Органик хүнсний тухай хуулийн 11.5.1.органик бус хүнс, тэжээл, бордоог органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээтэйгээр нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, зар сурталчилгаанд ашиглах;

¹⁰⁴ Мөн хуулийн 11.5.2.шилжилтийн үед үйлдвэрлэсэн хүнс, тэжээл, бордоог ногоон өнгийн дэвсгэртэйгээр нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, зар сурталчилгаанд ашиглах.

¹⁰⁵ 3.9.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний органик орц нь 70-89% байвал (Зураг3):

3.9.1.шошгоны нүүр хэсэгт, бүтээгдэхүүний оноосон нэрийн өмнө органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ, “органик”, “байгалийн цэвэр”, “байгалийн гаралтай цэвэр” гэсэн мэдэгдэл хэрэглэхийг хориглох бөгөөд бүтээгдэхүүний оноосон нэрний доод хэсэгт хамгийн өндөр хувьтай 3 хүртэлх органик орцын нэрийг зааж, “Органик-тай бүтээгдэхүүн” мэдэгдлийг ашиглаж болно. Органик гэсэн үг нь шошгоны нүүр хэсэгт байгаа бусад үгнээс ялгарсан, өөр өнгө, хэмжээтэй байж болохгүй.

¹⁰⁶ 3.10.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний органик орц нь 69%-иас бага, эсхүл органик бус бүтээгдэхүүн байвал (Зураг4):

3.10.1.шошгод органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ, “органик”, “байгалийн цэвэр”, “байгалийн гаралтай цэвэр” гэсэн мэдэгдлийг хэрэглэхийг хориглоно.

¹⁰⁷Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам. ХХААХҮСайдын 2018 оны А-09 дүгээр тушаал. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/13149>

Тодруулбал, Органик хүнсний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт зааснаар хүнс, тэжээл, бордооны орц, найрлага 90 болон түүнээс дээш органик түүхий эдээс бүрдсэн бол органик¹⁰⁸ бүтээгдэхүүнд тооцож дээрх тэмдэг, тэмдэглэгээг хэрэглэх эрх үүсэх юм. Эдгээрээс харахад органик хүнс, тэжээл, бордооны сав, баглаа, боодлын шошгололтод органик тэмдэг, тэмдэглээ хэрэглэх, шошготой холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн орчин хангалттай бүрджээ.

“Органик” тэмдэг, тэмдэглэгээ, шошгод хамаарах эрх зүйн орчин хангалттай бүрдсэн ч өөр хоорондоо зөрчилдсөн зохицуулалт, хуулиас давсан журам үйлчилж байна.

Харин Органик хүнсний тухай хуулийн 11.6¹⁰⁹ дахь хэсэг болон Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам¹¹⁰-аар органик ХАА-н үйлдвэрлэл, хүнс, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, тэжээл, бордоог органикаар баталгаажсан тохиолдолд “органик” тэмдэг, тэмдэглэгээ олгох, үүнтэй холбоотой журам батлах эрх, үүргийг Засгийн газрын гишүүн болон ХХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүлээлгэсэн. Гэтэл Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын даргын 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/181 тушаалаар баталсан “Органик бүтээгдэхүүн/Certified organic эко шошго хэрэглэх эрх олгох журам”¹¹¹-ын 9, 10 дугаар зүйлд заасны дагуу “Органик бүтээгдэхүүн” шошго хэрэглэх эрх олгож байгаа нь холбогдох хууль тогтоомжоос давсан журам үйлчилж байгааг харуулж байна.

Зураг 11. Органик тэмдэг, тэмдэглэгээ, МҮХАҮТ



Мөн Органик хүнсний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 10.1-д зааснаар баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдэг, 10.2-т зааснаар баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдэглэгээг тус тус шошгод тавина” гэж заасан нь гадаадын болон хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулсан бол тэмдэг, хамтын баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулсан бол тэмдэглэгээ хэрэглэхээр

¹⁰⁸ Органик хүнсний тухай хуулийн 5.2.Орцын 90 болон түүнээс дээш хувь нь органик найрлагатай хүнс, тэжээл, бордоог органикт тооцно.

¹⁰⁹ 11.6.Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

¹¹⁰ 3.2.Хамтын баталгаажуулалтын байгууллага болон хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагаас олгосон гэрчилгээ, түүхий эд, бүтээгдэхүүний органик орцын хувь хэмжээг тогтоосон тухай тэмдэглэл, албан хүсэлтийг үндэслэн хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажлын 14 хоногт багтаан бүтээгдэхүүнийг бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

¹¹¹ Органик бүтээгдэхүүн/Certified organic шошго. Эх сурвалж: <https://www.mongolchamber.mn/p/24>

ойлгогдох бол Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журмын 2.1-д “Хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллага болон Хамтын оролцооны байгууллагын баталгаажуулсан хүнсний бүтээгдэхүүнд хэрэглэх органик болохыг илэрхийлсэн тэмдэг нь Органик хүнсний тухай хуулийн 11.6-д заасны дагуу баталсан загвар, хэмжээ, төрөлтэй байна.” гэж заасан, мөн Органик хүнсний бүртгэл мэдээллийн сан organic.gov.mn-д байршуулсан органик болохыг илэрхийлсэн 6 тэмдэг, тэмдэглэгээний загвар¹¹² нь органик бүтээгдэхүүнийг баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулсан тохиолдолд “Органик” тэмдгийг, харин органик хүнсний үйлдвэрлэл шилжилтийн үед буюу баталгаажуулалтын байгууллагын хяналтад байгаа тохиолдолд “Органик” тэмдэглэгээг ашиглахаар харуулсан зэрэг нь “Органик” тэмдэг, тэмдэглэгээний хэрэглээг олон янзаар ойлгогдохоор тайлбарласан байгааг анхаарах шаардлагатай.

Органик тэмдэг, тэмдэглэгээг бүтээгдэхүүний шошгод байрлуулах нь ХАА-н органик хүнсний бүтээгдэхүүн, бордоо үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн борлуулалтад нөлөөгүй, үр өгөөжгүй, нэмэлт зардал болж байна.

Органик хүнсний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Энэ хуулийн 10.1-д зааснаар баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдэг, 10.2-т зааснаар баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдэглэгээг тус тус шошгод тавина.” гэж заасны дагуу органик хүнс, түүхий эд, бордоо, тэжээл, үр, суулгацаар баталгаажсан бүтээгдэхүүний жижиглэн худалдааны сав, баглаа, боодолд “органик” тэмдэг, органик шилжилтийн үеийн тэмдэглээ байршуулах үүрэг хүлээлгэжээ. Гэвч органик тэмдэг, тэмдэглэгээний өртөг өндөр буюу сав, баглаа боодлын зардлын 25-30%-ийг эзэлдэг нь эдийн засгийн хувьд бэхжээгүй ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэгчид төдийгүй органик бүтээгдэхүүнээ гадаадын зах зээлд нийлүүлж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд ч эдийн засаг, маркетингийн ач холбогдолгүй байх тул хуулийн зохицуулалт хэрэгжихгүй байна. Энэ нь дотоодын хэрэглэгчдийн органик хүнсний талаарх мэдлэг, мэдээлэл муу, органик хүнсний ач холбогдол, бүтээгдэхүүний зар сурталчилгаа хангалтгүй, хүнсний дэлгүүрүүд төдийгүй төрийн байгууллагууд ч “органик” шошгод ач холбогдол өгөхгүй байгаагаас гадна дотоодын худалдан авагчдын худалдан авах чадвар сул байгаа нь органик шошгоны ач холбогдлыг бууруулж байна.

Манайх дотоодод гаргаж байгаа бүтээгдэхүүндээ органик шошго хэвлүүлээгүй. Цаашид ч хэвлүүлэхгүй байх. Яагаад гэвэл энэ шошгыг хэвлүүлэхэд зардал ихтэй, за тэгээд “бар код”-той болно гэвэл бүр ч өндөр өртөгтэй болох байх. Хэрэв органик шошготой байлаа гээд хүмүүсийн сонголтод нөлөөлдөг бол бид хэвлүүлмээр байна. Гэтэл хүмүүс органик гэж, органик болохын тулд ямар их хөрөнгө, хүч зарцуулдаг талаар мэддэггүй. Бас дээрээс нь худалдан авалт хийхдээ аль хямдыг нь сонгодог. Яг адилхан чацаргана байж танайх яагаад үнэтэй юм гэхээс биш, органик уу үгүй юу гэж хардаг хүн одоогоор цөөн. Энэ талын мэдлэг муу болохоор хандлага ч мөн адил тийм. Энэ хандлагыг өөрчлөх ажлыг төрийн

¹¹² Органик хүнснийг баталгаажуулсан тэмдэг, тэмдэг тэмдэглэгээний тайлбар. Эх сурвалж: <https://organic.gov.mn/?#/logo>

байгууллагууд хийх хэрэгтэй байна. ХХААХҮЯ-аас гадна боловсролын байгууллага, мэргэжлийн хяналт гээд. Хувийн компани ийм ажил хийхээр зүгээр нэг ПР-аа хийж, бүтээгдэхүүнээ рекламдаж байгаа юм шиг ойлголт өгдөг. Иймээс манайх органик бүтээгдэхүүнийхээ рекламыг цацаж байгаагүй, цацлаа гээд нэмэргүй л дээ

Хаан жимс Эс Би Ти ХХК төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Манай Сэлэнгэ органикийн гишүүд маань үйлдвэрлэсэн бүх бүтээгдэхүүнээ шошголох боломжгүй. Жишээ нь 1 тариаланч 1 га-гаас 15 тн органик лууван авна, нийт 5 га газартай гэж үзвэл 75 тонн болно. Нэмүү өртөг шингээгээд 1-1 кг-аар нь савлаад зарвал, шошгынхоо зардлыг дийлэхгүй шүү дээ. Бид одоогоор сүлжээ дэлгүүрүүдэд бүтээгдэхүүнээ нийлүүлдэггүй, нэрийн барааны дэлгүүрүүдээрээ борлуулдаг. Дунд нь 1 бар код байршуулаад, мэдээлэл авах хүн нь уншуулаад явах боломжтой: Манайхан органик гэсэн стикер наадаг, тэр болгоныг нэг хүн наагаад л зогсоно. 1 ширхэг нь 30-50 төгрөгийн өртөгтэй байсан, одоо бол бүр өндөр. Тариаланчид маань одоогоор шошгын зардлыг мэдэрэхгүй байна. Яагаад гэвэл төслөөс хариуцаад явж байгаа болохоор.

Сэлэнгэ органик төслийн төлөөлөл

Манайх бордооныхоо бөөний баглаандаа органик шошго байршуулсан. Жижиглэнгээр борлуулна гэдэг чинь шошгоороо биш өөрийн маркетинг, танил талдаа сурталчлах байдлаар хэрэгждэг болохоор органик шошгын хэрэг байдаггүй.

Монпеллетс ХХК төлөөлөл

Органик шошгын төлөө баталгаажуулалт хийлгэх шаардлага байна уу гэдэг асуудал хөндөгдөнө. Өнөөдөр “Өө энэ чинь органик шошготой юм байна” гэж худалдан авалт, сонголт хийдэггүй. Хувь хүний маркетинг дээр л бүтээгдэхүүнээ борлуулдаг.

Органик Хөгжил ТББ-ын төлөөлөл

Үүнээс харахад органик бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс тодорхой арга хэмжээ хэрэгжүүлэх, органик бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжих замаар нийгэмд органик хүнсний бүтээгдэхүүний талаар мэдлэг, мэдээлэл олгох, органик хүнсний хэрэглээг өсгөх шаардлага байна. Тухайлбал, органик шошгын зардлыг бууруулах тухайд шошгын хэвлэмэл хэлбэрээс гадна бусад төрлийг нэвтрүүлэх боломжийг судлах шаардлагатай гэж үзлээ.

“Био”, “эко” зэрэг мэдэгдэл агуулсан бүтээгдэхүүн Органик хүнсний тухай хуульд заасан "органик", "байгалийн цэвэр", "байгалийн гаралтай цэвэр" гэсэн мэдэгдэл бүхий органик бүтээгдэхүүний зах зээлд сөргөөр нөлөөлөхөөс гадна хэрэглэгчдийг төөрөгдүүлж байна.

Органик хүнсний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7-д “Хүнсний шошгод монгол болон гадаад хэлээр бичигдсэн "органик", "байгалийн цэвэр", "байгалийн гаралтай цэвэр" гэсэн үгийг хэрэглэх бол энэ хуулийг дагаж мөрдөнө” гэж заасан бол эдгээр мэдэгдэлтэй ижил утгаар өрсөлдөөн бий болгож буй “био”, “эко” гэх мэдэгдлүүдийг

хэзээ, хэрхэн ашиглах талаар зохицуулалт үгүйлэгдэж байна. Тухайлбал, Монцамэ агентлагийн цахим хуудсанд “МҮХАҮТ-аас “Био Эко” бэлдмэлд “Органик бүтээгдэхүүн” эко шошго хэрэглэх эрхийн бичиг олголоо.”¹¹³ гэх мэдээ нийтлэгджээ. Үүнээс харахад бид хууль тогтоомжид заасан баталгаажуулалтын байгууллагаар баталгаажсан органик бүтээгдэхүүн, органик үйлдвэрлэл эрхлэгчид болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс эдгээр мэдэгдлүүд болон тэдгээрийг хэрэглэх нөхцөлийг тодорхойлох боломжийг судлах шаардлагатай юм.

Био, эко, органик, натурал зэрэг нэршлүүд нь бүгд л байгалийн, цэвэр буюу химийн орц найрлагагүй, байгальд ээлтэй гэх утга илэрхийлнэ. Зах зээлд борлуулагдаж буй бүтээгдэхүүний дунд “эко” болон “био” гэх мэдэгдэл түгээмэл байх тул эдгээрийг онцоллоо. Тодруулбал, “эко” гэдэг нь амьд бие организм болон тэдгээрийн хүрээлэн буй орчинтой харилцах харилцааг судлах экологийн шинжлэх ухаанаас гаралтай нэршил бөгөөд хүрээлэн буй орчинд хор хохирол учруулахаас урьдчилан сэргийлсэн, байгалиас нь ургуулан хөгжүүлсэн, дахин ашиглагдах хог хаягдал болох ашигтай бүтээгдэхүүн болон үйл явц дээр энэ хэллэг түгээмэл ашиглагддаг байна. Харин “био” гэдэг нь амьд бие организмуудыг биологийн талаас тодорхойлсон нэршил бөгөөд хүнсний бүтээгдэхүүний тухайд “био” гэх мэдэгдлийн европын улс орнууд түгээмэл ашиглах бөгөөд органик үйлдвэрлэлийн нэгэн адил аргаар үйлдвэрлэгдэж баталгаажсан бүтээгдэхүүнд хэрэглэх эрх олгодог байна. Эдгээр нэршлийг Европын холбооны орнууд органик бүтээгдэхүүндээ түгээмэл хэрэглэдэг онцлогтой.

Одоо мөрдөгдөж буй хуулийн хүрээнд органик мэдэгдэл хэрэглэх эрхийг зөвхөн хүнсний үйлдвэрлэл, хүнс, бордоо, тэжээл, үр, суулгацад олгох боломж бүрдсэн бол бусад гоо сайхан, барилгын материал, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнд энэ төрлийн баталгаажуулалт хийх эрх зүйн зохицуулалт байхгүй. Гэхдээ “органик” мэдэгдэлтэй нэгэн адил утга илэрхийлэх “эко” гэрчилгээ олгох стандарт, шаардлагууд цөөнгүй батлагдсаны дийлэнх нь байгаль орчны үйл ажиллагаатай холбогдож байгаа боловч олон нийтийн дунд “эко” нь “органик”-тай нэгэн утгатай мэт төөрөгдөл үүсгэхээр байна. Тухайлбал, MNS ISO 14020 : 2004 Эко тэмдэг ба мэдэгдэл – Ерөнхий зарчим¹¹⁴, MNS 5600 : 2003 Үндэсний эко-тэмдэг. Техникийн шаардлага, хэлбэр хэмжээ¹¹⁵ стандартуудыг дурдаж болох юм.



Иргэдийн органик, байгалийн гаралтай бүтээгдэхүүн хэрэглэх хандлагыг ашиглан баталгаажилт хийгээгүй бүтээгдэхүүний шошгод “органик”, “байгалийн гаралтай

¹¹³ "Органик бүтээгдэхүүн"-ий эко шошго хэрэглэх эрх олголоо. 2021.03.23. Эх сурвалж: <https://montsame.mn/mn/read/257804> Сүүлд нэвтэрсэн: 2022.08.23

¹¹⁴ <https://estandard.gov.mn/standard/v/4161>

¹¹⁵ <https://estandard.gov.mn/standard/v/5483>

цэвэр”, “байгалийн гаралтай” гэсэн мэдэгдлийг хийж, хэрэглэгчдийг төөрөгдүүлэн, хуурамч бүтээгдэхүүн үйлдвэрлэх явдал байсаар байна.

Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7 дахь хэсгийн хэрэгжилт хангалтгүй байна. Хуулийн зохицуулалт хэрэгжихгүй байхад нэг талаас хуулийн хэрэгжилтийг хангуулах төрийн хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь нөлөөлж байгаа¹¹⁶ бол нөгөө талаас үйлдвэрлэгч, хэрэглэгчийн хандлага нөлөөлж байна. Тухайлбал, 2019 онд МХЕГ, ШӨХТГ, НХХААГ-тай хамтран зах зээл дээр байгаа органик, байгалийн цэвэр, байгалийн гаралтай цэвэр гэсэн мэдэгдэл, шошго бүхий дотоодын болон импортын хүнсний бүтээгдэхүүнд улсын хэмжээнд тандалт судалгаа хийж 360 зах, худалдааны төв, дэлгүүр мухлагт худалдаалж байсан 9300 нэр төрлийн бүтээгдэхүүнийг хамруулснаас 38,9% нь Органик хүнсний тухай хууль, тогтоомжийг зөрчсөн хаяг шошготой байжээ. Тэгвэл энэ үзүүлэлт 3 жилийн дараа буюу 2022 онд ямар түвшинд хүрсэн талаар судалгаа байхгүй төдийгүй НМХГ, ШӨТХГ зэрэг байгууллагуудаас энэ чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

Аж ахуйн нэгжүүдийн хувьд ёс зүй гэж байна. Яг адилхан нэр төрлийн бүтээгдэхүүн хийж байгаа компанийг бид шүүхдээд ч юм уу, мэргэжлийн хяналтад өгөөд хариуцлага нэхээд байх хүсэлгүй байдаг.

Хаан жимс Эс Би Ти ХХК төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Бид органик хүнсээ нэрийн барааны дэлгүүрээрээ бүтэн жил борлуулж байж олох орлогоо нэг үзэсгэлэн худалдаанд гараад л хэд нугалж олдог. Гэтэл яг хажууд манайх ч гэсэн органик, ёстой цэвэр, ямар ч бордоогүй гээд зарж байгаа хүн байж л байна. Бүгд л хүч хөдөлмөрөө зараад ургуулсан ногоогоо зарах гэж оролдож байхад бид юу ч хэлж чаддаггүй. Гэхдээ бид органикаар баталгаажуулах гэж ямар хүч, хөрөнгө зардгаа бодохоор тэдэнтэй өрсөлдөөд адилхан үнээр зардаг нь хэцүү.

Сэлэнгэ органик төслийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Иргэдээс органик шошготой холбоотой гомдол ирдэггүй, манайхаас ийм төрлийн гомдлын дагуу зөрчлийн арга хэмжээ авсан тохиолдол гараагүй, ер нь Органик хүнсний тухай хуультай холбоотой шийтгэл оногдуулаагүй.

НМХГ-ын мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

Органик шошго, тэмдэг, тэмдэглэгээний зөрчилтэй холбоотой гомдол, санал бүртгэгдээгүй, шийдвэрлэсэн хэрэг байхгүй. Үүнд иргэдийн мэдлэг нөлөөлдөг байх.

ШӨХТГ-ын мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

Дотоодын зах зээлд борлуулагдаж буй бүтээгдэхүүнээс органикаар баталгаажаагүй боловч уг мэдэгдлийг хэрэглэсэн, мөн агуулга нэг “эко”, “био” мэдэгдэл хэрэглэсэн бүтээгдэхүүн их байгаа ч үүнтэй холбоотой гомдол, санал гаргах аж ахуйн нэгж, хувь

¹¹⁶ Энэ хэсгийн тайлангийн хуулийн хэрэгжилт хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

хүн цөөн байгаа нь органик хүнсний талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгаагаас гадна хэрэглэгч, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хандлага ч нөлөөлж байна.

Зураг 12. Органик шошгоны хэрэглээ



Үнэлсэн байдал

Органик хүнсний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг “Органик хүнс, бордоо, тэжээл болохыг тодорхойлсон шошго хэрэглэх нь үйлдвэрлэгчид дарамт үүсгэхгүй.” болон 11.7 дахь хэсгийг “Органик шошгыг органик бус бүтээгдэхүүн хэрэглэхгүй” гэх томъёоллоор “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд хуулийн хэрэгжилт “**ЗОРИЛГОДОО ХҮРЭХГҮЙ**” байна.

1. Органик хүнс, тэжээл, бордооны сав, баглаа, боодлын шошгод органик тэмдэг, тэмдэглээ хэрэглэх, шошготой холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн, холбогдох тэмдэг, тэмдэглэгээг Оюуны өмчийн газраар баталгаажуулсан байна. Гэвч хууль болон түүнийг дагалдан гарсан журмын зөрчлөөс үүдэн нэр томъёог нэг мөр ойлгож, хэрэглэх боломжгүй байна. Тодруулбал, Органик хүнсний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 10.1-д зааснаар баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдэг, 10.2-т зааснаар баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдэглэгээг тус тус шошгод тавина” гэж заасан бол Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журмын 2.1-д “Хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллага болон Хамтын оролцооны байгууллагын баталгаажуулсан хүнсний бүтээгдэхүүнд хэрэглэх органик болохыг илэрхийлсэн тэмдэг нь Органик хүнсний тухай хуулийн 11.6-д заасны дагуу баталсан загвар, хэмжээ, төрөлтэй байна.” гэж заасан, мөн Органик хүнсний бүртгэл мэдээллийн сан organic.gov.mn-д байршуулсан органик тэмдэг, тэмдэглэгээний загвар баталгаажсан органик бүтээгдэхүүн “Органик” тэмдгийг, шилжилтийн үеийн бүтээгдэхүүн “Органик” тэмдэглэгээг ашиглахаар харуулсан нь зөрчил үүсгэж байна.
2. Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын даргын 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/181 тушаалаар баталсан “Органик бүтээгдэхүүн/Certified organic эко шошго хэрэглэх эрх олгох журам” Органик хүнсний тухай хууль, холбогдох журмыг зөрчиж “Органик бүтээгдэхүүн” шошго хэрэглэх эрх олгож байна.
3. Органик хүнсний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан органик хүнс, түүхий эд, бордоо, тэжээл, үр, суулгацаар баталгаажсан бүтээгдэхүүний сав, баглаа, боодолд “органик” тэмдэг, органик шилжилтийн үеийн тэмдэглээ байршуулах үүрэг нь ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэгчид, органик хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд хүндрэл үүсгэж байна. Органик тэмдэг, тэмдэглэгээний өртөг зардлын 25-30%-ийг эзэлдэг боловч эдийн засаг, маркетингийн ач холбогдолгүй байгаа нь бүтээгдэхүүний шошгод органик тэмдэг, тэмдэглэгээ байршуулахаас татгалзах шалтгаан болж байна.
4. Органик шошго нэр хүндгүй, эдийн засгийн үр өгөөжгүй байхад хэрэглэгчдийн органик хүнсний талаарх мэдлэг, мэдээлэл муу, органик хүнсний ач холбогдол, бүтээгдэхүүний зар сурталчилгаа хангалтгүй, хүнсний дэлгүүрүүд төдийгүй төрийн байгууллагууд ч “органик” шошгод ач холбогдол өгөхгүй байгаатай холбоотой байна.
5. “Био”, “Эко” зэрэг мэдэгдэл агуулсан бүтээгдэхүүн Органик хүнсний тухай хуульд заасан "органик", "байгалийн цэвэр", "байгалийн гаралтай цэвэр" гэсэн мэдэгдэл бүхий органик бүтээгдэхүүний зах зээлд сөргөөр нөлөөлөхөөс гадна хэрэглэгчдийг төөрөгдүүлж байна. Үүнд хууль зөрчиж шошгожуулсан хүнсний бүтээгдэхүүнээс гадна гоо сайхан, барилгын материал, ахуйн хэрэглээний зэрэг бусад бүтээгдэхүүнд органик баталгаажуулалт хийх эрх зүйн орчин бүрдээгүй нь нөлөөлж байна.

- Хүнсний бүтээгдэхүүний шошгод “органик”, “байгалийн гаралтай цэвэр”, “байгалийн гаралтай” гэсэн мэдэгдлийг хийж, хэрэглэгчдийг төөрөгдүүлэн, хуурамч бүтээгдэхүүн үйлдвэрлэх явдал байсаар байгаад хуулийн хэрэгжилтийг хангуулах төрийн хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаа уялдаагүй, хангалтгүй, үйлдвэрлэгч, хэрэглэгчийн энэ төрлийн өргөдөл, гомдол гаргах хүсэлгүй байх хандлага нөлөөлж байна

Санал, зөвлөмж

- Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журмын 2.1 дэх заалт болон Оюуны өмчийн газрын гэрчлэх тэмдгийн 40-0019373 дугаарт бүртгүүлсэн тэмдэг, тэмдэглэгээг Органик хүнсний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт нийцүүлэх,
- Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын даргын 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/181 тушаалаар баталсан “Органик бүтээгдэхүүн/Certified organic эко шошго хэрэглэх эрх олгох журмыг хүчингүй болгох,
- “Органик” тэмдэг, тэмдэглэгээг бүтээгдэхүүний савлагаанд хэвлэмэл хэлбэрээс бусад зардал багатай хэлбэрээр байршуулах боломжийг судлах,
- Хууль тогтоомжийн шаардлага хангаж “Органик” мэдэгдэлтэйгээр борлуулагдаж буй бүтээгдэхүүний зах зээлийн нэр хүнд, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор “Био”, “Эко” зэрэг ижил утгатай мэдэгдэл агуулсан бүтээгдэхүүний нэр, шошгыг хуулиар зохицуулах шаардлагатай эсэхийг судлах,
- Хуурамч бүтээгдэхүүнд “органик” тэмдэг, тэмдэглэгээ ашигласан тохиолдлыг мэдээлэх, өргөдөл, гомдол гаргах боломжийн талаар олон нийтэд сурталчлах,

ХАРИУЦЛАГА

2.1.5. Хуулийн 13 дугаар зүйлийг “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

№	Зүйл, заалтын агуулга	Шалгуур үзүүлэлтийн томъёолол
9	13 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага 13.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 13.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Органик үйлдвэрлэл, органик хүнсний бүтээгдэхүүнд холбогдох хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэсэн байна.

Томъёолол

Органик хүнсний тухай хуулийн 13 дугаар зүйлд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын асуудлыг тусгасан байх ба хуулийн хэрэгжилтийг үнэлэхдээ “Органик үйлдвэрлэл, органик хүнсний бүтээгдэхүүнд холбогдох хууль тогтоомж зөрчсөн

этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэсэн байна.” гэх томьёоллоор “Зорилгод хүрэх түвшин” шалгуур үзүүлэлтээр үнэллээ.

Судалсан байдал

Органик хүнсний тухай хуулийг боловсруулах үндсэн шалтгааны нэг бол хүнсний бүтээгдэхүүнийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн органик аргаар үйлдвэрлэх, баталгаажуулах, органик бүтээгдэхүүний савлах, тээвэрлэх, худалдаалахаас эхлээд органик тэмдэг, тэмдэглэгээг ашиглах замаар органик хүнсний бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангах, хэрэглэгчийн эрх ашигт нийцүүлэх харилцааг зохицуулах явдал юм. Органик хүнсний тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд энэ хуулийг зөрчигчдөд хүлээлгэсэн хариуцлагын асуудлыг судлах нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг тогтооход чухал үзүүлэлт болно гэж үзсэн.

Органик хүнсний тухай хуулийн 13 дугаар зүйлд энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн болон Зөрчлийн хуульд заасан хуулийн хариуцлага хүлээлгэхээр тусгасан ба 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын¹¹⁷ Зургаадугаар буюу “Нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эрүүл ахуйн журмын эсрэг зөрчил” бүлгийн 6.16 дахь хэсэгт Органик хүнсний тухай хууль зөрчсөн тохиолдолд органик үйлдвэрлэл эрхлэгч, баталгаажуулалтын байгууллага болон органик шошгыг хэрэглэгч хуульд заасан шаардлага хангаагүй тохиолдолд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээс гадна хувь хүнийг 250 нэгжээс 400 нэгжээр, хуулийн этгээдийг 2500 нэгжээс 4000 нэгжтэй тэнцэх төгрөгөөр торгох, итгэмжлэлийг хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авахаар заажээ.¹¹⁸ 2020 онд Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар итгэмжлэгдсэн байгууллага, бүтээгдэхүүний талаарх бүртгэл, мэдээллийг цаг тухайд хөтлөх, холбогдох төрийн байгууллагуудад шаардлагатай мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд хүргүүлэх шаардлагыг хэрэгжүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасан хамгийн өндөр дүнтэй торгуулийн арга хэмжээ авахаас гадна, итгэмжлэлийг цуцлах хүртэл арга хэмжээ авахаар тусгасан нь органик хүнс үйлдвэрлэгчид болон баталгаажуулалтын байгууллагуудыг

¹¹⁷Зөрчлийн тухай хууль 2017 он.Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/12695>

¹¹⁸ 6.16 дугаар зүйл.Органик хүнсний тухай хууль зөрчих

1.Органик үйлдвэрлэл эрхлэгч хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Хуульд заасан органик үйлдвэрлэл эрхлэгчид тавигдах шаардлагыг хангаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Хуульд заасан:

3.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдах импортын органик хүнс;

3.2.органик хүнсний тэмдэг, тэмдэглэгээ, шошгод тавигдах шаардлагыг хангаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Баталгаажуулалтын байгууллага нь:

4.1.хуульд заасан журмыг зөрчиж органик хүнсийг баталгаажуулсан;

4.2.органик үйлдвэрлэл эрхлэгчийн мэдээллийг хуульд заасан хугацаанд холбогдох төрийн байгууллагад мэдэгдээгүй бол итгэмжлэлийг хүчингүй болгож хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

хариуцлагажуулах, органик бүтээгдэхүүний талаар хэрэглэгчдэд бодит мэдээлэл хүргэхэд чухал нөлөө үзүүлэх зохицуулалт болжээ.

*Манай байгууллагаас Органик хүнсний тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш Зөрчлийн хуулийн 6.16 дугаар зүйлд заасан үндэслэлээр аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн торгуулийн шийтгэл тавиагүй.*¹¹⁹ НМХГ

*Органик хүнсний тухай хууль зөрчсөн асуудлаар манайд гомдол ирээгүй, хяналт шалгалт хийгээгүй, арга хэмжээ аваагүй. 2019 онд хамтарсан багаар хяналт хийж байсан.*¹²⁰ ШӨХТГ

Органик хүнсний тухай хуулийг зөрчсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэслэлийг авч үзвэл 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн¹²¹ Тусгай ангийн Арваннаймдугаар буюу Эдийн засгийн гэмт хэрэг бүлгийн 18 дугаар зүйлийн 18.16 дахь хэсэгт¹²² заасан “Барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг зөрчих” гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хуульд заасан хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялын аль нэгээр шийтгэхээр тусгасан ба хүндрүүлэх нөхцөл бүрдсэн бол торгуулийн хэмжээ 14000 нэгж хүртэл, зорчих эрхийг хязгаарлах болон хорих ялын хэмжээ 3 жил хүртэл нэмэгдэж байна. Үүнээс гадна Хорьдугаар буюу Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг” бүлгийн 20 дугаар зүйлийн 20.12 дахь хэсэгт¹²³ заасан “Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх” гэмт хэрэг үйлдэж хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан эсхүл үлэмж хэмжээний хохирол учруулсан

¹¹⁹ Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хэлтсээс МУ-ын УИХ-ын гишүүн Ч.Ундрамын 2022.08.05-ны өдрийн УИХ-03/7503 дугаартай албан бичигт ирүүлсэн хариунаас

¹²⁰ Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас МУ-ын УИХ-ын гишүүн Ч.Ундрамын 2022.08.05-ны өдрийн УИХ-03/7500 дугаартай албан бичигт ирүүлсэн хариунаас

¹²¹ Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга. 2015 он. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/11634>

¹²² Эрүүгийн хуулийн 18.16 дугаар зүйл. Барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг зөрчих

1. Бусдын барааны тэмдэг, эсхүл газар зүйн заалтыг ашиглан хэрэглэгчийг төөрөгдөлд оруулан хуурамч бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, хадгалсан, тээвэрлэсэн, худалдсан, улсын хилээр нэвтрүүлсний улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:

2.1. байнга тогтвортой үйлдсэн;

2.2. зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

¹²³ Эрүүгийн хуулийн 20.12 дугаар зүйл. Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх

1. Эрүүл ахуйн шаардлага хангаагүй, хүний эрүүл мэндэд хохирол учруулж болох хүнсний, эсхүл хүнсний нэмэлт бүтээгдэхүүн зориуд худалдсан, түгээснээс хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учирсан, эсхүл үлэмж хэмжээний хохирол учирсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

болох нь тогтоогдвол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр заажээ.

Үнэлгээний явцад Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан үндэслэлээр хариуцлага хүлээлгэсэн тохиолдлыг шүүхийн шийдвэрийн цахим санд¹²⁴ байршуулсан Эрүүгийн хэргийн анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхүүдэд Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.16 болон 20 дугаар зүйлийн 20.12 дахь хэсэгт холбогдох шүүхийн шийдвэрүүдээс шүүж үзэхэд органик хүнс үйлдвэрлэл болон органик шошго хэрэглээтэй холбоотой шүүхийн шийдвэр байхгүй байгаа нь ХАА-н органик үйлдвэрлэгч болон хэрэглэгчийн зүгээс маргаан үүсгэдэггүй байх магадлалтайг харуулж байна.

Эрүүгийн хуулийн 20.12 дугаар зүйл болон Зөрчлийн тухай хуулийн 6.16 дугаар зүйлд заасан “Органик хүнсний тухай хууль зөрчих” зөрчлийн хэргийг 2017-2021 оны бүтэн жилд тус тус хянан шийдвэрлээгүй.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн мэдээлэл¹²⁵

Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын¹²⁶ 6 дугаар зүйлийн 6.16 дахь хэсэгт заасан Органик хүнсний тухай хууль зөрчсөн этгээдэд зөрчлийн хэрэг үүсгэсэн тохиолдол цөөн байхаас гадна энэ талаарх тоо мэдээлэл мөн л тодорхойгүй, олдоцгүй байна.

Үнэлсэн байдал.

Органик хүнсний тухай хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэх, зөрчлийг илрүүлэх ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байгаа тул хуулийн 13 дугаар заалт “**ЗОРИЛГОДОО ХҮРЭХГҮЙ**” байна. Тодруулбал, хуурамч органик бүтээгдэхүүний талаар хэрэглэгчид төдийгүй баталгаажуулалтын байгууллага, ХАА-н органик хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид гомдол гаргадаггүй, мөн хяналт тавих нэгж тодорхойгүй, нийгэмд органик хүнсний бүтээгдэхүүнийг органик бус хүнсний бүтээгдэхүүнээс хэрхэн ялгаж таних талаар мэдээлэлгүй байгаа зэргээс шалтгаалан өнгөрсөн 5 жилийн хугацаанд органик хүнсний үйлдвэрлэл, органик шошгоны хууль бус хэрэглээтэй холбоотой хэрэг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдээгүй зэргээс харахад хуулийн 13 дугаар зүйлд заасан хариуцлагатай холбогдох зохицуулалт хэрэгжихгүй байна.

Санал, зөвлөмж

1. Хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг хэрэгжилтийг хангуулах.

¹²⁴ Шүүхийн шийдвэрийн цахим сан. Эх сурвалж: <https://shuukh.mn/>. Сүүлд нэвтэрсэн: 2022.08.01

¹²⁵ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 8 сарын 17-ны өдрийн 01/986 тоот албан бичгээс

¹²⁶ Зөрчлийн тухай хууль 2017 он. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/12695>

ГУРАВ. ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА

ЕВРОПЫН ХОЛБОО

2020 оны 5 дугаар сард Европын ногоон хэлэлцээрийн хүрээнд Европын холбоо /цаашид ЕХ гэх/ 2030 он гэхэд тариалангийн талбайн органик нөөцийг 25 хувьд хүргэх зорилтоо зарласан. ЕХ-ны “фермээс сэрээ хүртэлх стратеги” нь Европын хүнсний аюулгүй байдлыг сайжруулах зорилготой. Энэхүү стратеги нь 2030 он гэхэд химийн пестицидийн хэрэглээг 50 хувь, аюултай пестицидийн хэрэглээг 50 хувь, химийн бордооны хэрэглээг 20 хувь, шим тэжээлийн бодисын алдагдлыг 50 хувиар бууруулах замаар Европын хүнсний системийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахад чиглэжээ.

Дээрх зорилтод хүргэхийн тулд органик бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх үүднээс ЕХ даяар органик хөдөө аж ахуйг цогц бодлогоор дэмжих шаардлагатай гэж үзсэн бөгөөд 2021 оноос эхлэн Европын хөдөө аж ахуй, хүнсний бүтээгдэхүүнийг сурталчлахад зориулагдах төсвийн тал орчим хувийг, тухайлбал, органик болон бусад тогтвортой үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг дотоод зах зээл болон гуравдагч орнуудад¹²⁷ сурталчлах, түгээн дэлгэрүүлэх кампанит ажлуудад зориулах, тухайлбал үзэсгэлэн худалдаа, яармагт оролцуулах, ЕХ-ны органик үйлдвэрлэгчдийн экспортын боломжуудын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, бусад улс орнуудтай байгуулсан чөлөөт худалдааны гэрээ, түүнтэй адилтгах гэрээг ашиглах гэх мэтэд зарцуулах юм.

ЕХ дээр дурдсан стратегийн зорилтод хүрэхийн тулд 2021 оны 3 дугаар сард органик ХАА-н үйл ажиллагааны шинэ төлөвлөгөөгөө гаргасан.¹²⁸ Энэхүү 23 үйл ажиллагаа бүхий органик үйл ажиллагааны төлөвлөгөө нь 3 үндсэн зорилгын хүрээнд хэрэгжинэ. Үүнд, (1) ЕХ-нд органик хүнсний хэрэглээг нэмэгдүүлэх, (2) органик хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, (3) үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг бэхжүүлэх. Эдгээр нь органик салбарын тогтвортой хөгжлийг бий болгох тулгын гурван чулуу аж. ЕХ эдгээр зорилтыг илүү сайн хэрэгжүүлэхийн тулд гишүүн орнуудаа үндэснийхээ хэмжээнд органик үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргах ХАА-н нэгдсэн бодлогын хүрээнд суурь боломжуудаа ашиглан органик ХАА-г дэмжих, ялангуяа, шилжилтийн үед байгаа аж ахуйд нэлээдгүй анхаарал хандуулахыг уриалжээ. Энэхүү үзэл бодлыг хүнсний тогтвортой үйлдвэрлэл, хөдөөгийн хөгжлийн өргөн хүрээнд авч үзэх шаардлагатайг тэмдэглээд Европын эдийн засаг, нийгмийн комисс нь улирлын шинж чанарыг харгалзан богино, орон нутгийн органик үйлдвэрлэл, маркетингийн сүлжээ нь хүнсний сүлжээнд илүү их нэмүү өртөг шингээх ирээдүйтэй арга зам гэж онцолсон ба мөн хөдөө орон нутагт ажлын байр бий болгох боломжтой гэжээ. Цаашид органик бүтээгдэхүүнийг нийгмийн эмзэг бүлэгт хүртээмжтэй байлгахын тулд зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг санал болгож, төрийн сектор (орон нутаг, хот, бүс нутаг, холбооны эрх баригчид) бүс нутгийн органик хүнсний бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтаар дамжуулан олон нийт илүү ихээр хэрэглэх боломжийг бий болгохыг зөвлөсөн (жишээлбэл, байгууллагын цайны газар г.м) байна. Ер нь эрэлтийг ихээр

¹²⁷ <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/HTML/?uri=CELEX:52021DC0141&from=EN>

¹²⁸ <https://www.fao.org/family-farming/detail/en/c/1440862/>

дэмжих, хэрэглэгчийг мэдлэгжүүлэх ажил чухал ба хэрэв нийлүүлэлт нь эрэлтээс давбал зах зээлийн эдийн засгийн зарчмаар органик үйлдвэрлэлийн өрсөлдөөн байхгүй болж, улмаар үнэ буурах гэсэн агуулгыг илэрхийлсэн байна. Хэрэглэгчийн өндөр итгэл нь органик тариалангийн амжилтын урьдчилсан нөхцөл болохыг онцолж хэрэглэгчид үйлдвэрлэлээс эхлээд боловсруулалт, хэрэглээ хүртэлх хүнсний сүлжээний бүх үе шатанд холбогдох үйлдвэрлэлийн стандартыг дагаж мөрдсөн гэдэгт итгэл үнэмшилтэй байх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал гэж үздэг. Тиймээс залилан мэхлэхээс урьдчилан сэргийлэх, мөшгөх тогтолцоог сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүд онцгой чухал. Ялангуяа дижиталчлалын санал болгож буй боломжуудыг ашиглах нь зүйтэй гэж үзэж байна. ЕХ-ны хэмжээнд органик хүнс үйлдвэрлэлд баримтлах гол хуулийн хүрээнд манай улсын хувьд анхаарвал зохих зарим асуудлуудыг судалж үзлээ.

Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, шошгололтын тухай шинэ хууль (2018/848)

ЕХ-ны хэмжээнд мөрдөгдөж буй органик бүтээгдэхүүнд хамаарах хууль тогтоомж, түүний хамрах хүрээний тухай товч авч үзвэл, 2018 оны 6-р сард ЕХ-ны органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, шошгололтын тухай шинэ хууль (2018/848) хэрэгжиж эхэлсэн. Анх энэ хууль 2021 оны 1-р сарын 01-нээс эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан, хэдий ч COVID-19 тахал зэрэг олон шалтгааны улмаас хэрэгжиж эхлэх хугацааг нэг жилээр хойшлуулжээ. Энэ хууль нь ЕХ-ын хэмжээнд "био" ба "эко" гэх мэт үгээс үүсэлтэй, эсхүл эдгээрийг товчилсон, эсхүл дангаар нь эсхүл хослуулан хэрэглэх¹²⁹, Холбооны хэмжээнд хавсралтад орсон аливаа хэл дээр бүтээгдэхүүний шошго, сурталчилгаанд ашиглах бол энэ хуулийг дагаж мөрдөхөөр заажээ.

Уг хууль 9 бүлэгтэй:

1. Ерөнхий зүйл, хамрах хүрээ, нэр томъёоны тодорхойлолт
2. Органик үйлдвэрлэлийн зорилго, зарчмууд
3. Үйлдвэрлэлийн журам
4. Шошгололт
5. Баталгаажуулалт
6. Албан хяналт ба бусад албан үйл ажиллагаанууд
7. Гуравдагч оронтой хийх худалдаа
8. Ерөнхий зохицуулалт (органик болон шилжилтийн үед байгаа бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөн ба мэдээлэл солилцох, тайлагнах болон дүрмийн бус зөвшөөрөх үйл ажиллагаа)
9. Үйл ажиллагааны, шилжилтийн болон төгсгөлийн зохицуулалт

ЕХ-ны 2018/848 органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, шошгололтын тухай шинэ хуулийн хамрах хүрээнд 1/амьд буюу боловсруулаагүй ХАА-н бүтээгдэхүүн, түүний дотор үр болон бусад ургамлын нөхөн үржихүйн материал; 2/ хүнсний зориулалтаар ашиглах боловсруулсан ХАА-н бүтээгдэхүүн; 3/тэжээл багтдаг ба шинэ хуулиар хуулийн хамрах хүрээ нь өргөжиж хөдөө аж ахуйд зөгийн лав, далайн давс, ноос болон бусад бүтээгдэхүүнүүдийг багтаасан байна. Органик хүнсэнд хамаарахгүй ч самнаагүй

¹²⁹Уг хуулийн 30-р зүйлд

ноос, боловсруулаагүй арьс шир, ургамлын гаралтай уламжлалт эмийн бэлдмэл, эфирын тос зэргийг хүнстэй нэг хуулиар зохицуулдаг байна. Харин зэрлэг амьтдыг агнах, загасчлахаас гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн процессыг бүрэн хянах боломжгүй тул органик гэж үзэхгүй, мөн нийтийн хоолны газруудын өөрсдийн байранд бэлтгэсэн хоол хүнс нь энэхүү журамд хамаарахгүй тул ЕХ-ны органик үйлдвэрлэлийн лого бүхий шошго, сурталчлахыг хориглосон байна.

Нэр томъёоны тодорхойлолтын тухайд

Тус хуульд орсон бараг бүх нэр томъёог тайлбарласан байх ба ингэхдээ өмнө нь хуульчилсан нэр томъёог тухайн хуулиас иш татаж оруулсан нэр томъёоны тодорхойлолт ихэнх хувийг эзэлжээ. Тухайлбал, органик үйлдвэрлэл, органик бүтээгдэхүүн, ХАА-н түүхий эд, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, болгоомжлох арга хэмжээ, шилжилтийн үе, шилжилтийн үед байгаа бүтээгдэхүүн, аж ахуй, үйлдвэрлэлийн талбар, органик үйлдвэрлэлийн талбар, шилжилтийн үеийн үйлдвэрлэлийн талбар, органик бус үйлдвэрлэлийн талбар, фермер, фермийн газар, шошголох асуудлаас гадна органик үйлдвэрлэл, органик бүтээгдэхүүн, ХАА-н гаралтай түүхий эд, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, болгоомжлох арга хэмжээ, шилжилт, шилжилтийн үеийн бүтээгдэхүүн, аж ахуйн нэгж, үйлдвэрлэлийн нэгж, органик үйлдвэрлэлийн нэгж, шилжилтийн үеийн үйлдвэрлэлийн нэгж, органик бус үйлдвэрлэлийн нэгж, аж ахуй эрхлэгч, фермер, ХАА-н бүс, ургамал, ургамлын нөхөн үржихүйн материал, органик үйлдвэрлэлд тохирсон органик сорт, эх ургамал, нөхөн үржихүйн үе шат, тариалангийн үйлдвэрлэл, тариалангийн бүтээгдэхүүн, ургамлын өвчин, хортон, биодинамик бэлдмэл, ургамал хамгааллын бүтээгдэхүүн, мал аж ахуйн үйлдвэрлэл, шувууны аж ахуйн верэнда барилга, залуу эм тахиа, өндөглөгч тахиа, ашиглах боломжтой талбай, загасны аж ахуй, загасны аж ахуйн бүтээгдэхүүн, хаалттай эргэлт бүхий загасны аж ахуй, нөхөн сэргээгдэх эрчим хүч, үржүүлгийн газар, усны бохирдол, олон төрлийн загас үржүүлэг, амьдралын цикл, дотоодод үржүүлсэн төрөл, зүйл, мал, амьтны эмнэлгийн үйлчилгээ, мал, амьтны эмнэлгийн эмийн бүтээгдэхүүн, бэлдмэл, хүнс, тэжээл, ул мөрийг мөрдөн тогтоох, үйлдвэрлэл, бэлтгэл, түгээлтийн үе шат, орц, шошгололт, зар сурталчилгаа, эрх бүхий байгууллага, хяналтын байгууллага, баталгаажуулалтын байгууллага, GMO, хүнсний нэмэлт, тэжээлийн нэмэлт, инженерчлэгдсэн нано-материал, харилцан тэнцүүгээр хүлээн зөвшөөрөх, үйлдвэрлэлийн туслах материал, хүнсний фермент, радиациар ионжуулах, урьдчилан савласан хүнс тахианы аж ахуйн байр, хөрсийг сайжруулах замаар тариалан эрхлэх, боловсруулаагүй бүтээгдэхүүн, боловсруулсан бүтээгдэхүүн, боловсруулах, органик эсхүл шилжилтийн үеийн органикийн шаардлага хангах, хашаа гэх зэргээр нийт 75 нэр томъёоны тодорхойлолтыг оруулжээ.

Баталгаажуулалтын байгууллагын төрөл, тэдгээрийг бүртгэх, мэдээллийн сан үүсгэх асуудлын тухайд

Хуулийн 40.1 дэх заалтад тусгаснаар эрх бүхий байгууллага (ЕХ) 2017/625 журмын III бүлэгт заасан нөхцөлөөс гадна энэ хуульд заасан нөхцөл хангагдсан тохиолдолд албан ёсны хяналтын (баталгаажуулах) тодорхой үүрэг, албан ёсны бусад үйл ажиллагаатай холбоотой тодорхой даалгаврыг хяналтын (баталгаажуулалтын) байгууллагад

шилжүүлж болно гэж заасан. Төрийн эрх бүхий байгууллага эрх олгосон хяналтын байгууллагын үйл ажиллагаанд жилд 1 удаа хяналт шалгалт хийдэг байна.

Тухайлбал, Германд 18-20 хувийн баталгаажуулалтын байгууллага байна. Хяналтын байгууллагууд дараах зүйлийг эрх бүхий байгууллагад хүргэдэг. Үүнд: 1/өмнөх оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн жил бүрийн 1 дүгээр сарын 31-ний дотор хяналтад хамрагдсан операторуудын жагсаалтыг, мөн (ЕХ) 2017/625 журмын 113 дугаар зүйлд заасан жилийн тайлангийн органик үйлдвэрлэл, органик бүтээгдэхүүний шошгололттой холбоотой хэсгийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор жил бүрийн 3-р сарын 31-ний дотор өмнөх онд хийгдсэн албан ёсны хяналт болон бусад албан ёсны үйл ажиллагааны талаарх мэдээллийг¹³⁰ хүргүүлдэг байна. Үүнээс гадна энэ хуулийн 52.1-д заасны дагуу Гишүүн улсууд 1/ баталгаажуулалт хийх эрх бүхий байгууллагын нэр, хаяг, 2/хяналтын байгууллага, хуулийн этгээдийн нэр, хаяг, кодын дугаартай холбоотой мэдээллийн жагсаалтыг тогтмол шинэчилж байх ёстой бөгөөд Гишүүн улсууд эдгээр жагсаалт болон түүнд гарсан аливаа өөрчлөлтийг Комисст хүргүүлж, нийтэд мэдээлнэ. Хуулийн 52.2. 1 дэх хэсэгт заасан мэдээлэлд үндэслэн Комисс 1 дэх хэсгийн (б) хэсэгт заасан хяналтын байгууллага, хуулийн этгээдийн шинэчилсэн жагсаалтыг интернэтэд тогтмол нийтэлнэ.

ЕХ-ны зарим гишүүн улс баталгаажуулах чиг үүргээ хувийн байгууллагад шилжүүлдэг ба зарим гишүүн улсын төрийн эрх бүхий байгууллага баталгаажуулах үйл ажиллагаа эрхэлдэг буюу төрийн болон хагас улсын хяналтын системтэй байна. Хувийн хяналтын буюу баталгаажуулалтын байгууллага ихэнх ЕХ-ны гишүүн оронд үйл ажиллагаа эрхэлдэг ба эдгээр хяналтын байгууллагуудыг төрийн эрх бүхий байгууллага баталж, хянадаг. Энэ нь чанарын удирдлагын гарын авлага, тухайн хувийн байгууллагын оффист хийсэн аудит дээр үндэслэдэг ба тухайн хяналтын байгууллагад болон тэдгээрийн ажилтнуудад үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг олгодог.

Органик үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр төр, орон нутаг, ААН-ийн хүлээх үүрэг

Энэ талаар ЕХ хуулиндаа нарийвчлан тусгаагүй. Харин ЕХ 2021 оны 3 дугаар сард органик ХАА-н үйл ажиллагааны шинэ төлөвлөгөө гаргасан. Энэхүү 23 үйл ажиллагаа бүхий органик үйл ажиллагааны төлөвлөгөө нь 3 үндсэн зорилгын хүрээнд хэрэгжинэ. Үүнд, (1) ЕХ-нд органик хүнсний хэрэглээг нэмэгдүүлэх, (2) органик хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, (3) үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг бэхжүүлэх. Эдгээр нь органик салбарын тогтвортой хөгжлийг бий болгох тулгын гурван чулуу аж. ЕХ эдгээр зорилтыг илүү сайн хэрэгжүүлэхийн тулд гишүүн орнуудаа үндэснийхээ хэмжээнд органик үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргах ХАА-н нэгдсэн бодлогын хүрээнд байгаа боломжуудыг ашиглан органик хөдөө аж ахуйг дэмжих, ялангуяа, шилжилтийн үед байгаа аж ахуйд нэлээдгүй анхаарал хандуулахыг уриалжээ. Энэхүү үзэл бодлыг хүнсний тогтвортой үйлдвэрлэл, хөдөөгийн хөгжлийн өргөн хүрээнд авч үзэх шаардлагатайг тэмдэглээд Европын эдийн засаг, нийгмийн комисс нь улирлын шинж чанарыг харгалзан богино, орон нутгийн органик үйлдвэрлэл, маркетингийн сүлжээ нь хүнсний сүлжээнд илүү их нэмүү өртөг шингээх ирээдүйтэй арга зам гэж

¹³⁰ Хуулийн 40.10-р заалт.

онцолсон ба мөн хөдөө орон нутагт ажлын байр бий болгох боломжтой гэжээ. Цаашид органик бүтээгдэхүүнийг нийгмийн эмзэг бүлэгт хүртээмжтэй байлгахын тулд зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг санал болгож, төрийн сектор (орон нутаг, хот, бүс нутаг, холбооны эрх баригчид) бүс нутгийн органик хүнсний бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтаар дамжуулан олон нийт илүү ихээр хэрэглэх боломжийг бий болгохыг зөвлөсөн (жишээлбэл, байгууллагын цайны газар г.м) байна. Ер нь эрэлтийг ихээр дэмжих, хэрэглэгчийг мэдлэгжүүлэх ажил чухал ба хэрэв нийлүүлэлт нь эрэлтээс давбал зах зээлийн эдийн засгийн зарчмаар органик үйлдвэрлэлийн өрсөлдөөн байхгүй болж, улмаар үнэ буурах гэсэн агуулгыг илэрхийлсэн байна. Хэрэглэгчийн өндөр итгэл нь органик тариалангийн амжилтын урьдчилсан нөхцөл болохыг онцолсон байна. Хэрэглэгчид үйлдвэрлэлээс эхлээд боловсруулалт, хэрэглээ хүртэлх хүнсний сүлжээний бүх үе шатанд холбогдох үйлдвэрлэлийн стандартыг дагаж мөрдсөн гэдэгт итгэл үнэмшилтэй байх нөхцлийг бүрдүүлэх нь чухал аж. Тиймээс залилан мэхлэхээс урьдчилан сэргийлэх, мөшгих тогтолцоог сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүд онцгой чухал. Ялангуяа дижиталчлалын санал болгож буй боломжуудыг ашиглах нь зүйтэй юм.

Сургалт, сурталчилгаа, эрдэм шинжилгээний асуудлын тухайд

Хуулийн 3.53 дахь хэсэгт “сурталчилгаа” гэж бүтээгдэхүүний борлуулалтыг шууд болон шууд бусаар дэмжих зорилгоор хандлага, итгэл үнэмшил, зан үйлд нөлөөлөх, төлөвшүүлэх зорилготой, эсхүл нөлөөлөх боломжтой аливаа бүтээгдэхүүнийг шошгоос өөр аргаар олон нийтэд таниулахыг хэлнэ гэжээ.

Бүтээгдэхүүн, түүний орц найрлага, тэжээлийн материалын шошго, сурталчилгааны материал болон арилжааны баримт бичигт органик нэр томьёог хэрэглэсэн бол энэ хуульд нийцсэн органик үйлдвэрлэлээс бий болсон бүтээгдэхүүн, орц найрлага, тэжээлийг хэрэглэгчид санал болгож байгаа гэж үзнэ. Тодруулбал, тухайн бүтээгдэхүүн нь энэ хуульд нийцүүлэн үйлдвэрлэсэн бол "био" ба "эко" гэсн нэр томьёо, тэдгээрийн үүсмэл эсхүл товчилсон, эсхүл дангаар нь болон хослуулан ЕХ-ны хэмжээнд гишүүн орнуудын хэл дээр тус бүтээгдэхүүний шошго, сурталчилгаанд хэрэглэж болно гэжээ.¹³¹

Хэрэв бүтээгдэхүүн нь энэ хуульд заасан шаардлагын дагуу үйлдвэрлэгдээгүй бол дээр дурдсан нэр томьёог бүтээгдэхүүний шошгод хэрэглэхийг ямар ч этгээд, байгууллагад Холбооны хэмжээнд хориглоно. Түүнчлэн, тухайн бүтээгдэхүүн, түүний орц найрлага нь энэхүү журамд нийцэж байгаа гэж хэрэглэгчийг төөрөгдүүлэх эрсдэлтэй бол ямар ч нэр томьёо, тэр дундаа барааны тэмдэг, компанийн нэрэнд болон дадал заншилд ашигласан нэр томьёог бүтээгдэхүүний шошго, сурталчилгаанд ашиглахыг хориглоно. Мөн шилжилтийн хугацаанд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг органик бүтээгдэхүүн эсхүл шилжилтийн үед байгаа бүтээгдэхүүн гэж шошголох, сурталчлахыг хориглоно. Харин тус хуулийн 10.4 дэх заалтаар зөвшөөрсөн шилжилтийн хугацаанд үйлдвэрлэсэн ургамлын нөхөн үржихүйн материал, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүн, ургамлын гаралтай тэжээлийн бүтээгдэхүүнийг энэ хэсгийн 1-д заасан нэр, томьёог

¹³¹ Хуулийн 30.1-р заалт/

ашиглан "шилжилтийн үеийн бүтээгдэхүүн" гэж шошголж, сурталчилж болно. Дээрх дурдсан нэр томъёог ЕХ-ны хуулиар тухайн бүтээгдэхүүн нь хувиргасан амьд организм агуулсан, хувиргасан амьд организмаас бүрдсэн эсвэл хувиргасан амьд организмаас үйлдвэрлэсэн гэж шошго, сурталчилгаанд оруулахыг шаарддаг бүтээгдэхүүнд ашиглахгүй.

Энэхүү хуульд нийцсэн бүтээгдэхүүний шошго, танилцуулга, сурталчилгаанд ЕХ-ны органик үйлдвэрлэлийн логог ашиглаж болно. ЕХ-ны органик үйлдвэрлэлийн логог сурталчилгаатай холбоотой мэдээлэл, боловсролын зорилгоор ашиглаж болно, гэхдээ ийм хэрэглээ нь тодорхой бүтээгдэхүүний органик үйлдвэрлэлийн талаар хэрэглэгчийг төөрөгдүүлэхгүй байхыг шаардсан ба логог энэ хуулийн V хавсралтад заасан журмын дагуу хуулбарласан байх ёстой.¹³² Энэхүү журамд нийцсэн бүтээгдэхүүний шошго, танилцуулга, сурталчилгаанд үндэсний лого, хувийн лого ашиглаж болно. Бүтээгдэхүүнийг энэ хуульд заасны дагуу үйлдвэрлээгүй, эсхүл органик бус бүтээгдэхүүнтэй холилдсон бол хяналтын/баталгаажуулалтын байгууллагууд нь (ЕХ) 2017/625 хуулийн 138 дугаар зүйлд заасны дагуу авах арга хэмжээнүүдээс гадна тухайн бүтээгдэхүүний цуврал болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааг бүхэлд нь шошголох, сурталчлахдаа органик үйлдвэрлэлийн талаар дурдаагүй гэдгийг баталгаажуулдаг байна.¹³³

Хэдийгээр сургалтын талаар тус хуульд тусгайлсан заалт байхгүй ч үйл ажиллагааны төлөвлөгөөнд энэ талаар тусгасан байна. Органик бүтээгдэхүүний ашиг тус, бэрхшээлийн талаарх хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх ажлуудыг хийх, энэ ажлыг сургуулиас эхлэх нь зүйтэй гэжээ. ЕХ сургуулиуд жимс, хүнсний ногоо, сүүний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг ба үүгээр дамжуулан органик бүтээгдэхүүний талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байгаа.

Органик хүнсний дотоодын хэрэглээг дэмжих чиглэлээр хэрэгжүүлдэг төрийн бодлого, үйл ажиллагаа, онцлог зохицуулалтын тухайд

Органик газар тариалангийн талаар холбогдох мэдлэг солилцоог дэмжихийн тулд фермийн зөвлөх үйлчилгээг бэхжүүлэх шаардлагатай. Өмнө хэсэгт дурдсан Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүднээс Европын Комисс хөдөө аж ахуй, ойн аж ахуй, хөдөө орон нутгийн органик салбарын онцлог эсвэл хамааралтай судалгаа, инновацид төсвийн 30-аас доошгүй хувийг зориулахаар төлөвлөсөн аж, тухайлбал, тариалангийн ургац болон генетикийн олон янз байдал, зарим маргаантай бүтээгдэхүүн (ургамал хамгаалах өөр бүтээгдэхүүн)-ийг орлох боломжийг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагаанд 2021 онд хөдөө аж ахуйг дэмжих төсвөөс органик бүтээгдэхүүнд 27 хувь буюу 49 сая еврог хуваарилсан байна. Түүнчлэн, органик үйлдвэрлэлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхийн тулд Европын Комисс жил бүр ЕХ-ны Органик өдрийг тэмдэглэх, органик хүнсний сүлжээний бүх салбарт шилдэг бүтээлийн шагналыг бий болгохоор төлөвлөжээ. Өөрөөр хэлбэл, ЕХ-ны органик хүнсний сүлжээн дэх шилдэг

¹³² Хуулийн 33.2 дахь заалт

¹³³ Хуулийн 42.1 дэх заалт

амжилтыг үнэлж, шагнал гардуулах замаар тус салбарыг олон нийтэд танилуулах. Жил бүр зохион байгуулах Европын органик шагналууд нь органик үнэ цэнийн сүлжээг нэмэгдүүлэх, хөгжүүлэх, идэвхжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулж байгаа Европын үйлдвэрлэгчийг урамшуулахад зориулагдсан юм. ЕХ-ны органик шагналыг

- Шилдэг органик фермер (эмэгтэй, эрэгтэй)
- Шилдэг органик хот
- Шилдэг органик бүс
- Шилдэг органик био дүүрэг
- Шилдэг органик ЖДҮ
- Шилдэг органик хүнсний жижиглэн худалдаалагч
- Шилдэг органик ресторан гэсэн 7 ангиллаар олгодог.

Органик хүнсний экспортыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлдэг төрийн бодлого, үйл ажиллагаа, онцлог зохицуулалт

Энэ хуулийн дагуу органик үйлдвэрлэлийн шаардлагыг хангасан гэдгийг нотлон ЕХ-ны органик логотойгоор ЕХ-оос органик бүтээгдэхүүнийг экспортлох боломжтой. Комисс нь гуравдагч орны гаалийн байгууллагад зориулагдсан баримт бичиг, ялангуяа органик экспортын гэрчилгээг боломжтой бол цахим хэлбэрээр олгох зэрэг зохицуулалтыг батална.

Органик хүнсний хяналтын тогтолцоо

Аж ахуйн нэгжүүд зөвхөн нэг баталгаажуулалтын байгууллагаар бүтээгдэхүүнээ баталгаажуулахыг хуульчилсан. Үйлдвэрлэгчийн бүлгүүдийг баталгаажуулахыг бүх гишүүн оронд хийхийг зөвшөөрсөн ба хяналтыг сайжруулахаар заасан. Жишээлбэл, фермийн хэмжээ, нэг бүлэгт байх гишүүдийн тоог тодорхой болгожээ. Эрх бүхий байгууллага, эсхүл зохих тохиолдолд хяналтын байгууллага, хяналтын этгээд нь 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу үйл ажиллагаагаа мэдэгдсэн, энэхүү журамд нийцсэн үйл ажиллагаа эрхэлж байгаа аливаа оператор эсвэл оператор бүлэгт гэрчилгээ олгоно. Гэрчилгээг энэ хуулийн хавсралтад заасан загварын дагуу гаргах ба дор дурдсан мэдээллийг агуулах ба боломжтой бол цахим хэлбэрээр гаргах; 1/ гэрчилгээнд хамаарах бүтээгдэхүүний ангилал, 2/ түүний хүчинтэй байх хугацаа, 3/ оператор эсвэл бүлэг операторуудын тодорхойлолт; 4/ мэдэгдсэн үйл ажиллагаа нь энэхүү журамд нийцэж байгааг баталгаажуулсан тухай тодорхойлолт. Гэрчилгээнд хамрах бүтээгдэхүүнийг дараах төрлөөр ангилна.¹³⁴ Үүнд:

- боловсруулаагүй ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, түүний дотор үр болон бусад ургамлын нөхөн үржихүйн материал;
- мал, малын боловсруулаагүй бүтээгдэхүүн;
- замаг ба боловсруулаагүй загасны аж ахуйн бүтээгдэхүүн;
- хүнсний зориулалтаар ашиглах боловсруулсан ХАА-н бүтээгдэхүүн, түүний дотор загасны аж ахуйн бүтээгдэхүүн;
- тэжээл;

¹³⁴ Хуулийн 35.7-р заалт/.

- дарс;
- энэ журмын I хавсралтад орсон болон өмнөх ангилалд хамаарахгүй бусад бүтээгдэхүүн.

Комисс нь гуравдагч оронд хяналт тавих, органик гэрчилгээ олгох эрх бүхий хяналтын байгууллагыг хүлээн зөвшөөрөх, эдгээр хяналтын байгууллагыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, хүлээн зөвшөөрөгдсөн хяналтын байгууллагуудын жагсаалтыг гаргах зорилгоор хэрэгжүүлэх актуудыг баталж болно.¹³⁵

Органик хүнс, бүтээгдэхүүний бүртгэл, мэдээллийн тогтолцоо

Гишүүн улсууд "органик" эсхүл "шилжилтийн үеийн өмнөх үед байгаа", эсхүл "шилжилтийн үед байгаа" аливаа бүтээгдэхүүнийг зах зээлд гаргахаас өмнө операторууд болон операторуудын бүлгүүдийн нэрийг агуулсан жагсаалтыг байнга шинэчилж хөтөлнө. Гуравдагч орноос ийм бүтээгдэхүүнийг импортлох, гуравдагч улсад экспортлох, эсхүл зах зээлд гаргаж буй органик болон шилжилтийн үеийн бүтээгдэхүүн бэлтгэх, түгээх, хадгалах үйл ажиллагаагаа эрхэлж байгаа операторууд, эсхүл операторын бүлгүүд гишүүн улсынхаа эрх бүхий байгууллагад энэ тухайгаа болон эдгээр үйл ажиллагаа нь баталгаажуулалтын хяналтад байгаа тухайгаа мэдэгдэнэ.¹³⁶

Гишүүн улсууд өмнөх хэсэгт дурдсан мэдэгдлийг хүлээн авах эрх бүхий байгууллагыг томилох, эсхүл батална. Гишүүн улсууд энэ хуульд заасны дагуу үйл ажиллагаагаа мэдэгдсэн операторууд болон операторуудын бүлгүүдийн нэр, хаягийг агуулсан шинэчилсэн жагсаалтыг хөтөлж, зохих журмын дагуу олон нийтэд мэдээлнэ. Ингэхдээ интернэтийн нэгдсэн цахим хуудасны холбоосыг ашиглах ба операторууд болон операторуудын бүлгүүдийн мэдээлэл бүхий иж бүрэн жагсаалтыг тэдгээрт олгосон гэрчилгээний мэдээллийн хамт оруулна. Энэ үйл ажиллагаанд гишүүн улсууд Европын Парламент болон Зөвлөлийн 2016/679 дугаар журамд заасан хувийн мэдээллийг хамгаалах шаардлагыг дагаж мөрдөнө.

Хүлээлгэх хариуцлага

Энэ хуулиар хариуцлагыг тусгайлан заагаагүй ба энэ нь тус Холбооны улсад мөрдөж буй бусад хуулиар зохицуулагддаг.

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Бүгд найрамдах Солонгос улсын органик үйлдвэрлэлд хамаарах эрх зүйн орчин болох Байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуй, загас агнуурыг дэмжих, органик хүнсний удирдлага болон дэмжлэг үзүүлэх тухай хууль нь 2017 оны 6-р сарын 3-ны өдрөөс хэрэгжиж эхэлжээ.

¹³⁵ Хуулийн 46.1-р заалт

¹³⁶ Хуулийн 34-р зүйл 1/

Хуулийн хамрах хүрээний тухайд энэ хууль нь байгальд ээлтэй хөдөө аж ахуй, загас агнуур болон органик хүнс гэсэн 2 асуудлыг хамран зохицуулсан байна. Энэ хуулийн байгаль орчинд ээлтэй ХАА, загасны гаралтай бүтээгдэхүүн, органик хүнс, органик ХАА-н болон загас агнуурын материалын тодорхойлолт, менежментийн талаарх заалт нь бусад хуулийн заалтаас давамгайлах ба байгальд ээлтэй хөдөө аж ахуй, загас агнуур болон органик хүнс, хүнсний бус боловсруулсан бүтээгдэхүүн гэсэн утгаар орсон.

Органик хүнс болон бусад органик бүтээгдэхүүнийг /гоо сайхан, ноос ноолуур, эмийн бэлдмэл зэрэг зарим бүтээгдэхүүнийг нэг хуулиар буюу байгальд ээлтэй хөдөө аж ахуй, загас агнуур болон органик хүнс, хүнсний бус боловсруулсан бүтээгдэхүүн гэсэн утгаар оруулсан байна.

Нэр томъёоны тодорхойлолт хэсэг

Байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуй ба загас агнуур, байгаль орчинд ээлтэй агро-загасны бүтээгдэхүүн (пестицидгүй ХАА-н гаралтай бүтээгдэхүүн, антибиотикгүй малын бүтээгдэхүүн, антибиотикгүй загасны бүтээгдэхүүн, химийн бодисгүй загасны бүтээгдэхүүн г.м), органик, органик хүнс, хүнсний бус органик бүтээгдэхүүн, органик агро-загасны материал, зөвшөөрөгдсөн бодис, үйл ажиллагаа эрхлэх, бизнесийн байгууллага гэсэн 9 нэр томъёог хуульчилсан.

Баталгаажуулалтын байгууллагыг бүртгэх, мэдээллийн сангийн асуудлыг төр дангаар хариуцдаг эсэх тухайд

Хөдөө аж ахуй, хүнс, хөдөөгийн яамны сайд эсвэл Далай тэнгис, загас агнуурын сайд нь баталгаажуулалтын байгууллагад органик хүнсийг баталгаажуулах итгэмжлэл олгодог. Хүчинтэй хугацаа 5 жил байна. Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон байгууллагад баталгаажуулалтын байгууллагуудад үнэлгээ хийх, итгэмжлэх олгох, сунгах эрхээ шилжүүлж болно. Түүнчлэн эдгээр сайд нар баталгаажуулалтын аудитуудад эрх олгодог.¹³⁷ Эрхийг цуцлах шалгууруудыг тодорхой заажээ. Баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагаанд холбогдох яамд хяналт шалгалт хэрэгжүүлдэг. Хэрэв баталгаажуулах үйл явц нь энэ хуульд нийцээгүй байвал эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авдаг¹³⁸. Хөдөө аж ахуй, хүнс, хөдөөгийн яамны сайд, далай тэнгис, загас агнуурын сайд нь баталгаажуулалтын түвшинг сайжруулах, сайн үйлчилгээ үзүүлдэг баталгаажуулалтын байгууллагыг дэмжих, сурталчлах зорилгоор тэдгээрийн үйл ажиллагаа, үйлчилгээний гүйцэтгэлийн байдлыг үнэлэн зэрэглэл тогтоож, үр дүнг нийтэд мэдээлдэг.¹³⁹

Органик үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр төр, орон нутаг, ААН-ийн хүлээх үүрэг

Энэ хуулиар төрийн төв байгууллагаас гадна орон нутгийн байгууллагын чиг үүргийг хуульчилсан. Төрийн төв байгууллага нь байгальд ээлтэй ХАА, загас агнуур болон органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төлөвлөгөө болон бодлого гаргах,

¹³⁷ Хуулийн 26-2 дахь заалт

¹³⁸ /32-р зүйл/.

¹³⁹ /32-2 дахь заалт/.

түүнчлэн орон нутгийн байгууллага, тариаланч, загасчдын сайн дурын оролцоог хөхиүлэн дэмжих бол орон нутгийн байгууллагууд эдгээрт нийцүүлэхээс гадна өөрийн орон нутгийн онцлогт тохируулан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлнэ гэжээ.

Мөн энэ хуулиар ХАА, загас агнуур, хөдөөгийн явдлын сайд болон Далай болон загас агнуурын сайд нар байгальд ээлтэй ХАА, загас агнуурыг дэмжих төлөвлөгөөг 5 жил тутам гаргаж хэрэгжүүлэхийг үүрэг болгосон. Уг төлөвлөгөөнд заавал тусгах асуудлуудын жагсаалтыг мөн хуулиар тогтоожээ. Үүнд:

- бодлогын зорилго, дэмжлэгийн чиглэл,
- байгаль орчинд бохирдуулж байгаа байдлын өнөөгийн түвшин,
- химийн бодис (синтетик пестицид, химийн бордоо, антибиотик, хөгц мөөгөнцөрийн эсрэг бэлдмэлүүд)-ын хэрэглээг бууруулах арга хэмжээ,
- төрөл бүрийн дэвшилтэт, байгаль орчинд ээлтэй технологиудын талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, сургах, хөгжүүлэх, зөвлөмжөөр хангах арга хэмжээнүүд,
- байгаль орчинд ээлтэй ХАА, загас агнуурын цогц загваруудыг хөгжүүлэх арга хэмжээ,
- байгаль орчинд ээлтэй ХАА, загас агнуурын бүтээгдэхүүн, боловсруулсан бүтээгдэхүүн, органик хүнсийг үйлдвэрлэх түгээх, экспортлох үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг холбох, хэрэглээг бий болгох,
- байгаль орчинд ээлтэй ХАА, загас агнуураас олон нийтийн хүртэх боломжийг өргөжүүлэх,
- олон улсын харилцааг хөгжүүлэх,
- төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилтийг бий болгох,
- баталгаажуулалтын байгууллагуудыг бойжуулах,
- бусад арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх зэрэг асуудлыг тусгах бөгөөд холбогдох сайд нар орон нутгийн засаг захиргааны удирдлагад төлөвлөгөөний талаар мэдээлэл хүргэх үүрэг хүлээнэ.

Орон нутгийн засаг захиргааны удирдлагууд орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргах үүргийг хуулийн 10 дугаар зүйлд заасан.¹⁴⁰ Үүний дагуу хөдөө аж ахуй, загас агнуурын нөөцийг хамгаалах, хүрээлэн буй орчныг сайжруулах тухайд (1) Тариалангийн газар, тариалан болон загасны аж ахуйд ашигладаг ус, агаар мандал, хөдөө аж ахуй, загас агнуурын бусад нөөцийг хадгалах, түүнчлэн хөдөө аж ахуй, загас агнуурын орчныг сайжруулах тухайлбал, хөрс, усны чанарыг сайжруулах зорилгоор тариалангийн газрыг сайжруулах, загасны аж ахуйд ашиглагдаж буй усыг бохирдуулахаас сэргийлэх, хүлэмжийн хийн ялгарлыг багасгах арга хэмжээг төр, орон нутгийн засаг захиргаа идэвхтэй хэрэгжүүлнэ гэж заажээ.

Баталгаажуулалтын тогтолцоог эрчимжүүлэх зорилгоор Хөдөө аж ахуй, хүнс, хөдөөгийн сайд буюу далай тэнгис, загас агнуурын сайд дараах ажлыг хэрэгжүүлнэ. Үүнд:

¹⁴⁰ 10 дугаар зүйл

- Энэхүү хуулийн дагуу баталгаажуулалтын тогтолцоог сурталчлахтай холбоотой асуудал;
- Баталгаажуулалтын тогтолцоог ажиллуулахад шаардлагатай боловсрол, сургалттай холбоотой асуудал;
- Энэхүү хуулийн дагуу баталгаажсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах загвар төлөвлөгөөг боловсруулах, түгээхтэй холбоотой асуудал багтана.

Сургалт, сурталчилгаа, эрдэм шинжилгээний асуудал

Хөдөө аж ахуй, хүнс, хөдөөгийн сайд, Далай тэнгис, загас агнуурын сайд, эсвэл орон нутгийн засаг захиргааны дарга нар нь байгальд ээлтэй хөдөө аж ахуй, загас агнуурыг хөгжүүлэхэд шаардлагатай судалгаа, шинжилгээ, түгээн дэлгэрүүлэх, боловсрол олгох бодлогуудыг гаргах, зааварчилгааны бодлого боловсруулна. Байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуй, загасны аж ахуйд шаардлагатай технологи, материал зэргийн гарын авлагыг боловсруулах үүргийг хүлээсэн. Мөн тариаланч, загасчид, хэрэглэгчид болон холбогдох төрийн албан хаагчийг байгальд ээлтэй ХАА, загас агнуурын талаар боловсрол олгох, сургахыг хуулиар дээрх албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолтод тусгасан байна. Холбогдох сайд, орон нутгийн засаг захиргааны дарга нар тариаланчид, загасчид, хэрэглэгчид болон холбогдох төрийн албан хаагчдад байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний талаар боловсрол олгох, сургах арга хэмжээ авч болно.

Аливаа этгээд органик гэрчилгээгүй аливаа бүтээгдэхүүнийг гэрчилгээтэй бүтээгдэхүүн мэтээр хэрэглэгчийг төөрөгдүүлэн сурталчлах, эсвэл баталгаажуулалтын мэдээлэлтэй нийцэхгүй сурталчилгаа хийхийг хориглодог.¹⁴¹

Органик хүнсний дотоодын хэрэглээг дэмжих чиглэлээр хэрэгжүүлдэг төрийн бодлого, үйл ажиллагаа, онцлог зохицуулалт

Хуулийн 5-2 дугаар зүйлд газар тариалангийн үндэс болсон хөрсний талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор жил бүрийн гуравдугаар сарын 11-ний өдрийг “Хөрсний өдөр” болгон тэмдэглэхээр хуульчилсан ба төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд Хөрсний өдөрт тохирсон арга хэмжээг багтаасан төслүүдийг хэрэгжүүлэхийг үүрэг болгожээ. Энэ хүрээнд 2021 оны "Органик өдөр" (6-р сарын 2)-ийн үеэр "Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулахын тулд органик хүнсийг хэрэглэцгээе" уриан дор орон даяар олон нийтийн арга хэмжээ зохион байгуулсан байна. Органик бүтээгдэхүүнийг сурталчлах, мэдлэг түгээх зорилгоор хэрэглэгчдийг органик талбайд будаа тариалах ажилд урьж, саванд тарьж болох будааны суулгац тараах, органик газар тариалан нь хөрсөн дэх нүүрстөрөгчийг ялгаруулж, уур амьсгалын өөрчлөлтийн шийдэл гэдгийг ойлгуулах зорилгоор их сургуулийн хорин мянга орчим оюутнуудад органик bibimbar (холимог ногоотой солонгос цагаан будааны хоол)-аар үйлчилэх зэрэг арга хэмжээ авсан байна. Мөн тус арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан симпозиумаар 2030 он гэхэд цагаан будааны бүх талбайг байгаль орчинд ээлтэй практикт шилжүүлэх, 2030 онд ийм талбайн хэмжээг 30 хувьд хүргэх; химийн бордоо, пестицид, антибиотикийг 50 хувиар бууруулах; “Газар тариалан, мал аж ахуйг

¹⁴¹ Хуулийн 30.8 дахь заалт

хосолсон дахин боловсруулах фермийн систем”-д шилжүүлэх, нийтийн хоолыг өргөжүүлэх зорилго бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг дэвшүүлсэн бөгөөд үйлдвэрлэгч, үйлдвэрлэгчийн холбоод, түгээгчид, экспортлогчид, баталгаажуулалтын байгууллага зэрэг энэ чиглэлд үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдүүдэд шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулах зарим зардлыг төрөөс дэмжих асуудлыг хуульчилсан.

Хөдөө аж ахуй, хүнс, хөдөөгийн сайд, далай тэнгис, загас агнуурын сайд, эсхүл орон нутгийн засаг захиргааны дарга нар нь байгальд ээлтэй хөдөө аж ахуй, загас агнуурыг хөгжүүлэх зорилгоор судалгаа, шинжилгээ, хөгжүүлэлт, түгээн дэлгэрүүлэх, боловсрол, технологи, материал ашиглах талаарх зөвлөх үйлчилгээний талаар бодлого боловсруулах ба шаардлагатай зардлыг татаасаар олгож болно.¹⁴²

Органик хүнсний хяналтын тогтолцоо

Хэрэв органик хүнсийг задгайгаар дахин савлахгүйгээр хадгалж, тээвэрлэж, импортолж, худалдаж байгаа бол баталгаажуулах шаардлагагүй, харин дараах тохиолдолд баталгаажуулалтад хамрагдах боломжгүй, үүнд:

- баталгаажуулалт нь хүчингүй болсноос хойш 1 жилийн дотор,
- хэрэв 2 болон түүнээс дээш бүтээгдэхүүн баталгаажуулалт хүчингүй болсноос хойш 2 жилийн дотор,
- бүтээгдэхүүний органик шошготойгоор худалдахыг хязгаарласан, хориглосон бол,
- үл тохирлыг торгууль, бусад шийтгэлээр дуусгаснаас хойш 1 жил өнгөрөөгүй.

Дээрхээс бусад тохиолдолд органик баталгаажуулалтад хамрагдах ба өргөдөл гаргах, баталгаажуулалт, хяналт шалгалт хийх зэрэг асуудлыг Хөдөө аж ахуй, хүнс, хөдөөгийн сайд, далай тэнгис, загас агнуурын сайд нарын баталсан журмаар нарийвчлан зохицуулна. Тухайлбал, хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар Хөдөө аж ахуй, хүнс, хөдөөгийн сайд, далай тэнгис, загас агнуурын сайд, эсхүл орон нутгийн засаг захиргааны дарга нар ээлжит шалгалт, үнэлгээг хийнэ. Үүнд:

- Тариалангийн талбайн үржил шим болон хүнд металл, пестицид, хөрсний бичил биет зэргийг үзэх;
- тариалан, загасны аж ахуйд ашиглаж буй гадаргын болон гүний усны чанар;
- Тариалан, загасны аж ахуйд ашиглагдаж буй пестицид, бордоо, антибиотик гэх мэт материалын өнөөгийн байдал;
- Усны нөөцийг ариглан, хөрсийг хамгаалснаар хөдөө аж ахуй, загасны аж ахуйгаас олон нийтэд хүртэх үр өгөөжийн өнөөгийн байдал;
- Газар тариалан, загас агнуурын аж ахуй орших нутаг дэвсгэрийн нөөцийн эргэлтийн ашиглалтын өнөөгийн байдал, түүний дотор малын бууцан бордоо.
- Байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуй, загас агнуурын өнөөгийн байдал, байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуй, загас агнуурын бүтээгдэхүүний тархалт, хэрэглээ гэх мэт;

¹⁴² Хуулийн 13-р зүйл

- Хөдөө аж ахуй, загас агнуурын нөөцийг хамгаалах, тариалан, загас агнуурын орчныг сайжруулахад шаардлагатай бусад асуудал багтаж байна.

Органик хүнс, байгальд ээлтэй ХАА, загас агнуурын бүтээгдэхүүн нь энэ хуульд заасны дагуу баталгаажуулалтад хамрагдсан бол энэ тухай мэдээллээ ил тод байршуулна. Органик хүнсийг Хөдөө аж ахуй, хүнс, хөдөөгийн сайд эсвэл далай тэнгис, загас агнуурын сайд¹⁴³ эсхүл дээрх яамдаас томилсон баталгаажуулалтын байгууллага гүйцэтгэх боломжтой. Баталгаажуулалтын хүчинтэй хугацаа 1 жил байна. Баталгаажсан ААН нь өөрийн үйлдвэрлэсэн, үйлдвэрлэдэг, боловсруулдаг, арчилж тордож буй баталгаат бүтээгдэхүүн дээр шууд тэмдэг хэрэглэж болох ба бүтээгдэхүүний сав баглаа, боодол дээр болон баталгаажсан бүтээгдэхүүний тодорхойлолт, баталгааны хуудсанд "органик" эсвэл ижил төстэй тэмдэглэгээг хийж болно. Хэрэв бүтээгдэхүүний борлуулалт нь савлагаагүй эсхүл ширхгээр хийгддэг бол органик шошгыг харуулсан самбар, дэлгэц байршуулж болохоор зохицуулжээ.¹⁴⁴

Хэрэв тухайн бүтээгдэхүүн органик орц найрлагатай бол зөвхөн тэр хэсгийг шошгод заана. Хөдөө аж ахуй, хүнс, хөдөөгийн сайд, далай тэнгис, загас агнуурын сайд шаардлагатай гэж үзвэл төрийн албан тушаалтан болон баталгаажуулалтын байгууллагаар дараах хяналт шалгалтыг хийлгэж болно. Үүнд:

1. Зах зээл дээр баталгаажсан бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх;
2. аж ахуйн нэгжийн органик гэрчилгээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, бүтээгдэхүүнтэй харьцах үйл явц нь энэ хуульд заасан баталгаажуулалтын аль нэг шалгуурт нийцэж байгаа эсэхийг тогтоох хяналт шалгалт. Энэ тухай урьдчилан мэдэгдэнэ.

Органик хүнс, бүтээгдэхүүний бүртгэл, мэдээлэл хариуцсан захиргааны байгууллагын тогтолцоо, хувийн хэвшилд шилжүүлдэг эсэх

Хөдөө аж ахуй, хүнс, хөдөөгийн сайд, далай тэнгис, загас агнуурын сайд нь дараах зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор байгаль орчинд ээлтэй байдлын баталгаажуулалтыг удирдах мэдээллийн системийг байгуулан ажиллуулж болно.¹⁴⁵ Үүнд:

- Баталгаажуулалтын байгууллагыг томилох, бүртгэх асуудал, баталгаажуулалтын нөхцөл байдал, импортын гэрчилгээний менежмент г.м;
- Баталгаажсан бүтээгдэхүүний талаарх мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, удирдах ажил г.м;
- Баталгаажсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, савлах, тээвэрлэх зэрэг үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ийн нэрсийн жагсаалт, тэдгээрийн талаар мэдээлэл өгөх;
- Баталгаажсан бүтээгдэхүүний нэр, холбоо барих мэдээлэл гэх мэт баталгаажсан бүтээгдэхүүний найдвартай байдлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллийг үйлчлүүлэгчдэд хүргэх асуудлууд багтана.

¹⁴³ /19-р зүйл/.

¹⁴⁴ 23-р зүйл

¹⁴⁵ /53.1 дэх заалт

Баталгаажуулалтын шалгуур хангаагүй бүтээгдэхүүнийг зах зээлд гаргахаас сэргийлэх үүднээс мэдээллийг нийтлэх үүрэгтэй. Мэдээллийн сан байгуулах, ажиллуулах асуудлыг сайд нарын баталсан журмаар зохицуулна.

Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Хууль зөрчсөн этгээдэд торгох, хорих, захиргааны шийтгэл оногдуулах боломжтой. Тухайлбал, итгэмжлэлгүй үйл ажиллагаа эрхлэх, итгэмжлэлийн хугацаа дууссаны дараа баталгаажуулалт хийх, хуурамч материал бүрдүүлэн итгэмжлэл авсан нь тогтоогдсон, эсхүл олон нийтэд ил болсон, баталгаажсан бүтээгдэхүүний шошгыг ашиглахыг түдгэлзүүлэх, шошгыг өөрчлөх үүрэг даалгаврыг биелүүлээгүй этгээдийг 3 жил хүртэл хорих, эсхүл 300 мянган вонтой тэнцэх торгууль ногдуулна.

Хэрэв баталгаажуулалтын гэрчилгээний мэдээллийг баталгаажуулалтын байгууллагаас зөвшөөрөл авахгүйгээр өөрчилсөн, эсхүл холбогдох баталгаажуулалтын баримт бичгийг хадгалаагүй, шинэчлээгүй, баталгаажсан бүтээгдэхүүнийг дахин савлаж органик логог наасан, шошголох стандартыг зөрчсөн, аудитын үр дүнг мэдээлээгүй, хүндэтгэх шалтгаангүйгээр хяналт шалгалт хийлгэхээс татгалзсан, зайлсхийсэн, саад учруулсан зэрэг үйлдэлд захиргааны шийтгэл буюу 5 мянга хүртэл воноор торгох гэх мэт арга хэмжээ авдаг байна. Мөн баталгаажуулалт хийх эрх авсан этгээд энэ тухайгаа мэдээлээгүй бол дээрх хариуцлага ногдуулна.

Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу холбогдох 2 яам захиргааны шийтгэлийг оногдуулж, торгуулийг хураах үүрэгтэй.

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС

Бүгд найрамдах Хятад ард улсын органик хүнсний тухай хууль тогтоомжийг судалж үзэхэд тус улсад “Органик бүтээгдэхүүн”-ий үндэсний стандарт (GB/T19630)-ыг 2019 онд шинэчлэн боловсруулж, 2020 оноос хэрэгжүүлж байгаа бол¹⁴⁶ 2014 онд батлагдсан Органик бүтээгдэхүүний баталгаажуулалтыг хэрэгжүүлэх захиргааны арга хэмжээ/дүрэм/-ийн дагуу баталгаажуулалт хийгдэж байна.¹⁴⁷ Стандартад мал, ургамлын гаралтай түүхий эд, хүнс, малын тэжээл, нэхмэлийн бүтээгдэхүүнийг органикаар баталгаажуулах асуудал багтана.

Органик баталгаажуулалт хийлгэхээр өргөдөл гаргах бүтээгдэхүүн нь "Органик бүтээгдэхүүний баталгаажуулалтын каталоги"-т орсон байх ёстой бөгөөд дараах бүтээгдэхүүнүүдийг дор дурдсан ангиллаар каталогт бүртгэдэг байна. Үүнд:

¹⁴⁶ “Органик бүтээгдэхүүн”-ий үндэсний стандарт (GB/T19630). Эх сурвалж: <https://www.chinesestandard.net/PDF/BOOK.aspx/GBT19630-2019>

¹⁴⁷ Органик бүтээгдэхүүний баталгаажуулалтыг хэрэгжүүлэх захиргааны арга хэмжээ/дүрэм/ Эх сурвалж: https://apps.fas.usda.gov/newgainapi/api/report/downloadreportbyfilename?filename=Revised%20Administrative%20Measures%20for%20Organic%20Product%20Certification%20_Beijing_China%20-%20Peoples%20Republic%20of_1-7-2014.pdf

- Ургамал болон хүнсний мөөг: тариалангийн таримал, хүнсний мөөг болон цэцэг, зэрлэг ургамал, хөвөн, хөвөн даавуу болон бусад даавуу, ногоон тэжээл, хятадын эмийн ургамал гэх мэт;
- Мал, шувуу: амьд амьтан, малын гаралтай бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн;
- Далайн гаралтай бүтээгдэхүүн: замаг, загас, сам хорхой, хавч зэрэг;
- Боловсруулсан хүнс: ургамал, мал, далайн гаралтай боловсруулсан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн;
- ТСМ боловсруулах: ургамлын гаралтай Хятадын уламжлалт эмийн боловсруулалтын бүтээгдэхүүн;
- Тэжээл: хүнсний үйлдвэрийн дайвар бүтээгдэхүүн, хүнсний ногоо, малын тэжээл;
- Нэхмэл: ээрэх болон нэхмэлийн зориулалттай байгалийн гаралтай утас.

Нэр томъёоны тодорхойлолт

Органик хөдөө аж ахуй, органик бүтээгдэхүүн, шилжилтийн үе, зэрэгцээ үйлдвэрлэл, хамгаалалтын зурвас, орц, мал, амьтны амьдралын цикл, хомотетик эмчилгээ, үржүүлгийн материал, биологийн олон янз байдал, генетик инжинеринг, генетикийн өөрчлөлт, генетик инженерчлэгдсэн организм, генетикийн өөрчлөлттэй организм, радиаци, ионоор радиацилах, найрлага, хүнсний нэмэлт, тэжээлийн нэмэлт, туслах бодис, органик үйлдвэрлэгч, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч, тээвэр, ложистикийн үйл ажиллагаа эрхлэгч зэрэг нэр томъёог хуульчилжээ.

Баталгаажуулалтын байгууллагын бүртгэл, мэдээллийн сан

2018 оноос эхлэн БНХАУ-ын Зах зээлийн зохицуулалтын улсын захиргаа (SAMR)-ны дэргэдэх Баталгаажуулалт хяналтын газар болон Баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн газар (CNCA)-ын дэргэдэх Баталгаажуулалтын хяналтын хэлтэс нь органик бүтээгдэхүүний баталгаажуулалтын ажлыг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүргийг хэрэгжүүлж байна. Баталгаажуулалтын байгууллагыг итгэмжлэх, үүний дараа баталгаажуулалт хийх асуудлыг Органик баталгаажуулалт, итгэмжлэлийн дүрэм /2003 онд батлагдсан/-ээр зохицуулдаг.¹⁴⁸

БНХАУ-ын нутаг дэвсгэрт органик баталгаажуулалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа болон гэрчилгээтэй органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг этгээдүүд энэхүү дүрмийг дагаж мөрдөнө. Энэ арга хэмжээний дагуу БНХАУ-ын Баталгаажуулалт, итгэмжлэлийн газар (цаашид CNCA гэх) нь органик баталгаажуулалтын үйл ажиллагааны ерөнхий зохицуулалт, нэгдсэн удирдлага, хяналтыг үндэсний хэмжээнд хариуцна.¹⁴⁹ Энэ арга хэмжээнд заасан органик баталгаажуулалт гэснийг энэ дүрмийн заалтад болон органик баталгаажуулалтын

¹⁴⁸ Органик баталгаажуулалт, итгэмжлэлийн дүрэм.2003. Эх үүсвэр: <http://extwprlegs1.fao.org/docs/pdf/chn65190.pdf>

¹⁴⁹ Дүрмийн 3-р зүйл/

дүрэмд үндэслэн холбогдох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, маркетингийн үйл ажиллагааг Хятад улсын үндэсний органик бүтээгдэхүүний стандартад нийцэж байгааг баталгаажуулалтын байгууллагаас нотлох тохирлын үнэлгээний үйл ажиллагаа гэж ойлгоно.

Органик үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр төр, орон нутаг, ААН-ийн хүлээх үүрэг

Орон нутгийн чанар, техникийн хяналтын газар болон хилээр нэвтрүүлэх хяналт, хорио цээрийн алба (цаашид орон нутгийн баталгаажуулалтын хяналтын хэлтэс гэх) нь тус тусын чиг үүрэг, үүргийнхээ хүрээнд органик баталгаажуулалтын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, хууль сахиулах үүрэгтэй.

Органик хүнсний экспортыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлдэг төрийн бодлого, үйл ажиллагаа, онцлог зохицуулалт

Экспортод гаргах органик бүтээгдэхүүн нь тухайн импортлогч улсын стандарт эсхүл шаардлагыг хангана.

Органик хүнсний хяналтын тогтолцоо

Дор дурдсан этгээдүүд нь БНХАУ-ын Баталгаажуулалт, итгэмжлэлийн газраас баталсан баталгаажуулалтын байгууллагаар “GB/T 19630” стандартын дагуу баталгаажуулалт хийлгэж, гэрчилгээ авах шаардлага тавьдаг байна. Үүнд

- органик бүтээгдэхүүн үйлдвэрлэгч: Органикаар баталгаажиж, хятадын органик баталгаажуулалтын тэмдэг хэрэглэх зөвшөөрөлтэй ургамал, амьтан, бичил биетний гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж буй компани, хувь хүн;
- Органик бүтээгдэхүүн боловсруулагч: Органикаар баталгаажиж, хятадын органик баталгаажуулалтын тэмдэг хэрэглэх зөвшөөрөлтэй ургамал, амьтан, бичил биетний гаралтай бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхэлдэг компани, хувь хүн;
- Органик бүтээгдэхүүний бизнес эрхлэгч: Органикаар баталгаажиж, хятадын органик баталгаажуулалтын тэмдэг хэрэглэх зөвшөөрөлтэй бүтээгдэхүүнийг тээвэрлэх, савлах болон худалдаалах үйл ажиллагаа эрхэлдэг компани, хувь хүн;
- органик бүтээгдэхүүний худалдаа эрхлэгч: Органик бүтээгдэхүүний бөөны болон жижиглэнгийн худалдаа, үзэсгэлэн худалдаа, түгээлтийн үйл ажиллагаа эрхэлдэг компани, хувь хүн.

Магадлан баталгаажуулалтыг жил бүр хийх бөгөөд үүнээс гадна Баталгаажуулалтын байгууллагад нь хяналт эсхүл гэнэтийн хяналт шалгалтыг эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн хийж болно.

Шошгын хэрэглээ

Хятадын органик бүтээгдэхүүний тэмдгийг баталгаажсан органик бүтээгдэхүүний шошго, зааварчилгааны гарын авлага, сурталчилгаа болон бусад материал дээр хэвлэж болно. Ингэхдээ тус тэмдгийг пропорциональ хэмжээгээр томруулж эсхүл багасгаж болох боловч өнгийг бууруулах, тодруулах, эсхүл хэлбэрийг нь өөрчилж үл болно.

"Шилжилтийн үеийн органик" гэсэн гэрчилгээтэй бүтээгдэхүүнийг зөвхөн шилжилтийн үеийн гэдгээр зарах боломжтой ба эдгээр бүтээгдэхүүн дээр хятадын органик тэмдэг, эсхүл "Органик" гэх мэт үг, тэмдэглэгээг ашиглахыг хориглоно.

Хятадын органик бүтээгдэхүүний тэмдгийг ул мөрийг тогтоох дахин давтагдахгүй кодыг баталгаажсан органик бүтээгдэхүүний хамгийн жижиг борлуулалтын савлагааны шошгод хэрэглэнэ.

Органик бүтээгдэхүүний шошго нь органик бүтээгдэхүүний үзүүлэлтүүд, ул мөрийг мөшгөх мэдээлэл, баталгаажуулалтын байгууллагын нэр, болон органик тэмдгийг багтаана.

Шошгыг шууд борлуулдаггүй органик боловсруулсан материалд хэрэглэхгүй байж болох ба сонирхсон хүмүүс QR кодыг уншуулж баталгаажсан бүтээгдэхүүний мэдээллийг авах боломжийг бүрдүүлнэ.

Онцлог зохицуулалтын тухайд Худалдах гэрчилгээг онцлох боломжтой байна. Худалдах гэрчилгээ нь бүтээгдэхүүний эзэмшигчээс худалдан авагчид олгодог борлуулалтын гэрчилгээ юм. Үүнийг худалдан авагч тал шаардана. Баталгаажсан оператор нь баталгаажсан бүтээгдэхүүнийг борлуулахаас өмнө Баталгаажуулалтын байгууллагад Худалдах гэрчилгээг авах хүсэлт гаргана. Органик кодтой баталгаажсан бүтээгдэхүүн борлуулах бол дахиж ийм өргөдөл гаргахгүй. Баталгаажуулалтын байгууллагад нь нийлүүлэлтийн гэрээ, нэхэмжлэх, хүргэлтийн мэдэгдэл гэх мэт багц баримт бичигт үндэслэн Худалдах гэрчилгээг олгоно.

Органик хүнс, бүтээгдэхүүний бүртгэл, мэдээлэл хариуцсан захиргааны байгууллагын тогтолцоо, хувийн хэвшилд шилжүүлдэг эсэх

БНХАУ нь органик баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлж, баталгаажуулалтын нэгдсэн каталог, нэгдсэн стандарт, баталгаажуулалтын дүрэм, баталгаажуулалтын нэгдсэн шошгыг хэрэгжүүлнэ. CNCA нь органик бүтээгдэхүүний баталгаажуулалтын каталог, баталгаажуулалтын дүрмийг боловсруулах, шинэчлэх, мөн тэдгээрийг хэвлэн нийтлэх үүрэгтэй /5-р зүйл/.

Органик баталгаажуулалтын байгууллага нь органик баталгаажуулалтын үйл ажиллагаа эрхлэхээс өмнө CNCA-аар батлагдаж, зохих хуулийн дагуу хуулийн этгээдийн статус авна. Баталгаажуулалтын байгууллагыг батлахдаа тэдний үйл ажиллагаа явуулах чадвар нь баталгаажуулалтын байгууллагад тавигдах үндэсний стандартын шаардлагад нийцсэн эсэхэд үндэслэнэ. Органик баталгаажуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг аудитор нь органик баталгаажуулалтын хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулахын өмнө аудиторын улсын бүртгэлийг хариуцсан байгууллагад бүртгүүлнэ.

Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Баталгаажуулалтын шошгыг хуурамчаар үйлдсэн, залилангаар ашигласан, хууль бусаар худалдаалсан этгээдэд БНХАУ-ын Бүтээгдэхүүний чанарын тухай хууль, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын импорт, экспортын түүхий эдийн хяналтын тухай болон тэдгээрийг хэрэгжүүлэх журам зэрэг хууль тогтоомж, захиргааны журмын дагуу орон нутгийн баталгаажуулалтын зохицуулах хэлтэс хариуцлага хүлээлгэнэ.

Баталгаажуулалтын байгууллагаас үйлдвэрлэлийн талбай нь шаардлага хангаагүй, эсхүл байгаль орчны шаардлагад нийцээгүй бүтээгдэхүүнд, эсхүл органик бүтээгдэхүүний каталогид ороогүй бүтээгдэхүүнд органик гэрчилгээ олгосон бол баталгаажуулалтын байгууллагад залруулга хийхийг шаардах ба 30,000 юанийн торгууль ногдуулна.

"Органик" гэсэн үг (Хятад эсвэл Англи хэлээр)-ийг олон нийтэд органик бүтээгдэхүүний тухай ойлголтыг төөрөгдүүлж болзошгүй байдлаар бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний сав баглаа боодол эсвэл шошгон дээр хэрэглэсэн бол орон нутгийн баталгаажуулалтын зохицуулах хэлтэс түүнийг засаж залруулахыг даалган, 30,000 юан хүртэл торгууль ногдуулна.

Хэрэв дараах нөхцөл байдлын аль нэг үүссэн тохиолдолд CNCA нь баталгаажуулалтын байгууллагад яаралтай залруулга хийх, энэ талаар олон нийтэд мэдээлэхийг сануулна¹⁵⁰.

Үүнд: Баталгаажуулалтын байгууллага

- энэ дүрмийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан CNCA-гээс тодорхойлсон шаардлагын дагуу органик шошго, кодыг мэдээллийн системд оруулаагүй бол;
- CNCA-гээс тодорхойлсны дагуу эсхүл энэ дүрмийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагын дагуу баталгаажуулалтын холбогдох мэдээллийг мэдээллийн системд илгээгээгүй эсхүл буруу мэдээлэл ирүүлсэн бол;
- 24 дүгээр зүйлд заасны дагуу холбогдох материалыг CNCA-д бүртгүүлэхээр гаргаж өгөөгүй бол.

Энэ дүрмийн 14 дүгээр зүйлийн заалтыг зөрчиж, баталгаажуулалтын байгууллагаас Үйлчлүүлэгчийн үйлдвэрлэсэн болон боловсруулсан органик бүтээгдэхүүнд олгосон органик бүтээгдэхүүнийг борлуулах зөвшөөрлийн тоо нь бодит тоо хэмжээнээс их байвал залруулга хийлгэж, 10,000-аас 30,000 хүртэл юань торгууль ногдуулна.

Энэ дүрмийн 16 дугаар зүйлийг зөрчиж 95%-иас бага органик орцын агууламжтай боловсруулсан бүтээгдэхүүнд органик баталгаажуулалт хийсэн бол баталгаажуулалтын байгууллагыг орон нутгийн баталгаажуулалтын зохицуулах хэлтэс нь залруулга хийхийг шаардаж, 30,000 хүртэл юанийн торгууль ногдуулна.

Баталгаажуулалтын байгууллага энэ дүрмийн 30, 31 дүгээр зүйлд заасны дагуу гэрчилгээг түдгэлзүүлж, хүчингүй болгож, энэ тухай нийтэд мэдээлээгүй бол БНХАУ-

¹⁵⁰ /51-р зүйл/

ын баталгаажуулалт, итгэмжлэлийн журмын 60 дугаар зүйлийн заалтын дагуу шийтгэл оногдуулна.

Дараах нөхцөл байдлын аль нэг үүссэн бол орон нутгийн баталгаажуулалтын зохицуулах хэлтэс залруулга хийхийг үйлчлүүлэгчид шаардаж, 10,000-аас 30,000 хүртэлх юанийн торгууль ногдуулна. Үүнд:

- энэ дүрмийн 5 дугаар зүйлийг зөрчин, органик баталгаажуулалт хийгээгүй боловсруулсан бүтээгдэхүүнийг органик гэж шошголох;
- баталгаажуулсан бүтээгдэхүүний шошгыг энэ дүрмийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт болон 34 дүгээр зүйлд заасныг зөрчиж хэрэглэсэн бол;
- Гэрчилгээг түдгэлзүүлэх явцад эсхүл гэрчилгээг хүчингүй болгосны дараа гэрчилгээ эсхүл органик шошгыг үргэлжлүүлэн ашигласан бол.

Баталгаажуулалтын байгууллага эсхүл баталгаажуулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч нь CNCA-ийн эсхүл орон нутгийн баталгаажуулалтын зохицуулалтын хэлтсийн хяналт, шалгалтын үр дүнг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд зохих журмын дагуу залруулга хийх, хэрэв залруулгыг хугацаанд нь хийгээгүй бол 30,000 хүртэл юанын торгууль ногдуулна.

Баталгаажуулалтын байгууллагын үйлчлүүлэгч нь импортын органик бүтээгдэхүүний талаар үнэн зөв мэдээлэл өгөөгүй, эсхүл улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт шалгалтыг хийх үед буй хилийн хяналт шалгалт, хорио цээрийн байгууллагаас шаардсан зохих гэрчилгээ аваагүй, эсхүл тухайн органик бүтээгдэхүүнд шаардлагатай хяналт шалгалт хийлгэх хүсэлт гаргаагүй, эсхүл хяналт шалгалтаас зайлсхийсэн бол БНХАУ-ын импорт, экспортын бараа бүтээгдэхүүний хяналтын тухай хуулийг Хэрэгжүүлэх журмын 46 дугаар зүйлд заасны дагуу хилийн хяналт шалгалт, хорио цээрийн байгууллага хариуцлага хүлээлгэнэ. Органик баталгаажуулалтын үйл ажиллагаанд гарсан бусад зөрчилд холбогдох хууль тогтоомж, захиргааны журам, яамны дүрэмд заасны дагуу хариуцлага тооцно зэрэг тодорхой зохицуулалтуудыг дүрэмдээ тусгаж өгсөн нь органик үйлдвэрлэгч, баталгаажуулалтын байгууллага болон бусад холбогдох этгээдэд ойлгомжтой байдлаар зохицуулагдсан байна.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Тус улсад органик фермийн талаар анх Ж. И. Родэйль дэвшүүлэн тавьж, Хөрс ба эрүүл мэнд сангаар дамжуулан органик тэжээлийг олонд түгээжээ. 1970-аад он гэхэд муж улсын түвшинд органик фермер болон худалдан авагчдын зохион байгуулалтууд үүсэж эхэлсэн. Улмаар органик бүтээгдэхүүний хүрээ өргөжиж, тодорхой стандарт, итгэмжлэлийн үйл ажиллагаа өрнөсөн боловч сайн дурын шинжтэй байв. 1980-аад оноос хэд хэдэн мужууд органик хүнсний үйлдвэрлэл, шошго зэргийг зохицуулсан хууль тогтоомж батлан гаргасан байдаг. Улмаар органик хэрэглээ өсөн нэмэгдэхийн хэрээр “органик” гэсэн хуурамч шошготой бараа бүтээгдэхүүн ч ихээр гарах болсон.¹⁵¹

¹⁵¹ K. DiMatteo, 'Case-Study-USA' in I. Källander and G. Rundgren (eds.), Building Sustainable Organic Sectors (IFOAM, 2008), pp. 176–180

Органик хүнсний хууль тогтоомж

АНУ-ын Конгресс 1990 онд Органик хүнс үйлдвэрлэлийн тухай хуулийг батлан гаргав. Тус хуулиар органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүнийг хадгалах, тээвэрлэх зэрэгтэй холбоотой суурь хэм хэмжээг тогтоож өгснөөс гадна магадлан итгэмжлэл, баталгаажуулалтын тогтолцоо, Үндэсний органик стандартын зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг тогтоосон. Уг хуулийн 2104 дэх хэсэгт зааснаар ХАА-н сайд нь органик баталгаажуулалтын хөтөлбөрийг батлан гаргаж, уг хөтөлбөрөөр үйлдвэрлэгч, органик бүтээгдэхүүнтэй харьцагч нарт чиглэсэн зохицуулалтыг гаргана.

Дээрх хууль батлагдсанаас хойш 10 гаруй жилийн идэвхтэй хэлэлцүүлгийн үр дүнд Үндэсний органик хөтөлбөрийг 2000 онд боловсруулж дууссан бөгөөд 2002 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Уг хөтөлбөрт органик бүтээгдэхүүн, савлах, хадгалах, хүргэх болон шошго тавихад баримтлах шаардлага, баталгаажуулалт хийх этгээдийг магадлан итгэмжлэх, органик баталгаажуулалт бүхий бүтээгдэхүүнд тавигдах доод шаардлага болон захиргаа, зохион байгуулалтын шинжтэй бусад асуудлыг тусгасан байдаг.

Органик хүнсний бүтээгдэхүүний баталгаажуулалт, гэрчилгээ олгох процесс

Үндэсний органик бүтээгдэхүүний тухай хуулийн 2115 дахь хэсэгт зааснаар ХАА-н яам нь органик хүнсний бүтээгдэхүүний баталгаажуулалт хийхэд баримтлах магадлан итгэмжлэх хөтөлбөрийг батлан гаргана. Энэ хэсэгт мөн баталгаажуулалт хийх төлөөлөгчдөд тавигдах шаардлагыг тусгасан. ХАА-н сайд нь ХАА-н зах зээлийн үйлчилгээ хариуцсан зохион байгуулагчийн туслалцаатайгаар магадлан итгэмжлэх, хяналт тавих ажиллагаанд хяналтын чиг үүрэг хэрэгжүүлдэг.

Төрийн болон хувийн хэвшлийн хийгээд гадаадын болон дотоодын аж ахуй нэгж нь дээрх зохион байгуулагчид магадлан итгэмжлүүлэхээр хүсэлт гаргана. Ингэхдээ магадлан итгэмжлэгдэхэд тавигдах шаардлагыг хангасан талаарх баримтыг хавсаргана. Дараах нийтлэг шаардлага тавигддаг:

- Органик бүтээгдэхүүнийг шалгах, баталгаажуулах хөтөлбөрийг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадварыг эзэмшсэн,
- Мэргэжлийн чиглэлээр хангалттай мэргэшсэн, дотоод удирдлага засаглалын хувьд хангалттай түвшинд зохион байгуулагдсан,
- Ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлсэн хангалттай зохицуулалтыг бүрдүүлсэн,
- Бүртгэл, тайлагнал, нууц хадгалах үүргийг чанд мөрдөх,

Органик баталгаажилтыг хийсний дараа “органик үйл ажиллагааны сертификат” гаргаж өгөх ба уг сертификатад уг эзэмшигчийн нэр, хаяг, сертификатын хүчинтэй болох огноо, органик бүтээгдэхүүний төрөл зэргийг тусгасан байна.

Органик хүнсний хяналтын тогтолцоо

Үндэсний органик хөтөлбөрт мөн тавигдах стандартад үл нийцэх байдал үүссэн тохиолдолд хэрхэхийг тусгасан. Баталгаажилтын төлөөлөгчийн зүгээс хийсэн шалгах, нягтлах ажиллагааны явцад үндэсний органик стандартыг зөрчсөн нь тогтоогдвол бичгэн хэлбэрээр мэдэгдэнэ. Сертификат эзэмшигч нь уг мэдэгдлийг авсны дараа алдаагаа залруулах, эсхүл татгалзаж болно. Татгалзал нь үндэслэлгүй, эсхүл алдаагаа залруулах арга хэмжээ нь амжилтгүй болсон бол зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох тухай мэдэгдэл бичгээр хүргүүлнэ. Түдгэлзүүлэх, хүчингүй болгуулах тодорхой үндэслэлийг тусгаагүй. Зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн бол алдаагаа залруулсан тухай баримтын хамт сэргээлгэх тухай хүсэлтийг Сайдад гаргана. Зөвшөөрөл нь хүчингүй болсон бол 5 жилийн хугацаанд дахин хүсэлт гаргах эрхгүй. Түүнчлэн органик бүтээгдэхүүний шошгыг мэдсээр байж буруугаар ашигласан бол 10, 000 ам.доллартай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна.

Органик хүнс, бүтээгдэхүүний бүртгэл, мэдээлэл хариуцсан захиргааны байгууллагын тогтолцоо, хувийн хэвшилд шилжүүлдэг эсэх тухайд

Сайд нь Үндэсний органик стандартын зөвлөлийн гишүүдийг томилох эрхтэй бөгөөд зөвлөл нь үндэсний органик стандартыг хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд туслах үүрэгтэй.¹⁵² Тус зөвлөл нь нийт 15 гишүүнтэй байна. Үүнээс 4 нь органик фермийн үйл ажиллагаа эрхэлдэг, 2 нь органик бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх гэх мэт ажил эрхэлдэг, 1 нь органик бүтээгдэхүүний худалдаа эрхэлдэг, 3 нь байгаль орчин хамгаалал, байгалийн нөөцийг хамгаалах чиглэлээр мэргэшсэн этгээд, 3 нь нийтийн ашиг сонирхол, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах бүлгийн төлөөлөл, 1 нь хор судлал, экологи, биохимийн талаар мэргэшсэн этгээд, 1 нь хуульд заасан баталгаажуулалтын төлөөлөгч байна.¹⁵³

ЯПОН УЛС

Япон улсын органик газар тариалангийн эрх зүйн орчны суурь нь 1950 онд батлагдсан ХАА-н болон ойн бүтээгдэхүүний стандартчилал, зохих шошгололтын тухай хууль юм. Уг хуулиар зөвхөн органик хүнс гэлтгүй ХАА-н болон ойн бүх бүтээгдэхүүний баталгаажуулалт, гэрчилгээ, импортын шаардлагын ерөнхий шалгуурыг тогтоосон. 2000 оноос хойш Хөдөө аж ахуй, ой, загасны агнуурын яам (ХААОЗААЯ) нь органик ургамал, органик боловсруулсан хүнс, органик малын гаралтай бүтээгдэхүүн, органик үр суулгацтай холбоотой хэд хэдэн цуврал стандартыг баталж нэмэлт өөрчлөлт оруулсан. Эдгээр стандарт (“JAS Organic Standards” гэх)-ын дагуу органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, боловсруулалтад тавигдах нарийвчилсан техникийн шаардлагуудыг заасан.

Эдгээр стандарт нь тус тусдаа өөр өөр органик бүтээгдэхүүнд тавих стандартыг зохицуулсан байдаг.

¹⁵² Органик хүнс үйлдвэрлэлийн тухай хуулийн 2119a
[https://www.ams.usda.gov/sites/default/files/media/Organic%20Foods%20Production%20Act%20of%201990%20\(OFPA\).pdf](https://www.ams.usda.gov/sites/default/files/media/Organic%20Foods%20Production%20Act%20of%201990%20(OFPA).pdf)

¹⁵³ Мөн хуулийн 2119b.

1. Ургамлын гаралтай органик бүтээгдэхүүний ХАА-н стандарт- (Japanese Agricultural Standard for Organic Products of Plant Origin)

Энэхүү стандартын 3-р зүйлд зааснаар “ургамлын гаралтай органик бүтээгдэхүүн” (хүнс болон уух зүйлсээр хязгаарлагдах) гэдэг нь дараах зүйлд (4-р зүйл) заасан шалгуурын дагуу үйлдвэрлэсэн ургамлын бүтээгдэхүүнийг ойлгоно гэж заасан.

2. Органик боловсруулсан хүнсний ХАА-н стандарт (Japanese Agricultural Standard for Organic Processed Foods)

Тус стандартын 3-р зүйлд зааснаар “Органик боловсруулсан хүнс” гэж дараах зүйл (4-р зүйл)-д заасан шалгуурын дагуу үйлдвэрлэсэн, бүх орц найрлагын (давс болон уснаас гадна) болон нэмэлт (боловсруулсан бодисоос гадна)-ийн 5 буюу түүнээс бага хувийг ургамлын гаралтай бүтээгдэхүүн (ургамлын гаралтай органик бүтээгдэхүүнээс бусад), малын гаралтай бүтээгдэхүүн (органик малын гаралтай бүтээгдэхүүнээс бусад), далайн гаралтай бүтээгдэхүүн, далайн гаралтай бүтээгдэхүүнээс гаргаж авсан боловсруулсан бүтээгдэхүүн болон нэмэлт (уух идэх зориулалттай хүнс болон хүнсний нэмэлтээр ашигладаг бодисоос бусад) зэргээс гаргаж авсан бол органик боловсруулсан хүнс гэж ангилагдана.

3. Органик тэжээлийн ХАА-н стандарт (Japanese Agricultural Standards for Organic Feed)

Энэ стандартын 3-р зүйлд зааснаар “Органик тэжээл” гэж дараах зүйл (4-р зүйл)-д заасан шалгуурын дагуу үйлдвэрлэсэн нийт орц найрлага (дараах зүйлд заасан Орц найрлагын жагсаалтын (F)~(I)-д заасан зүйлээс бусад) 5 буюу түүнээс бага хувийг ургамлын бүтээгдэхүүн (жагсаалтын В-д заасан ургамлыг гаралтай органик бүтээгдэхүүнээс бусад) сүү (органик сүүнээс бусад), далайн гаралтай бүтээгдэхүүн болон эдгээрээс гаргаж авсан бусад боловсруулсан бүтээгдэхүүнээс гаргаж авсан байхыг ойлгоно.

4. Малын гаралтай органик бүтээгдэхүүний ХАА-н стандарт (Japanese Agricultural Standard for Organic Livestock Products)

Энэ стандартын 3-р зүйлд заасан “Органик малын гаралтай бүтээгдэхүүн” гэдэг нь дараах зүйл (4-р зүйл)-д заасан стандартын дагуу өсгөсөн мал болон шувууны аж ахуй, эсхүл тухайн зүйлд заасан шаардлагын дагуу гаргаж авсан мал аж ахуйн болон шувууны аж ахуйн бүтээгдэхүүнийг ойлгоно.

Органик хүнсний бүтээгдэхүүний баталгаажуулалт, гэрчилгээ олгох процесс

Бүтээгдэхүүний шошго нь төөрөгдөл үүсгэхүйц байгаа тул дийлэнх хэрэглэгчид зөв сонголт хийхэд хүндрэлтэй байгаа тул ургамлын гаралтай органик бүтээгдэхүүн, малын гаралтай органик бүтээгдэхүүн болон боловсруулсан органик бүтээгдэхүүнийг Засгийн газрын тогтоолоор зохих ёсны шошготой байх зайлшгүй шаардлагатай гэж үзсэн. Үүн дээр үндэслэн, эдгээр бүтээгдэхүүнүүд нь органик Японы ХАА-н стандартыг хангаагүй, холбогдох тамга тэмдэг дарагдаагүй л бол “органик” эсхүл үүнтэй ижил, төөрөгдөл үүсгэж болохуйц нэршлийг шошгод ашиглах боломжгүй болсон.

Органик хүнсний бүтээгдэхүүний хяналт, баталгаажуулалтын тогтолцоо

1. Баталгаажуулалт хийх байгууллагуудын магадлан итгэмжлэл

Хөдөө аж ахуй, ой, загасны агнуурын яам нь Баталгаажуулалт хийх байгууллагын хүсэлтийг хүлээн авч, ХАА-н стандартын тухай хуульд заасан шаардлага хангасан эсэхийг шалган тогтоож, магадлан итгэмжлэл олгоно.

2. Операторын гэрчилгээ

Баталгаажуулалт хийх байгууллагууд нь ургамлын гаралтай органик бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, боловсруулсан хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид гэх зэргээс ирсэн хүсэлтийг хүлээн авч, баталгаажуулалтын техникийн холбогдох шаардлагыг хангаж байгаа эсэх шалгалтыг хийж, гэрчилгээ олгоно. Ийнхүү гэрчилгээ олгохдоо Баталгаажуулалт хийх байгууллага дараах тохиолдлыг шалгах зорилгоор баримт бичгийн шалгалт, газар дээрх үзлэгийг хийнэ:

- (i) Тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж буй талбай, газар нь органик бүтээгдэхүүний стандартыг хангаж буй эсэх
- (ii) Тухайн бүтээгдэхүүн, органик бүтээгдэхүүний стандарт шаардлага хангаж байгааг нотлох холбогдох бүртгэл хийх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг зөв удирдаж буй эсэх

3. Гэрчилгээ олгосон операторын үзлэг шалгалт

Баталгаажуулалт хийх байгууллагууд нь өөрсдийн гэрчилгээ олгосон аж ахуй эрхлэгч үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн органик бүтээгдэхүүний стандарт шаардлага хангаж байгаа эсэх талаар үзлэг шалгалтыг жилд дор хаяж нэг удаа хийнэ.

4. Гэрчилгээ олгосон операторуудын ангилалт

Гэрчилгээ олгосон органик ургамлын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, боловсруулсан органик хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид нь өөрсдийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхийн өмнө өөрсдийн үйлдвэрлэлийн шат дамжлагын бүртгэлийн дагуу ангилж, органик JAS гэсэн тэмдгийг ашиглана.

ТАВ. ДҮГНЭЛТ

Дэлхий дахинаа 1960-аад оноос эхлэн хүн амын өсөлт, хүнсний бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн бүтээгдэхүүний хэмжээг нэмэх зорилгоор газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлд ашигласан химийн бодисын хэмжээ, генийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүнүүд хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэх эргэлзээ үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн дунд газар авч эхэлснээр органик хөдөө аж ахуй, органик бүтээгдэхүүний эрэлт эрс нэмэгдэж, улмаар уламжлалт аргаар боловсруулсан, тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн, байгаль орчинд ээлтэй, байгалийн нөөцийг зохистой, хөнөөл багатай ашиглах замаар боловсруулж буй хөдөө аж ахуйн органик хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн эзлэх байр суурь улам бүр өсөн нэмэгдэж байна. Тухайлбал, Европын холбооны гишүүн орнууд 2020 оны 5 дугаар сард болсон Европын ногоон хэлэлцээрийн хүрээнд холбооны хэмжээнд 2030 он гэхэд тариалангийн талбайн органик нөөцийг 25 хувьд хүргэх зорилт дэвшүүлсэн бол Бүгд найрамдах Солонгос улсын хувьд 2030 он гэхэд цагаан будааны бүх талбайг байгаль орчинд ээлтэй практикт шилжүүлэх, 2030 онд ийм талбайн хэмжээг 30 хувьд хүргэх, химийн бордоо, пестицид, антибиотикийн хэрэглээг 50 хувиар бууруулах зорилт дэвшүүлэн ажиллаж байгаагаас харахад цаашид ХАА-н гаралтай органик хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэх, зах зээлд өрсөлдөх чадвар нь дэлхийн хэмжээнд хамгийн хурдацтай өсөх боломжтой салбарын нэг болох магадлалтай юм.

Манай улсын хувьд 2030 он гэхэд нийт ХАА-н бүтээгдэхүүний 5 хувийг органик баталгаажуулалтад хамруулах зорилт тавьсан нь гарааны бизнесийн түвшинд оршин тогтнож буй органик хүнсний үйлдвэрлэлийн цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход чухал алхам болсон бол үүнд УИХ-ын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол түлхэц болохоор байна.

Монгол орны газар нутаг, хөрс, цаг уурын онцлог нөхцөл байдал нь Монгол Улсыг төлөөлөхүйц ХАА-н органик брэнд бүтээгдэхүүнээр дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжийг бүрдүүлсэн. Иймээс мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдийг байгаль орчин, эко систем, хүний эрүүл мэндэд ээлтэй ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд дэмжих нь хөдөөг хөгжүүлэх, орон нутагт ажлын байр бий болгох замаар төвлөрлийг сааруулахаас гадна хамгийн гол нь эрүүл, баталгаатай, шим тэжээллэг хүнсээр хүн амаа хангах нөхцөл сайжрах юм.

Иймээс дэлхий нийтийн чиг хандлагад нийцсэн шинэ технологи, шийдэлд суурилсан органик үйлдвэрлэл эрхлэх нийгэм, эдийн засгийн хөшүүрэг бий болгох, органик бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл эрхлэгчдийн болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр органик хүнсний эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь манай органик үйлдвэрлэл олон улсын чанар, стандартын шаардлага хангах түвшинд хөгжих, шавхагдашгүй баялаг болох хөдөө аж ахуйн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өсөн нэмэгдүүлэх үндэс болох юм.

Төрөөс 2016 онд хүн амыг мал аж ахуй, газар тариалангийн гаралтай органик бүтээгдэхүүнээр хангах, органик хүнсний үйлдвэрлэлийг органик түүхий эдээр хангах тогтолцоог бүрдүүлэх, улмаар малчид, тариаланчдын орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг дээшлүүлэх зорилгоор Органик хүнсний тухай хуулийг баталснаас хойш 5 жилийн хугацаа өнгөрчээ. Иймээс Органик хүнсний тухай хуульд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “... хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх ...” гэж заасныг үндэслэн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэв.

Үнэлгээгээр хуулийн хэрэгжилтийн өнөөгийн түвшинг тодорхойлох, ХАА-н органик үйлдвэрлэл, органик хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд боловсруулах, эдгээр үйл явцыг удирдлага зохион байгуулалт, арга зүйгээр хангах, бүртгэх, хяналт тавих гээд хүнсний сүлжээний үе шатуудад тулгамдаж буй зарим асуудлыг тодруулахаас гадна органик үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих замаар хэрэглэгчдийг эрүүл, баталгаат хүнсээр хангах, үндэсний брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортын бүтээгдэхүүний төрөл, хэмжээг нэмэгдүүлж буй олон улсын чиг хандлагад нийцсэн бодлого, зохицуулалтыг төлөвлөхөд дэмжлэг үзүүлэхүйц үр дүнд хүрэхийг зорьсон.

Үнэлгээний хүрээнд Засгийн газрын “Аргачлал батлах тухай” 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д заасан “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтээр хуулийн зорилт, баталгаажуулалтын байгууллага, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэл, шошго зэрэгт тавих хяналт шалгалт, хариуцлага зэрэг асуудалд холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийг онцлон судалсан бол хуулийг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлохын тулд “Харьцуулах арга”-ыг сонгон гадаад орнуудын органик хүнсний хууль тогтоомжоос холбогдох зохицуулалтыг судалсан. Гадаад орнуудын туршлагаас судлахдаа манай улстай хөрш зэргэлдээ байдал, худалдааны гэрээ байгуулсан байдал, бараа эргэлт, зах зээлийн боломж болон олон улсад эзлэх байр суурь зэрэг суурь үзүүлэлтүүдийг харгалзан Европын холбоо, БНХАУ, Япон, Солонгос, Америкийн нэгдсэн улсын Органик хүнсний тухай хууль тогтоомжийн хүрээнд дээр дурдсан асуудлуудыг судаллаа.

Эрх зүйн орчны тухайд

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний “амьд явах эрх”-д хүнсний аюулгүй байдал, эрүүл, баталгаатай, шим тэжээллэг хоол, хүнсээр хангагдах асуудал чухал байр суурь эзэлнэ. Иймээс хүнсний сүлжээнд, түүн дотор ХАА-н органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд үйлдвэрлэх, боловсруулах зэрэг үйл ажиллагаанд хамааралтай 20 орчим хууль, мөн тооны дүрэм, журам үйлчилж байна. Органик үйлдвэрлэлийг дэмжих талаарх эрх зүйн орчныг бүрдүүлж буй хууль тогтоомжуудад Органик хүнсний тухай хууль, түүнтэй уялдан гарсан журмуудаас гадна Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Тариалангийн тухай хуулиуд органик хүнс, тэжээл, бордоотой холбоотой зохицуулалт агуулжээ. Бодлогын баримт бичгийн тухайд “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” -д хүнс, ХАА-н

бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, ялангуяа хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог сайжруулах замаар хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, олон улсын жишигт нийцүүлэх, улмаар иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, цаашлаад хөрсний доройтлыг бууруулах зэрэг ерөнхий асуудлыг тусгасан боловч ХАА-н органик бүтээгдэхүүний талаар тодорхой зохицуулалт агуулаагүй. Харин УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт эрүүл, аюулгүй хүнсний хэрэглээг дэмжихэд буюу хүнсний үйлдвэрлэл, түүн дотор органик брэнд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, түүний хэрэглээг дэмжих, хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл, ул мөрийг мөшгөх, баталгаажуулах, хянах тогтолцоог боловсронгуй болгох, бүтээгдэхүүн тээвэрлэлтийн сүлжээг сайжруулах зэрэг органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжихээр өргөн хүрээтэй тусгагдсан нь бодлогын түвшинд ахиц гарсныг харуулж байна.

Хэдийгээр ХАА-н органик үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр төрийн бодлогод тусгасан ч түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, арга хэмжээ байхгүй, мөн өмнө хэрэгжүүлсэн арга хэмжээ, төлөвлөгөөний биелэлтийг үнэлж, дүгнэдэггүй, үр дүнг танилцуулдаггүй, санхүүжилтийг шийдвэрлэдэггүй байдал нь төрийн бодлого, зорилт хэрэгжихгүй байхад нөлөөлж байна. Мөн Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байхад уг хуульд заасан журмуудыг батлах үйл ажиллагаа удаашралтай байсан нь нөлөөлжээ. Тухайлбал, ХХААХҮСайд “Органик хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам”-ыг 2018 оны 10 сард, “Хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэх”-тэй холбоотой журам, аргачлалыг 2018 оны 2 сард, мөн Үндэсний итгэмжлэлийн төвийн дарга “Гадаад орны итгэмжлэлийн байгууллагаас итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагыг бүртгэх журам”-ыг 2020 он 10 сард тус тус баталсан. Органик хүнсний тухай хууль тогтоомжууд батлагдсан нь сайшаалтай ч эдгээрт органик үйлдвэрлэл, органик бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн зарим асуудлыг тусгаагүй, санхүүжилтийг шийдвэрлээгүй асуудал байна. Тухайлбал, гадаад орнуудын туршлагаас харахад органик хүнсний үйлдвэрлэл, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, сурталчлах, мэдлэг, мэдээлэл түгээх зэрэг үйл ажиллагааг урт, дунд хугацаанд төлөвлөн, санхүүжилтийг төр, орон нутгийн төсөв болон бусад тодорхой эх үүсвэрээс тусгаарлан гаргах, санхүүжилтийн хэдэн хувийг ямар үйл ажиллагаанд зарцуулах талаар дэлгэрэнгүй, ойлгомжтой байдлаар тусгадаг сайн жишгийг нэвтрүүлэх шаардлагатай.

Хуулийн зорилт хэрэгжихгүй байхад эрх зүйн орчны зөрчил, хийдэл нөлөөлж байна.

Органик хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлд уг хуулийн зорилтыг тусгасан бөгөөд уг зорилтын хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд ХАА органик үйлдвэрлэл эрхлэх эрх зүйн орчны дотоод зөрчил, хийдэл болон бусад эрх зүйн актууд хооронд зөрчилтэй байдал болон нөлөөлсөн. Тодруулбал,

Хуулийн зөрчил: Органик хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг “Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журмын 2.5 дахь хэсэг нь

үйлдвэрлэгч 2 өөр төрлийн гэрээ байгуулахаар, эсхүл шилжилтийн үеийг эхлүүлэх болон органик хүнснийг баталгаажуулах тухай гэрээ нь ХББ-ын хамтран ажиллах гэрээтэй нэгэн адил мэтээр ойлгогдохоор тусгасан, мөн Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан органик тэмдэг, тэмдэглэгээний хэрэглээтэй холбоотой зохицуулалт “Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам”-ын 2.1-д заасан органик тэмдэг, тэмдэглэгээний хэрэглээний зохицуулалт, мөн Органик хүнсний бүртгэл мэдээллийн сан organic.gov.mn-д байршуулсан органик болохыг илэрхийлсэн 6 тэмдэг, тэмдэглэгээний загвар нь өөр хоорондоо зөрчил үүсгэсэн байна. Үүнээс гадна бусад хууль тогтоомжтой зөрчил үүсгэсэн асуудал нь ХББ-ын органик баталгаажуулалт хийх үйл ажиллагааг журмаар зохицуулсан нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4.1.6-д заасан "тохирлын үнэлгээ" гэж бүтээгдэхүүн, ажилтны ур чадвар, менежментийн тогтолцоо нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох үйл ажиллагаа гэсэнтэй зөрчилдөж байна. Дээрхээс гадна Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын даргын 2018 А/181 тушаалаар баталсан “Органик бүтээгдэхүүн/Certified organic эко шошго хэрэглэх эрх олгох журам”-ын дагуу органик бүтээгдэхүүнийг баталгаажуулж гэрчилгээ олгож байгаа нь Органик хүнсний тухай хуультай зөрчилдөж байна.

Хуулийн хийдэл: Хуульд органик бордоо, тэжээлийн тухайд импортлох болон баталгаажуулагдсан байх шаардлагаас цааш тодорхой зохицуулалт оруулаагүй бол хуулийн зорилт хэсэгт тусгагдаагүй органик хүнсний экспортод хамаарах зохицуулалтыг хуулийн 9 дүгээр зүйлд тусгасан, мөн энэ заалтын хүрээнд зөвхөн органик хүнсний экспорт, импорт хамаарахаар байгаа нь хуулийн хамрах хүрээнд орсон органик бордоо, тэжээл, түүхий эдийг орхигдуулсан байна. Мөн органик хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой үйл ажиллагааг хангахад чухал нөлөөтэй хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт, сургалт, сурталчилгаанаас гадна шинэ технологи, техник, арга зүй нэвтрүүлэх, хөнгөлөлт, урамшуулал олгох, хөрс, ус, хүнд метал зэрэг суурь шинжилгээний асуудлыг тусгаагүй нь органик хүнсний сүлжээний эрх зүйн зохицуулалт хийдэлтэй байгааг илэрхийлж байна.

Мөн органик мал аж ахуй, газар тариалангаас гаралтай бусад түүхий эд болох ноос, ноолуур, арьс шир, ноосон утас, дайвар бүтээгдэхүүн, малын тэжээл, бордоо болон байгалийн гаралтай хүнс, гоо сайхан болон уламжлалт эм, бэлдмэлд хэрэглэгдэх малын /өөх, тос г.м/ болон ургамлын /цай, давс, амтлагч, эмийн ургамал г.м/ гаралтай бүтээгдэхүүн, орц зэрэг Органик хүнсний тухай хуулийн хамрах хүрээнд багтаж буй түүхий эд, бүтээгдэхүүний салшгүй хэсгүүдийг органикаар баталгаажуулах талаар тодорхой зохицуулалт байхгүй нь органик үйлдвэрлэл хөгжихгүй, үүнд нэгдэн орох ХАА-н салбарын үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо цөөн байхад нөлөөлсөн.

Гадаад орнуудын туршлагаас /Солонгос, Хятад/ харахад ХАА-н органик үйлдвэрлэлээс буюу МАА, газар тариалангаас гаралтай органик бүтээгдэхүүнийг хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн гэж ангилан нэг хуулиар зохицуулах замаар органикаар баталгаажих бүтээгдэхүүн, түүхий эдийн төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж нэмүү өртөг

шингэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх боломж бүрдүүлдэг байна. Иймээс Органик хүнсний тухай хуулийн хамрах хүрээг ХАА-н гаралтай бүтээгдэхүүний боломжит хувилбаруудыг хамруулах байдлаар тэлэх нь зүйтэй байна.

Түүнчлэн хуулийн нэр томъёоны хэсгийг өргөжүүлж органик аж ахуй, үйлдвэрлэл, бүтээгдэхүүнтэй холбоотой нэр томъёо, үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлж, нэмж тусгах нь хуулийг нэг мөр ойлгож хэрэглэхэд дэм болохоор байна. Тухайлбал, ЕХ-ны тухайд Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, шошгололтын тухай шинэ (2018/848) хуульд орсон 75 буюу бараг бүх нэр томъёог тайлбарласан байх бол Солонгос улсын тухайд байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуй ба загас агнуур, байгаль орчинд ээлтэй агро-загасны бүтээгдэхүүн (пестицидгүй ХАА-н гаралтай бүтээгдэхүүн, антибиотикгүй малын бүтээгдэхүүн, антибиотикгүй загасны бүтээгдэхүүн, химийн бодисгүй загасны бүтээгдэхүүн г.м), органик, органик хүнс, хүнсний бус органик бүтээгдэхүүн, органик агро-загасны материал, зөвшөөрөгдсөн бодис, үйл ажиллагаа эрхлэх, бизнесийн байгууллага зэрэг нэр томъёог, Хятад улс органик хөдөө аж ахуй, органик бүтээгдэхүүн, шилжилтийн үе, зэрэгцээ үйлдвэрлэл, хамгаалалтын зурвас, орц, мал, амьтны амьдралын цикл, хомотатетик эмчилгээ, үржүүлгийн материал, биологийн олон янз байдал, генетик инжинеринг, генетикийн өөрчлөлт, генетик инженерчлэгдсэн организм, генетикийн өөрчлөлттэй организм, радиаци, ионоор радиацлах, найрлага, хүнсний нэмэлт, тэжээлийн нэмэлт, туслах бодис, органик үйлдвэрлэгч, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч, тээвэр, ложистикийн үйл ажиллагаа эрхлэгч зэрэг нэр томъёог хуульчилж, хуулийн хэрэглээг хөнгөвчилж байна.

Сургалт, сурталчилгааны ажил төлөвлөлтгүй, хангалтгүй байна.

Органик үйлдвэрлэл хөгжих, тогтвортой үйл ажиллагаатай байх үндсэн баталгаа нь нэг талаас органик хүнс, бүтээгдэхүүний хэрэглээний ач холбогдол, үр дүнг олон нийтэд таниулах ажлаар дамжуулан хэрэглэгчдийг хуурамч бүтээгдэхүүний хэрэглээнээс урьдчилан сэргийлэх, нөгөө талаас органик үйлдвэрлэлд тавигдах шаардлага, эрх зүйн орчны талаар ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд мэдлэг, мэдээлэл түгээх, органик бүтээгдэхүүний баталгаажуулалт, шошгыг сурталчлах, эдгээр үйл ажиллагааны санхүүжилтийг шийдвэрлэх зэрэг цогц арга хэмжээ юм. Үүний нэг жишээ бол ЕХ-ны хэмжээнд органик ХАА-н үйл ажиллагааны шинэ төлөвлөгөөгөө гаргасан бөгөөд энэ төлөвлөгөө нь 1. ЕХ-нд органик хүнсний хэрэглээг нэмэгдүүлэх, 2. органик хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, 3. органик үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг бэхжүүлэх гэсэн 3 зорилгын хүрээнд хэрэгжих бөгөөд 2021 оноос эхлэн Европын ХАА-н органик хүнсний бүтээгдэхүүнийг сурталчлахад зориулагдах төсвийн тал орчим хувийг органик бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд болон гуравдагч орнуудад сурталчлах, түгээн дэлгэрүүлэх кампанит ажлуудад зориулах, тухайлбал үзэл худалдаа, яармагт оролцуулах, ЕХ-ны органик үйлдвэрлэгчдийн экспортын боломжуудын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, бусад улс орнуудтай байгуулсан чөлөөт худалдааны гэрээ, түүнтэй адилтгах гэрээг байгуулах зэргээр ашиглахаар төлөвлөсөн байна.

Органик хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан “сурталчлах” зорилтын хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг реклам, зар

сурталчилгаа, сургалт, судалгаа болон мэдээллийн ил тод байдал гэсэн 4 чиглэлээр үнэлэхэд дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

1/ ХАА-н органик хүнс үйлдвэрлэл, органик бүтээгдэхүүний талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй реклам, зар сурталчилгаа, мэдлэг, мэдээлэл олгох контент хангалтгүй байна. Үүнд эдийн засаг, санхүүгийн хувьд бэхжээгүй органик үйлдвэрлэл эрхлэгчид өртөг өндөртэй контент бэлтгэх, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх ажлыг өөрсдийн зардлаар хийдэггүй, харин үнэ төлбөргүй сошиал медиаг өргөнөөр ашигладаг байдал нөлөөлж байна. Иймээс Монгол орны онцлогийг агуулсан органик бүтээгдэхүүний хэрэглэгч, худалдан авагчдыг бэлтгэх, органик аж ахуй, үйлдвэрлэл эрхлэгчдээ дэмжихийн тулд төрөөс олон улсад хэрэгжүүлж буй органик бүтээгдэхүүнийг сурталчлах “Органик хүнсний өдөр”-тэй болох, дотоодын болон олон улсын хэмжээний үзэсгэлэн худалдаа, яармагт оролцоход дэмжлэг үзүүлэх, зар сурталчилгаа, мэдлэг түгээх үйл ажиллагааг төрийн болон орон нутгийн байгууллагуудын оролцоотой хэрэгжүүлэх боломж бүрдүүлэх зэрэг арга хэмжээ авах хэрэгцээ, шаардлага байна. Иймээс ХАА-н салбарын асуудал хариуцсан төрийн болон мэргэжлийн байгууллагуудын шат шатны онцлогт нийцүүлэн боловсруулсан тодорхой төлөвлөгөөний дагуу дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

2/ Органик аж ахуй эрхлэх, органик хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэхтэй холбоотой хийгдэж буй судалгаа, эрдэм шинжилгээний ажил хангалтгүй, үр дүн тодорхойгүй, салбарын судалгааны байгууллагуудын үйл ажиллагаа харилцан уялдаагүй байгаа нь Монгол орны байгаль, цаг уурын нөхцөл байдалд нийцсэн шинэ бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн технологи хөгжихгүй байхад нөлөөлж байна. Ялангуяа эдгээр байгууллагуудын гүйцэтгэсэн, жишээ нь хөрс, усны зэрэг суурь судалгааны үр дүн олон нийтэд ил тод бус, ХАА-н эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгүүд органик бүтээгдэхүүн боловсруулахтай шууд холбогдох төсөл, судалгааны ажлууд бараг хэрэгжүүлдэггүй, төлөвлөдөггүй нь нөлөөлж байна. Иймээс эрдэм шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагааг, ялангуяа органик үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэхэд төрөөс бодлогоор дэмжих шаардлагатай бөгөөд эн тэргүүнд эрдэмтэн судлаачдын өмнө гүйцэтгэсэн ажлуудын үр дүнг нэгтгэн дүгнэх, эрдэм шинжилгээний ажилтнуудыг мэргэшүүлэх, судалгааны ажлын үр дүнг бодитойгоор үнэлэх, урамшуулах, мөн үр дүнг “нэвтрүүлэх төв”-өөр дамжуулан органик аж ахуй эрхэлдэг малчид, тариаланчдад мэдлэг, дадлага олгодог байх асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна.

3/ Органик үйлдвэрлэл, бүтээгдэхүүний талаар нийгмийн мэдлэг, мэдээлэл хангалтгүй байхад энэ чиглэлийн сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах асуудал хариуцах байгууллага тодорхойгүй, мөн ХХАА-н асуудал хариуцсан төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хүртээмжгүй байдал нөлөөлж байна. Тухайлбал, манай улсад 2020 оны байдлаар газар тариалан эрхлэгч 20 орчим мянган иргэн, аж ахуйн нэгжид органик хүнс үйлдвэрлэлийн талаар мэдээлэл түгээх, эдгээрээс органик үйлдвэрлэлд шилжих хүсэлтэй, боломжтой тариаланчдыг судалгаа мэдээлэл, арга зүйгээр хангах бүтэц байхгүй, улсын хэмжээнд 2 мэргэжилтэн эл асуудлыг хариуцдаг, мөн салбарын үйл

ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа туршилт, инкубаци, шинжлэх ухааны ололт, дэвшилтэт техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, дамжуулах, сурталчлах, мэдээ мэдээллээр хангах чиг үүрэг бүхий Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төв энэ чиглэлд ямар үйл ажиллагаа хэрэгжүүлсэн нь тодорхойгүй, хяналт шалгалт хийх эрх бүхий төрийн бусад байгууллага МХЕГ, ШӨХТГ зэрэг байгууллагууд албан хаагчид болон хэрэглэгчдэд чиглэсэн сургалт, мэдээлэл, нөлөөллийн арга хэмжээ бараг хийдэггүй, органик бүтээгдэхүүний бүртгэл мэдээллийн сан” organic.gov.mn-д цахим хуудасны мэдээлэл, зөвлөгөө өгөх хэсгүүд 2018 оноос хойш шинэчлэгдээгүй байна. Иймээс ХАА-н органик үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд малчид, тариаланчдыг шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах, арга зүй, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох, эрдэм шинжилгээ судалгааны үр дүн, шинэ технологи нэвтрүүлэх боломж бүрдүүлсэн органик ХАА-н цогц бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох шаардлагатай.

4/ Органик хүнс үйлдвэрлэлтэй холбоотой статистик мэдээ болон органик хүнс үйлдвэрлэгч болон хэрэглэгчдэд шаардлагатай мэдээлэл байхгүй, мэдээллийн ангилал тодорхойгүй, байгаа мэдээллийг ил тод, ойлгомжтой байдлаар нийтлэхгүй байна. Тухайлбал, улсын хэмжээнд хэр хэмжээний МАА, газар тариалангийн гаралтай органик бүтээгдэхүүн, түүхий эд үйлдвэрлэгдсэн, тэдгээрийн хадгалалт, тээвэрлэлт, борлуулалттай холбоотой мэдээллийг салбарын яам хүртэл тооцож гаргадаггүй, хяналт шалгалт, бүртгэл хийх, мэдээлэл шаардах эрх бүхий төрийн байгууллагууд органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, бордоо, тэжээл, үр, суулгац үйлдвэрлэл, борлуулалтын талаарх статистик мэдээг тусад нь гаргадаггүй, бүртгэдэггүй, тухайн бүтээгдэхүүний нэр, төрөлд нэгтгэн тооцож байгаа нь органик хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой тодорхой судалгаа мэдээлэлгүй байхад нөлөөлж байна. Иймээс органик хүнс үйлдвэрлэлд холбогдох мэдээллийг оновчтой ангилах, мэдээлэл ангилах, цуглуулах, боловсруулах арга, аргачлалыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Органик хүнсний баталгаажуулалт, бүтэц, зохион байгуулалт

ХАА-н органик үйлдвэрлэлийн үндсэн зорилго нь органик бордоо, тэжээл ашиглах, уламжлалт болон дэвшилтэт технологи ашиглан аливаа химийн бодис, пестицид ашиглалгүйгээр эрүүл хөрснөөс эрүүл хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж хэрэглэгчдэд хүргэхэд чиглэдэг. Байгаль орчинд ээлтэй, цаг уурын өөрчлөлтөд тэсвэртэй, эрүүл, баталгаатай хүнс үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэг нь ХАА-н органик үйлдвэрлэл гэдэгтэй дэлхий нийтээрээ санал нэг байна.

Манай улс 2030 он гэхэд органик хүнсний үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж хүнс, ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 5 хувьд хүргэж органик баталгаажуулалтад хамруулах зорилт дэвшүүлсэн нь энэ үзэл санаатай нийцэж байгаа бөгөөд үүнд хэрэглэгчдийн итгэл үнэмшил дээр оршин тогтнох органик бүтээгдэхүүний баталгаажуулалтын асуудал маш чухал үүрэгтэй. Иймээс органик хүнсийг үнэн зөв баталгаажуулах, баталгаажуулалтын байгууллагуудын ур чадвар, мэдлэг чадавхыг дээшлүүлэх, аливаа ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, тэдний үйл ажиллагаанд

тавих төрийн хяналтыг үр дүнтэй байлгах, баталгаажуулалтын байгууллагад тавьж буй шаардлага, хүлээлгэж буй эрх, үүрэг нь цаг үе, үйл ажиллагаатай нь бодитой уялдсан байх зэрэг асуудал илүү анхаарал татдаг.

Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлын хүрээнд баталгаажуулалтын байгууллагууд, тэдгээрийн үйл ажиллагаа, хяналт зэрэг асуудлыг судалж үзэхэд хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь дараах асуудлуудтай холбоотой байна. Үүнд:

1/ Төрөөс 2030 он хүртэл органик баталгаажуулалтад хамрагдсан ХАА-н бүтээгдэхүүний хэмжээг 5 хувьд хүргэх зорилтын хүрээнд 46,4 мянган литр сүү, 26,3 мянган тонн мах, махан бүтээгдэхүүнийг органик хүнсний баталгаажуулалтад хамруулах наад захын шаардлага үүсэх бөгөөд өнөөдөр 2 мянга орчим литр, 10 гаруй төрлийн органик сүү, сүүн бүтээгдэхүүн, зах зээлд нийлүүлсэн тоо хэмжээ нь тодорхойгүй 5 төрлийн мах, махан бүтээгдэхүүнийг органик шаардлагад нийцүүлэн боловсруулж байна. ХХААХҮСайдын 2018 оны А-09 дүгээр тушаалаар баталсан “ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах журам”-аар органик газар тариалан, МАА-н үйлдвэрлэл, органик зөгийн аж ахуй эрхлэх, органик хүнсийг боловсруулах үйлдвэр эрхлэхэд тавигдах шаардлагуудыг тогтоосноор тухайн харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж болох хэдий ч МАА, газар тариалангийн бүтээгдэхүүний салшгүй хэсэг болох ноос, ноолуур, арьс, шир, дайвар бүтээгдэхүүн, өөх, тос, байгалийн гаралтай ургамал зэрэг хүнс болон хүнсний бус бүтээгдэхүүнд ашиглагдах бүтээгдэхүүн, түүхий эдийг органикаар баталгаажуулах, органик бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, органик мал арчилгаа, маллагаа, тээвэрлэлт, нядалгаа зэрэг олон харилцааны эрх зүйн орчин бүрдээгүй нь малчид, тариаланчдын хувьд органикаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ үр шимийг бүрэн хүртэхэд сөргөөр нөлөөлөхөөс гадна улсын хэмжээнд органикаар баталгаажсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээ бага байхад нөлөөлж байна. Ялангуяа МАА-н гаралтай органик бүтээгдэхүүний төрөл, хэмжээ бага байхад малчид, МАА-н гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн дунд органик үйлдвэрлэлийн талаар мэдлэг муу, органик баталгаажуулалт хийлгэсэн ч эдийн засгийн ач холбогдол бага, органик үйлдвэрлэлтэй холбоотой бүртгэл, мэдээллийн ажлыг гүйцэтгэх хүний нөөц, ур чадварын асуудал, уламжлалт аргаар малласан бэлчээрийн малын гаралтай бүтээгдэхүүн угаасаа байгалийн цэвэр, органик бүтээгдэхүүн байдаг гэх хэвшмэл ойлголт зэргээс шалтгаалан органик МАА-н үйлдвэрлэл эрхлэх сонирхолгүй байгаа нь нөлөөлж байна.

2/ ХАА-н органик хүнс үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхэд газар зохион байгуулалтын асуудалд онцгой ач холбогдол өгөх шаардлагатай байна. Ялангуяа МАА, газар тариалангийн талбайн дийлэнх хэсэг нь хүн амын нягтаршил өндөртэй, уул уурхай, аж үйлдвэр эрчимтэй хөгжиж буй бүс нутгуудад оршихоос гадна дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, үер усны аюул, ган гачиг, цөлжилт, органик бус, газар тариалангийн салбарын тэлэлт, шинэ төрлийн хортон шавж, өвчин эмгэг гээд олон хүчин зүйлээс шалтгаалан бэлчээр, усны хомсдол үүсэж байгаа нь органик МАА, газар тариаланг тогтвортой эрхлэхэд хүндрэл үүсгэх эрсдэлтэй байна. Иймээс ХАА-н органик хүнсний

бүтээгдэхүүн, түүхий эдээр олон улсын зах зээлд өрсөлдөх, экспортыг нэмэгдүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд бүс нутаг, аймаг, сумын хэмжээнд уул уурхай, органик бус газар тариалан, МАА-гаас ангид, хортон шавж, ургамалтай зөвхөн органик аргаар тэмцдэг хууль тогтоомжийн шаардлага хангахуйц хязгаарлалт тогтоосон органик МАА, газар тариалангийн бүс бий болгох, мөн органик хүнсний ногооны баталгаажуулалтыг баталгаажсан тариалангийн талбайтай нь уялдуулах боломжийг судлах шаардлагатай. Тухайлбал, манай улсын хувьд хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэлийн түвшинд органикаар баталгаажсан хүнсийг хамгийн ихээр үйлдвэрлэж байна. Статистик үзүүлэлтээс харахад 2030 он хүртэл газар газар тариалангийн бүтээгдэхүүний 5 хувийг органик баталгаажуулалтад хамруулах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд 5,253.5 тонн хүнсний ногоо тариалах 452,8 га газар, 9,098.3 тонн төмс тариалах 770 га газар, 21,700 тонн үр тариа тариалах 19,129 га газар, 7,686 тонн таримал тэжээл тариалах 2,307 га газрыг органик бус газар тариалан, мал аж ахуй, уул уурхай, хот суурин газраас тусгаарлах бэлтгэл хангах шаардлага үүсэхээр байна.

З/ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлээс үр тариа, таримал тэжээлийг органик үйлдвэрлэлд шилжүүлэхэд онцгой анхаарах шаардлагатайг энэ төрлийн бүтээгдэхүүн органик баталгаажуулалтад хамрагдаагүй байгаа нь харуулж байна. Ялангуяа үр тариаг органик үйлдвэрлэлд шилжүүлснээр нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, нэмүү өртөг шингэсэн органик гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжих суурь болох бол таримал тэжээлийг органик болгох нь МАА-н гаралтай органик бүтээгдэхүүний өсөлтөд нөлөөлөх ач холбогдолтой.

4/ Органик хүнсийг баталгаажуулах баталгаажуулалтын байгууллагыг бүртгэх эрх зүйн орчин зөрчилтэй, зарим үйл ажиллагаа хэрэгжихгүй байгаа нь хуулийн зохицуулалтын хэрэгжилт зорилгодоо хүрэхгүй байхад нөлөөлж байна. Органик хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар органик хүнсний баталгаажуулалтыг 1/ дотоодын буюу Монгол Улсын эрх бүхий байгууллагаар итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага, 2/ гадаадын буюу Монгол Улсад бүртгэлтэй, гадаад улсын итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага болон 3/ харилцан итгэлцэлд тулгуурласан хамтын баталгаажуулалтын байгууллагууд хуулийн 10.2, 10.7.4-т заасан шаардлагад нийцүүлэн Үндэсний итгэмжлэлийн төв болон ХХААХҮЯ-нд бүртгүүлэн үйл ажиллагаа хэрэгжүүлж байна. Гэвч хуулийн 10.7.4-т заасны дагуу Үндэсний итгэмжлэлийн төвийн мэдээллийн санд бүртгэлтэй хамтын баталгаажуулалтын байгууллага байхгүй, ХББ-аас органик хүнсийг баталгаажуулах үйл явцыг журмаар зохицуулсан нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд тохирлын үнэлгээ нь ... стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтооход чиглэнэ гэх зохицуулалттай зөрчилдсөн, “Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журам”-ын 3.4-т заасан Захиргааны гэрээ байгуулж, хяналт тавина гэх зохицуулалт огт хэрэгжээгүй, ХББ-ыг нөхөрлөл хэлбэрээр байгуулахаар журамласан боловч практикт хоршоо, төрийн бус байгууллага хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг зэрэг зөрчил, дутагдал байна.

Түүнчлэн ХХААХҮЯ-ны органик хүнсний бүртгэл, мэдээллийн санд мэдээлэл оруулах, хүсэлт шийдвэрлэх ажиллагааг нэг мэргэжилтэн хариуцаж байгаа нь хүнсний бүтээгдэхүүний баталгаажуулалтын үр дүнг нягтлах, ББ-аар бүртгүүлэх хүсэлтийг шийдвэрлэх ажил удаашрах, алдаа гарах магадлалыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Цаашлаад органик хүнсний бүртгэл, мэдээлэл хөтлөх, ББ-уудыг итгэмжлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтуудад ББ-ыг анхлан болон давтан итгэмжлэх хугацаа, ББ-ын итгэмжлэлийн хугацааг сунгаагүй тохиолдолд тэдний зүгээс хэрэгжүүлэх хяналт шалгалтыг хэн, хэрхэн хэрэгжүүлэх, хариуцлагагүй ажилласан, ББ-ын итгэмжлэлийг ямар тохиолдолд /ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн зэрэг/ түдгэлзүүлэх, цуцлах зэрэг асуудал тодорхойгүй байгаа бол цаашид төрөөс баримталж буй бодлогын хүрээнд ХАА-н органик хүнсний үйлдвэрлэл тэлж, олон гишүүнтэй эсхүл цөөн гишүүнтэй хэд хэдэн нөхөрлөл нэгдэн ХББ байгуулах зэрэг тохиолдолд эрх зүйн орчин хангалтгүй зэрэг асуудал байна.

5/ Хэдийгээр манай улс 2030 он гэхэд ХАА-н бүтээгдэхүүний 5 хувийг баталгаажуулалтад хамруулах зорилго тавьсан боловч уг бодлогыг хэрэгжүүлэх, энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэх идэвх, санаачилгыг хөхиүлэн дэмжих арга хэмжээ хэрэгжүүлэхгүй байна. Тухайлбал, органик аж ахуй эрхлэгч, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд урамшуулал, хөнгөлөлт, татаас, дэмжлэг үзүүлэх талаар бодлого, хөтөлбөр хэрэгжүүлээгүй, органик аж ахуйн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний талаар мэдээлэл цуглуулах, мэдээллийн санд бүртгүүлэх, мэдээлэл солилцох зэрэг үйл ажиллагаанд хамаарах эрх зүйн орчин бүрдээгүй, ядаж гарын авлага байхгүй. ББ-уудыг олноор байгуулах талаар шийдвэр гаргадаг ч тэдний үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтууд хангалтгүй байна. Гадаад орнуудын туршлагаас харахад органик бүтээгдэхүүн, органик үйлдвэрлэл эрхлэгчдийн тоог өсгөх зорилгоор төрийн худалдан авалт хийх /цайны газар, бордоо, үр суулгац/, ББ-ын үйл ажиллагааг сайжруулах, сайн үйлчилгээ үзүүлдэг ББ-ыг дэмжих, сурталчлах зорилгоор тэдгээрийн үйл ажиллагаа, үйлчилгээний гүйцэтгэлийн байдлыг үнэлэн зэрэглэл тогтоож, үр дүнг нийтэд мэдээлэх зэрэг арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж байна. Харин манай улсын хувьд органик үйлдвэрлэгчдийг дэмжих замаар хэрэглэгчдээ бэлдэх ажил хангалтгүй, зохион байгуулалтгүй байна. Тухайлбал, манай улсад органик бордоо үйлдвэрлэж, гадаадад экспортолж буй ААН-үүд бүгд хуурай бордоо үйлдвэрлэдэг бол төрөөс худалдан авалт хийхээс зарласан тендерт зөвхөн шингэн бордоо худалдаж авахаар заадаг жишээ байна. Иймээс бусад улсын туршлагаас судлан дотоодын органик үйлдвэрлэгчдээ дэмжих бодлого баримталж эхний ээлжид хэрэглэгчдээ бэлтгэх, удаад нь органик хүнс үйлдвэрлэлийн тогтолцоог бүрэн хэмжээгээр /үйлдвэрлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх г.м/ жигдрүүлэх зорилгоор төрийн худалдан авах ажиллагааны хүрээнд сургуулиудын “Үдийн цай” хөтөлбөр, эрүүл мэндийн байгууллага, цэргийн анги зэрэг байгууллагуудын хоолны нэг нэг орцыг органик бүтээгдэхүүн болгох зэрэг арга хэмжээ авах боломжтой

Органик үйлдвэрлэл, бүтээгдэхүүнд тавих хяналт

Хүн амын өсөлт, байгаль цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалан дэлхий дахинаа хүнсний хомсдол үүсэх эрсдэл тулгараад буй өнөө үед баталгаатай, эрүүл, аюулгүй хүнсээр ард иргэдээ хангах нь хүнсний нөөцийн хязгаарлагдмал нөхцөлд улам хүндрэлтэй болж

байгаа нь хүнсний аюулгүй байдалд ч нөлөөлж байна. Үүний нэг жишээ бол “өмхий махны хэрэг” буюу УИХ-аас 2022 онд “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол батлагдах болсон нөхцөл байдал юм. Хүнсний хяналт, тоон дотроо органик хүнсний хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь нэг талдаа хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, нөгөө талдаа органик хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах давхар ач холбогдолтой тул Органик хүнсний тухай хуулийн 11, 12 дугаар зүйлийг сонгож, хэрэгжилтийг үнэлж дараах үр дүнд хүрсэн.

1/ Органик хүнсний сүлжээний хяналт дотоод хяналт, хөндлөнгийн хяналт, төрийн хяналт шалгалт хэлбэрээр хэрэгжиж байна. Манай улсын хувьд органик хүнс, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл гарааны шатандаа хөгжиж байгаа бөгөөд цөөн тооны үйлдвэрлэл эрхлэгч ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа нь ББ-аас тавьж буй хөндлөнгийн болон гишүүд бие биедээ тавих дотоод хяналт хангалттай сайн хэрэгжихэд нөлөөлж байна. Харин төрийн хяналт шалгалтын тогтолцоо, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо өсөн нэмэгдэх хандлагатай уялдаагүй байна. Тухайлбал, төрийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий МХЕГ, ШӨХТГ, ГЕГ, МЭЕГ, Хилийн хорио цээрийн алба зэрэг төрийн байгууллагын улсын байцаагчдын орон тоо хангалтгүй, ашиглаж буй тоног төхөөрөмж органик хүнсний сүлжээг хянах түвшний шаардлага хангахгүй, албан хаагчдын органик үйлдвэрлэл, бүтээгдэхүүний талаарх мэдлэг, мэдээлэл хангалтгүй, органик аж ахуй эрхлэх, органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тэдгээрийн сав баглаа, боодол, тээвэрлэлт, хадгалалтын явцыг шалгах ажил /хяналтын хуудас/ “органик”-ийн шаардлага хангаж буй эсэхэд чиглэдэггүй, органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалттай холбоотой хяналт шалгалтыг зөвхөн тодорхой нэг арга хэмжээ, аяны хүрээнд хэрэгжүүлдэг зэрэг асуудлыг дурдаж болно. Түүнчлэн Манай улсад үйл ажиллагаа явуулж буй хүнсний бүтээгдэхүүний лабораториуд олон улсын шаардлага хангах хэмжээнд органик түүхий эд, бүтээгдэхүүнийг шинжлэх чадамжгүй байгаа нь дотоодод баталгаажуулсан органик бүтээгдэхүүнийг экспортлоход хүндрэл үүсгэж улмаар төрөөс ХАА-н органик бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилгод сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Эдгээр асуудлууд нь ХАА-н органик хүнсний хадгалалт, тээвэрлэлт, экспорт, импорт, худалдаа, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт тавих эрх зүйн орчин хангалтгүй байгаатай холбоотой тул органик хүнстэй холбоотой дээрх асуудлуудад хяналт тавих төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзлээ.

2/ Органик бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх, органик бүтээгдэхүүний баталгаат, аюулгүй байдлыг гэрчлэх зүйл бол органик тэмдэг, тэмдэглэгээ буюу шошго юм. Манай улс органик хүнс, тэжээл, бордооны сав, баглаа, боодлын шошгод органик тэмдэг, тэмдэглээ хэрэглэх, шошготой холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалттай, холбогдох тэмдэг, тэмдэглэгээг Оюуны өмчийн газраар баталгаажуулсан байна. Гэвч хууль болон түүнийг дагалдан гарсан журмын зөрчлөөс үүдэн нэр томьёог нэг мөр ойлгож, хэрэглэх боломжгүй байна. Тодруулбал, Органик хүнсний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 10.1-д зааснаар

баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдэг, 10.2-т зааснаар баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдэглэгээг тус тус шошгод тавина” гэж заасан бол Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журмын 2.1-д “Хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллага болон Хамтын оролцооны байгууллагын баталгаажуулсан хүнсний бүтээгдэхүүнд хэрэглэх органик болохыг илэрхийлсэн тэмдэг нь Органик хүнсний тухай хуулийн 11.6-д заасны дагуу баталсан загвар, хэмжээ, төрөлтэй байна.” гэж заасан, мөн Органик хүнсний бүртгэл мэдээллийн сан organic.gov.mn-д байршуулсан органик тэмдэг, тэмдэглэгээний загвар баталгаажсан органик бүтээгдэхүүн “Органик” тэмдгийг, шилжилтийн үеийн бүтээгдэхүүн “Органик” тэмдэглэгээг ашиглахаар харуулсан нь зөрчил үүсгэж байна. Түүнчлэн Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын даргын 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/181 тушаалаар баталсан “Органик бүтээгдэхүүн/Certified organic эко шошго хэрэглэх эрх олгох журам” Органик хүнсний тухай хууль, холбогдох журмыг зөрчиж “Органик бүтээгдэхүүн” шошго хэрэглэх эрх олгож байгаад анхаарах шаардлагатай.

Үнэлгээний дүнгээс харахад Органик шошго нэр хүндгүй, эдийн засгийн үр өгөөжгүй байхад хэрэглэгчдийн органик хүнсний талаарх мэдлэг, мэдээлэл муу, органик хүнсний ач холбогдол, бүтээгдэхүүний зар сурталчилгаа хангалтгүй, хүнсний дэлгүүрүүд төдийгүй төрийн байгууллагууд ч “органик” шошгод ач холбогдол өгдөггүй байдлаас гадна хуульд заасан "органик", "байгалийн цэвэр", "байгалийн гаралтай цэвэр" гэсэн мэдэгдлийг ашиглаагүй ч “Био”, “Эко” зэрэг ижил утгатай мэдэгдэл агуулсан бүтээгдэхүүн ихээр борлуулагдаж хэрэглэгчдийг төөрөгдүүлж байгаа нь баталгаажсан органик бүтээгдэхүүний зах зээлд сөргөөр нөлөөлж байна. Иймээс үйлдвэрлэгчид бүтээгдэхүүний өртгийн 25-30%-ийг эзэлдэг органик тэмдэг, тэмдэглэгээний зардлыг хэмнэж, бүтээгдэхүүний үнийг бууруулах зорилгоор органик хүнс, түүхий эд, бордоо, тэжээл, үр, суулгацаар баталгаажсан бүтээгдэхүүний сав, баглаа, боодолд “органик” тэмдэг, органик шилжилтийн үеийн тэмдэглээ байршуулахаас татгалзах хандлагатай байна. Энэ нь органик үйлдвэрлэл эрхлэгчид, органик хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид Органик хүнсний тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан үүргийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэдэг болохыг харуулж байна.

Түүнчлэн Органик хүнсний тухай хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэх, зөрчлийг илрүүлэх ажиллагааны хэрэгжилт хангалтгүй, хүнсний бүтээгдэхүүний шошгод “органик”, “байгалийн гаралтай цэвэр”, “байгалийн гаралтай” гэсэн мэдэгдлийг хийж, хэрэглэгчдийг төөрөгдүүлэн, хуурамч бүтээгдэхүүн үйлдвэрлэх явдал байсаар байгаад хуурамч органик бүтээгдэхүүний талаар хэрэглэгчид төдийгүй баталгаажуулалтын байгууллага, органик хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид гомдол гаргадаггүй, мөн хяналт тавих нэгж тодорхойгүй, нийгэмд органик хүнсний бүтээгдэхүүнийг органик бус хүнсний бүтээгдэхүүнээс хэрхэн ялгаж таних талаар мэдээлэлгүй байгаа зэргээс шалтгаалан хуулийн хариуцлагатай холбогдох зохицуулалт өнгөрсөн 5 жилийн хугацаанд хэрэгжээгүй байна.

Эцэст нь, 2016 онд батлагдаж 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж буй Органик хүнсний тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд “хуулийн зохицуулалт зорилгодоо хүрэхгүй” гэх үр дүнд хүрч байна. Үүнд хуулийн дотоод болон бусад хуультай үүсгэсэн зөрчил, хийдлээс гадна, органик ХАА-г хариуцах бүтэц, орон тоо хангалтгүй, ХАА-н салбарын болон төрийн хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагуудыг үйл ажиллагааны харилцан уялдаагүй байдал, төрийн байгууллагуудын болон органик үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг, мэдээлэлгүй байдал, технологи, тоног төхөөрөмж шаардлага хангахгүй, эрдэм шинжилгээний ажил хийдэггүй, туршлага судлах, дадлагажих боломж бүрдээгүй байдал зэрэг олон хүчин зүйлс нөлөөлжээ.

Түүнчлэн НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн, байгаль орчинд ээлтэй, байгалийн нөөцийг зохистой, хөнөөл багатай ашиглах замаар боловсруулсан хүний эрүүл мэндэд ээлтэй эрүүл, баталгаатай, шим тэжээллэг органик хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх талаар мэдлэг түгээх, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах ажил хангалтгүй хийгддэг, органик аж ахуй эрхлэгч, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж хуурамч органик бүтээгдэхүүнтэй тэмцэх ажиллагаа үр дүнгүй байгаа нь мөн л нөлөөлсөн гэж үзэж болох юм.

ЗУРГАА. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Төрийн зүгээс хүнсний аюулгүй байдал, байгаль орчинд ээлтэй органик аж ахуйн эрхлэлтийг дэмжих бодлого баримталж 2030 он гэхэд ХАА-н нийт бүтээгдэхүүний 5 хувийг органик баталгаажуулалтад хамруулах зорилго тавин ажиллаж байгаатай холбогдуулан Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний үр дүнд үндэслэн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Эрх зүйн зохицуулалтын зөрчил, хийдлийг арилгах асуудлаар:

1. Органик хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг “Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журмын 2.5 дахь хэсгийн зохицуулалтын уялдааг хангаж, зөрчлийг арилгах,
2. Органик хүнсний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг болон “Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам”-ын 2.1-д заасан органик тэмдэг, тэмдэглэгээтэй холбоотой зохицуулалтын уялдааг хангаж, зөрчлийг арилгах,
3. ХХААХҮСайдын 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А-09 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан “Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журам”-ыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4.1.6-д нийцүүлэн стандарт болгох,
4. Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын даргын 2018 А/181 тушаалаар баталсан “Органик бүтээгдэхүүн/Certified organic эко шошго хэрэглэх эрх олгох журам”-ыг хүчингүй болгох,
5. Органик хүнсний тухай хуулийн зорилт хэсэг болох 1 дүгээр зүйлд экспорт, сургалт, эрдэм шинжилгээний үр дүнг хэрэглээнд нэвтрүүлэх, органик үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой харилцааг нэмж тусгах,
6. Органик хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой үйл ажиллагааг хангахад чухал нөлөөтэй хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт болон урамшуулал, дэмжлэг үзүүлэх, шинэ технологи, техник, арга зүй нэвтрүүлэхтэй холбоотой зохицуулалт нэмэх,
7. Хуулийн хамрах хүрээг нэмэгдүүлж органик мал аж ахуй, газар тариалангаас гаралтай бусад түүхий эд болох ноос, ноолуур, арьс шир, ноосон утас, дайвар бүтээгдэхүүн, байгалийн гаралтай хүнс, гоо сайхан болон уламжлалт эм, бэлдмэлд хэрэглэгдэх малын /өөх, тос г.м/ болон ургамлын /цай, давс, амтлагч, эмийн ургамал г.м/ гаралтай бүтээгдэхүүн, орц зэргийг органикаар баталгаажуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх,
8. Хуулийн нэр томъёоны хэсгийг өргөжүүлж органик аж ахуй, үйлдвэрлэл, бүтээгдэхүүнтэй холбоотой нэр томъёо, үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлж, нэмж тусгах замаар хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх,

ХАА-н органик үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар

9. Органик ХАА эрхлэх, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тогтвортой үйл ажиллагаатай байх, импортын бүтээгдэхүүнийг орлох, экспортын брэнд бүтээгдэхүүнтэй болох зорилгоор органик ХАА-н үйл ажиллагаа, санхүүжилт, хүний нөөцийн бодлогыг урт, дунд хугацаанд төлөвлөн цогцоор нь шийдвэрлэх, түүнд шаардлагатай бүтэц, орон тоог бий болгох,
10. Органик хүнс, бүтээгдэхүүний хэрэглээний ач холбогдол, үр дүн, органик үйлдвэрлэлд тавигдах шаардлага, эрх зүйн орчны талаар хэрэглэгч, ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд мэдлэг, мэдээлэл түгээх, хэрэглэгчдийг хуурамч бүтээгдэхүүний хэрэглээнээс урьдчилан сэргийлэх зорилгоор органик бүтээгдэхүүний баталгаажуулалт, шошгыг сурталчлах ажлыг эрчимжүүлэх, тухайлбал, жил бүр “Органик өдөр” арга хэмжээ зохион байгуулах, хяналт шалгалтыг сайжруулах, мөн гадаад зах зээлд бүтээгдэхүүний борлуулах нөхцөлийг сайжруулах үүднээс бусад орнуудтай худалдааны гэрээ хэлэлцээрийг нэмэгдүүлэх, энэ эдгээр гэрээ, хэлэлцээрт тусгагдсан боломжуудын талаар ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд мэдээллээр хангах,
11. Органик аж ахуй, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд ХАА-н салбарын эрдэм шинжилгээний байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, Монгол орны байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон хөдөө аж ахуйн органик хүнсний үйлдвэрлэлийн арга, дэвшилтэт технологи боловсруулах, органик үр, суулгац, тэжээл, бордоо, ургамал хамгааллын бодис зэрэг чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх, үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд болон инкубатор, загвар аж ахуй, агро парк байгуулахад дэмжлэг үзүүлэх,
12. ХАА-н органик хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдээр олон улсын зах зээлд өрсөлдөх, экспортыг нэмэгдүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд бүс нутаг, аймаг, сумын хэмжээнд уул уурхай, органик бус газар тариалан, МАА-гаас ангид, хортон шавж, ургамалтай зөвхөн органик аргаар тэмцдэг хууль тогтоомжийн шаардлага хангахуйц хязгаарлалт тогтоосон органик МАА, газар тариалангийн бүс бий болгох асуудлыг судалж ХАА-н органик хүнс үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор газар зохион байгуулалтын асуудалд онцгой ач холбогдол өгөх, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах. Мөн органик хүнсний ногооны баталгаажуулалтыг баталгаажсан тариалангийн талбайтай нь уялдуулах боломжийг бүрдүүлэх,
13. Үр тариаг органик үйлдвэрлэлд шилжүүлснээр нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, нэмүү өртөг шингэсэн органик гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжих суурь болох тул үр тариа, таримал тэжээлийг органик үйлдвэрлэлд шилжүүлэхэд онцгой анхаарах.
14. Органик хүнсний бүртгэл мэдээллийн санг хэрэглэхэд хялбар болгох, мэдээлэл оруулах, боловсруулах, органик аж ахуйн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний талаар мэдээлэл цуглуулах, мэдээллийн санд бүртгүүлэх, мэдээлэл солилцох зэрэг асуудлыг журамлах эсхүл гарын авлага боловсруулах замаар тодорхой болгох,

15. 2030 он гэхэд ХАА-н бүтээгдэхүүний 5 хувийг баталгаажуулалтад хамруулах бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэх идэвх, санаачилгыг хөхиүлэн дэмжих чиглэлээр органик аж ахуй эрхлэгч, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд урамшуулал, хөнгөлөлт, татаас, дэмжлэг үзүүлэх талаар бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх,

Органик бүтээгдэхүүний баталгаажуулалтын асуудлаар

16. МАА, газар тариалангийн бүтээгдэхүүний салшгүй хэсэг болох ноос, ноолуур, арьс, шир, дайвар бүтээгдэхүүн, өөх, тос, байгалийн гаралтай ургамал зэрэг хүнс болон хүнсний бус бүтээгдэхүүнд ашиглагдах бүтээгдэхүүн, түүхий эдийг органикаар баталгаажуулах, органик бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, органик мал арчилгаа, маллагаа, тээвэрлэлт, нядалгаа зэрэг үйл ажиллагааг органикаар баталгаажуулах боломжийг бүрдүүлэх,
17. Хуулийн 10.7.4-т заасны дагуу Хамтын баталгаажуулалтын байгууллагуудыг Үндэсний итгэмжлэлийн төвийн мэдээллийн санд бүртгүүлэх,
18. “Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журам”-ын 3.4-т заасан Захиргааны гэрээ байгуулж, хяналт тавих зохицуулалтыг хэрэгжүүлэх,
19. Хамтын баталгаажуулалтын байгууллагын хуулийн этгээдийн хэлбэрийг органик аж ахуй эрхлэгчдэд татвар, санхүүгийн тооцоо хийх, банк санхүүгийн байгууллагатай харилцахад саадгүй байхаар үүсгэн байгуулагчдын сонголтоор тодорхойлох боломжийг бүрдүүлэх,
20. Баталгаажуулалтын байгууллагуудыг итгэмжлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтуудад ББ-ыг анхлан болон давтан итгэмжлэх хугацаа, ББ-ын итгэмжлэлийн хугацааг сунгаагүй тохиолдолд тэдний зүгээс хэрэгжүүлэх хяналт шалгалтыг хэн, хэрхэн хэрэгжүүлэх, хариуцлагагүй ажилласан, ББ-ын итгэмжлэлийг ямар тохиолдолд / ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн зэрэг/ түдгэлзүүлэх, цуцлах зэрэг асуудлыг тодорхой болгох,
21. Баталгаажуулалтын байгууллагуудын боловсон хүчний чадавхыг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд албан хаагчид, аудитуруудын органик аж ахуй, үйлдвэрлэл, бүтээгдэхүүний чиглэлээр мэдлэг, мэдээлэл олгох сургалтад тогтмол хамруулах, мэргэшүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах,
22. Хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагыг итгэмжлэх эрх зүйн үндэс болох MNS ISO 17065: 2013 Тохирлын үнэлгээ — Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээг баталгаажуулах байгууллагад тавих шаардлагад нэмэлт, өөрчлөлт оруулах,
23. Органик хүнсний бүртгэл, мэдээллийн санд ББ-уудын итгэмжлэгдсэн хугацааг тодорхой тусгах,
24. ХББ-ын гишүүнчлэлийн дээд, доод хязгаарыг тогтоох, мөн олон гишүүнтэй ХББ байгуулах, эсхүл хэд хэдэн нөхөрлөл/хоршоо нийлэн ХББ үүсгэх боломжтой эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай эсэхийг судлах,

Органик үйлдвэрлэл, бүтээгдэхүүнд тавих хяналтын асуудлаар

25. УИХ-аас 2022 онд баталсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны хүрээнд органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сүлжээний тогтолцоо, хяналт шалгалтыг сайжруулах,
26. Төрийн хяналт шалгалтын тогтолцоо, хэрэгжүүлж буй үйл ажиллагааг органик хүнс үйлдвэрлэлийн үйл ажиллагаа өсөн нэмэгдэх чиг хандлагатай уялдуулан зохион байгуулах боломжийг бүрдүүлэх, тухайлбал, төрийн байгууллагын улсын байцаагчдын орон тоо, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, албан хаагчдын органик үйлдвэрлэл, бүтээгдэхүүний талаарх мэдлэгийг дээшлүүлэх, үйл ажиллагаандаа ашигладаг хэрэглэгдэхүүнийг /хяналтын хуудас г.м/ “органик”-ийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох,
27. Хүнсний бүтээгдэхүүний лабораториудын органик түүхий эд, бүтээгдэхүүнийг шинжилгээний үр дүнг чанар, үзүүлэлтийн хувьд олон улсын шаардлага хангах хэмжээнд хүргэх,
28. Органик тэмдэг, тэмдэглэгээг сурталчлах замаар органик хүнс, түүхий эд, бордоо, тэжээл, үр, суулгацаар баталгаажсан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, мөн органик үйлдвэрлэл эрхлэгчид, органик хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид бүтээгдэхүүндээ зардал багатай шошгын төрлөөс сонгон байршуулах боломжийг судлах,
29. Органик хүнсний тухай хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэх, зөрчлийг илрүүлэх ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байгаад холбогдох байгууллагууд анхаарч ажиллах.

ДОЛОО. ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж:

- "Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн" үндэсний хөтөлбөр. ЗГ-ын 2019 оны 52 дугаар тогтоол.
- “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”
- MNAS P701 Итгэмжлэлийн үйл явцын журам
- MNS 6648:2016 “Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага. Стандартчиллын үндэсний зөвлөлийн 64-р тогтоолоор баталсан
- Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль
- Зайлшгүй сав, баглаа болон боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журам
- Засгийн газрын 2014 оны 157-р тогтоол "Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дотоод хяналт хэрэгжүүлэх үлгэрчилсэн журам"
- Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал
- ЗГ-ын 2020 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн “Төрийн өмчит үйлдвэрийн газрын талаар авах зарим арга хэмжээний тухай” 93 дугаар тогтоол
- Зөрчлийн тухай хууль 2017 он
- Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр.
- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
- МХЕГ-ын даргын 2016 оны “Аргачлал батлах тухай” А/167 дугаар тушаал.
- Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хэлтсээс МУ-ын УИХ-ын гишүүн Ч.Ундрамын 2022.08.05-ны өдрийн УИХ-03/7503 дугаартай албан бичигт ирүүлсэн хариу
- Органик хүнсний тухай хуулийн төслийн үзэл баримтлал. 2016.
- Органик хүнсний тухай хууль
- Органик хүнснийг боловсруулах, үйлдвэрлэх, шошголох, худалдаалахад баримтлах арга зүйн удирдамж MNS CAC GL 32:2017.
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль. 2017.
- Тариалангийн тухай хууль
- Таримал ургамлын үр сортын тухай хууль
- Төрийн хяналт, шалгалтын тухай хууль
- Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоол.
- Ургамал хамгааллын тухай хууль

- Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн а/10 дугаар тушаал. Гадаад орны итгэмжлэлийн байгууллагаас итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагыг бүртгэх журам
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 84-р тушаал “Согтууруулах ундааны үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрлэлд хяналт тавих журам”
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2018 оны А-09 дугаар тушаал “Хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах журам”
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2018 оны А-09 дугаар тушаал “Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам”
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2018 оны А-09 дугаар тушаал “Харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах этгээдэд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журам”
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2018 оны А-09 дугаар тушаал “Органик хүнсний орцын найрлага тооцох аргачлал”
- Хүнсний аюулгүй байдал" үндэсний хөтөлбөр.
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль
- Хүнсний тухай хууль
- Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай. УИХ-ын 2022 оны 36 тогтоол.
- Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2022 оны 36 тогтоол.
- ХХААХҮЯ, Европын холбоо, UNDP, FAOMN, ILO. 2021. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн зарлагын шинжилгээ. Эх сурвалж: Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн” тайлан. 2021
- ХХААХҮЯ-наас УИХ-ын гишүүн Ч.Ундармын УИХ-03/7498 тоот албан бичигт ирүүлсэн хариу
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль.
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас МУ-ын УИХ-ын гишүүн Ч.Ундрамын 2022.08.05-ны өдрийн УИХ-03/7500 дугаартай албан бичигт ирүүлсэн хариунаас
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 8 сарын 17-ны өдрийн 01/986 тоот албан бичиг
- Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга. 2015 он

Гадаад орнуудын туршлага

- БНХАУ-ын “Органик бүтээгдэхүүн”-ий үндэсний стандарт (GB/T19630)
- БНХАУ-ын Органик бүтээгдэхүүний баталгаажуулалтыг хэрэгжүүлэх захиргааны арга хэмжээ/дүрэм/
- Органик баталгаажуулалт, итгэмжлэлийн дүрэм.2003

- K. DiMatteo, 'Case-Study-USA' in I. Källander and G. Rundgren (eds.), Building Sustainable Organic Sectors (IFOAM, 2008),
- Органик хүнс үйлдвэрлэлийн тухай хуулийн 2119а

Цахим эх сурвалж

- UNDP Монгол www.undp.org
- Блүүмберг ТВ. <https://bloombergtv.mn/tv-offer/>
- Мал эмнэлгийн хүрээлэн <http://www.ivm.mn/>
- Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн. <https://muls.edu.mn/>
- МҮОНРТ. <http://about.mnb.mn/c/55>
- МҮХАҮТ <https://www.mongolchamber.mn/p/24>
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар <http://home.inspection.gov.mn>
- Органик бүтээгдэхүүний бүртгэл мэдээллийн сан. <https://organic.gov.mn>
- Стандартын нэгдсэн сан <https://estandard.gov.mn>
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан <http://www.1212.mn>
- Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн <http://www.plantprotection.mn/>
- Ургамал, газар тариалангийн хүрээлэн <http://ipas.edu.mn/academics/dgs/>
- Үндэсний аудитын газар <https://open.audit.mn/>
- Хөдөө аж ахуйн эдийн засаг, инновацын хөгжлийн төв. <https://muls.edu.mn/>
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төв <http://rdc.gov.mn/>
- ХХААХҮЯ <https://mofa.gov.mn/>
- Шүүхийн шийдвэрийн цахим сан. <https://shuukh.mn/>
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан <https://legalinfo.mn/mn/detail/15626>
- Эс Эф Си Эс ХХК <http://sfcs.mn/attorney>

Гадаад эх сурвалж

- <https://www.chinesestandard.net/PDF/BOOK.aspx/GBT19630-2019>
- https://apps.fas.usda.gov/newgainapi/api/report/downloadreportbyfilename?filename=Revised%20Administrative%20Measures%20for%20Organic%20Product%20Certification%20_Beijing_China%20-%20Peoples%20Republic%20of_1-7-2014.pdf
- <http://extwprlegs1.fao.org/docs/pdf/chn65190.pdf>
- [https://www.ams.usda.gov/sites/default/files/media/Organic%20Foods%20Production%20Act%20of%201990%20\(OFPA\).pdf](https://www.ams.usda.gov/sites/default/files/media/Organic%20Foods%20Production%20Act%20of%201990%20(OFPA).pdf)